



СОЁЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР



СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТООЛЛОГО - 2022

ГАРЫН АВЛАГА





СОЁЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР



СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТООЛЛОГО-2022 ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар
2022 он



**ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ
ДУРСГАЛЫН ТООЛЛОГО-2022
ГАРЫН АВЛАГА**

Эмхэтгэсэн:	Г.Анхсанаа
Редактор:	Г.Энхбат
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:	Н.Сувд-Эрдэнэ
Цаасны хэмжээ:	145х210мм
Хэвлэлийн хуудас:	12.5 хх
Хэвлэсэн газар:	Пресс Лоорд ХХК
ISBN:	978-9919-27-544-0

ГАРЧИГ

Өмнөх үг	5
----------	---

I БҮЛЭГ. Хууль эрх зүй, баримт бичиг

Монгол улсын хууль - Соёлын тухай	10
Монгол улсын хууль - Соёлын өвийг хамгаалах тухай	41
Монгол улсын засгийн газрын тогтоол	
Журам батлах тухай	91
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам	92
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын ажил зохион байгуулах тухай	96
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын удирдамж	97
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх төлөвлөгөө	100
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын мэдээлэл цуглуулах маягт-2022	102

II бүлэг. Бүртгэн баримтжуулах аргачлал

II.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн танилцуулга (Г.Анхсанаа)	114
II.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байршил тогтоох (С.Баасандорж)	154
II.3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын гэрэл зураг авах (Б.Алтансүх)	163
II.4. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын мэдээлэл цуглуулах маягтыг бөглөх, үнэлгээ хийх (Б.Амгаланбат)	168
II.5. Тооллогын бүртгэлийн дэвтэр хөтлөх (Б.Бямбажаргал)	184



III БҮЛЭГ. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын тайлан бичих тухай

III.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын ажлыг
тайлагнах тухай (Б.Эрдэнэсүвд) 192

Хавсралт

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйл 201

Ашигласан ном бүтээл: 204

ӨМНӨХ ҮГ

2014 онд шинэчлэн батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуульд, соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтын байдал зэргийг шалгах зорилгоор соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулахаар зааж өгсөн билээ.

Хуулийн дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг 2015 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/108 тоот тушаалаар улс, орон даяар зохион байгуулсан бөгөөд тооллогод 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт (99.6%) 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамруулан зохион байгуулжээ. Тус тооллогын онцлог нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн ангилал хийж, дурсгалт газар, дурсгал гэсэн зарчмаар дугаарлаж, хадгалалт хамгаалалтын асуулга бүхий хээрийн бүртгэлийн маягт хөтлөн, газар зүйн байршлыг тогтоож, бүртгэлийн RICH 3.0 программ хангамж ашиглан үр дүнг нэгтгэсэн явдал юм. Энэхүү үр дүнд тулгуурлан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтын дагуу Засгийн газрын 2020 оны 13, 2021 оны 179 дүгээр тогтоолоор Улсын хамгаалалтад байх 197, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/161 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 597 дурсгалыг тус тус батлаад байна.

2020 онд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг зохион байгуулах байсан боловч дэлхий дахинд тархсан цар тахлын улмаас хоёр жил хойшлогдон 2022 онд зохион байгуулагдаж байна.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого 2022”-ын зорилго нь шинэчилсэн найруулгаар 2022 оноос эхэлж мөрдсөн Соёлын өвийг



хамгаалах тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-д заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх, бүрэн бүтэн байдлыг нягтлан шалгах, хадгалалт хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдалд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад оршино.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/10 дугаар тушаалаар Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг зохион байгуулах Улсын комиссын бүрэлдэхүүнийг, А/14 дүгээр тушаалаар удирдамж, ажлын төлөвлөгөө, хадгалалт хамгаалалтын мэдээлэл цуглуулах маягтыг тус тус баталсан болно.

Энэ удаагийн тооллогоор улс, аймаг, сум дүүргийн хамгаалалтад байх дурсгалууд болон 2015 онд тоологдсон болон түүнээс хойш RICH 3.0 программд нэмж бүртгэгдсэн дурсгалыг хамруулах бөгөөд дурсгалын үндсэн мэдээлэл бүхий тооллогын дэвтэр хөтлөх, дурсгалт газрын хадгалалт хамгаалалт, эвдрэл, гэмтлийн мэдээллийг “Хадгалалт хамгаалалтын мэдээлэл цуглуулах маягт-2022” ашиглан хээрийн судалгаагаар хийх, өмнөх бүртгэлийн алдааг засаж сайжруулах, дурсгал болон дурсгалт газар тус бүрд дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ба мэдээллийг тооллогын RICH 4.0 программ оруулж нэгтгэх ажил хийгдэнэ.

Энэхүү гарын авлага гурван бүлгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт хууль, эрх зүйн бичиг баримт болон 2022 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын удирдамж, төлөвлөгөөг багтаасан бол хоёрдугаар бүлэгт тооллого хийхэд баримтлах дурсгалын төрөл зүйл, тэдгээрийн байршлыг тогтоох, гэрэл зураг авах, мэдээлэл цуглуулах маягт, тооллогын дэвтэр хөтлөх зэргийг хамруулав. Гуравдугаар бүлэгт тооллогын тайлан бичих заавар, техник шаардлага зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын зохион байгуулалтын ажлаас эхлэн тайлагнах хүртэлх үе, шат бүрд шаардлагатай аргачлал, зааврыг багтаав.

Тооллогыг амжилттай зохион байгуулснаар шатны шатны соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан дахь өмнөх тооллогын бүртгэлийн мэдээллийн чанар, агуулга сайжрах ба дурсгалд сөрөг нөлөө үзүүлж буй байгаль, нийгмийн хүчин зүйлсийг олж тогтоон, цаашид учирч болох эрсдэл, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний санал, цаашид авах арга хэмжээг төлөвлөх мэдээллийн сан бий болно. Мөн дурсгалыг зүй зохистой ашиглах, соёлын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн эргэлтэд оруулах, залуу хойч үе, олон нийтийг соёлын өвийн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны баримт эх хэрэглэгдэхүүнээр хангагдах зэрэг олон талын ач холбогдолтой болно.







I БҮЛЭГ

ХҮҮЛЬ ЭРХ ЗҮЙ, БАРИМТ БИЧИГ





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 сарын 02 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

СОЁЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, соёлын үйл ажиллагаа эрхлэх, түүний удирдлага, зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг, эдийн засгийн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Соёлын хууль тогтоомж

2.1. Соёлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "соёлын үнэт зүйл" гэж түүхэн тодорхой орон зай, цаг

үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, эсхүл хүний оюун санаа, үйлдэхүйн үр дүнд бий болсон соёлын агуулга бүхий биет болон биет бус илэрхийллийг;

3.1.2. "соёлын байгууллага" гэж энэ хуульд заасан журмын дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;

3.1.3. "соёлын ажилтан" гэж соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хамт олон, бүлэг хүнийг;

3.1.4. "соёлын бүтээгдэхүүн" гэж соёлын үнэт зүйл, түүнтэй холбоотой үйлчилгээг агуулсан, эдийн засгийн нэмүү өртөг шингэсэн биет болон биет бус зүйлийг;

3.1.5. "соёлын үйлчилгээ" гэж арилжааны үнэ цэнээс үл хамааран, хүний соёлын хэрэгцээг хангах зорилгоор үзүүлж байгаа соёлын илэрхийллийг агуулсан үйлчилгээг;

3.1.6. "соёлын бүтээлч үйлдвэрлэл" гэж хүний бүтээлч сэтгэлгээ, авьяас билэг, ур чадварын үр дүнд техник технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл явцыг;

3.1.7. "уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлэг" гэж уран сайхны кино, теле жүжиг, телевизийн олон ангит кино, хөгжөөнт хөтөлбөр, тоглолт, баримтат болон хүүхэлдэйн кино, газар зүй, түүх, соёл, зан заншил, хэл зохиол, зан үйл, соёлын өвийг тайлбарлан таниулсан аливаа бүтээл ба сэтгүүл зүйн бусад төрлийн бүтээлийг;

3.1.8. "үндэсний нэвтрүүлэг" гэж телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа тухайн нэвтрүүлгийн зохиолч, ерөнхий найруулагч, продюсерын аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, сурвалжлах багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх бүх төрлийн бүтээлийг.

4 дүгээр зүйл. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого

4.1. Төрөөс соёлын талаар дараах бодлого хэрэгжүүлнэ:



- 4.1.1. соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;
- 4.1.2. эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил зэрэг үндэсний үнэт зүйлийг эрхэмлэн хөгжүүлэх, нандигнан өвлүүлэх замаар үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх;
- 4.1.3. соёлын илэрхийллийн олон төрөлд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, дэмжих;
- 4.1.4. соёлын үнэт зүйлийг судлах, өвлөх, уламжлуулах нөхцөл бүрдүүлэх замаар соёлын дархлаа бүхий монгол хүнийг төлөвшүүлэх;
- 4.1.5. соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих таатай орчныг бий болгох, эдийн засаг, нийгмийн хөгжилд соёлын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, соёлын байгууллагын бие даасан, санхүүгийн тогтвортой байдлыг хангах;
- 4.1.6. хувь хүний бүтээлч хөгжил, авьяас, ур чадварыг хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, соёлын боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, иргэнийг соён гэгээрүүлэх;
- 4.1.7. салбар хоорондын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, төр, хуулийн этгээд, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх;
- 4.1.8. соёлын үйл ажиллагаа, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлого болон бусад хэлбэрээр дэмжих;
- 4.1.9. соёлын үнэт зүйлийг олон улсад нээлттэй сурталчлан таниулах.

5 дугаар зүйл. Соёлын бодлого, үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим

5.1. Соёлын бодлого, үйл ажиллагаанд дараах үндсэн зарчим баримтална:

- 5.1.1. үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;

- 5.1.2. нэгдмэл цогц, харилцан уялдаатай, бүх нийтийн оролцоонд тулгуурласан байх;
- 5.1.3. төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах;
- 5.1.4. судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, дэвшилтэт техник технологи, инновацад тулгуурласан байх;
- 5.1.5. ил тод, нээлттэй байх;
- 5.1.6. тэгш, хүртээмжтэй байх;
- 5.1.7. соёлын үйл ажиллагааны чиглэл, хэлбэрийг хөндлөнгийн оролцоогүй, чөлөөтэй сонгох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ ЭРХЛЭХ

6 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагаа

6.1. Соёлын үйл ажиллагаа соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих, судлан шинжлэх, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанаас бүрдэнэ.

6.2. Соёлын үйл ажиллагаа бүх нийтийн оролцоонд тулгуурлана.

7 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагаанд оролцох, соёлын үйл ажиллагаа эрхлэх

7.1. Иргэн хуулиар хориглосноос бусад тохиолдолд соёлын үйлчилгээ, арга хэмжээнд чөлөөтэй оролцож, соёлын үйл ажиллагаа эрхэлнэ.

7.2. Соёлын байгууллагыг өмчийн аль ч хэлбэрт үндэслэн үүсгэн байгуулж болно.

7.3. Соёлын байгууллагыг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу байгуулна.

7.4. Соёлын байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээг үүсгэн байгуулагч тогтооно.

7.5. Олон улсын байгууллага Монгол Улсын хууль тогтоомжид



заасны дагуу салбар, төлөөлөгчийн газар байгуулсны үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт соёлын үйл ажиллагаа эрхэлнэ.

7.6. Соёлын байгууллагыг үйл ажиллагааны чадавх, нөхцөлийг нь харгалзан Үндэсний соёлын байгууллагаар тогтооно. Үндэсний соёлын байгууллагад тооцох шалгуур үзүүлэлт, холбогдох журмыг Засгийн газар батална.

7.7. Үндэсний соёлын байгууллага өөрийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр соёлын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшсэн байгууллага байна.

7.8. Үндэсний соёлын байгууллага Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу соёлын болон эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх бөгөөд дэргэдээ судалгааны нэгж, лаборатори ажиллуулж болно.

7.9. Гадаад улсад монголын соёлын төв байгуулах, Монгол Улсад гадаад улсын соёлын төв байгуулах асуудлыг Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэл

8.1. Байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн нүүдлийн соёл иргэншлийн онцлогийг хадгалсан орон зай, газар нутгийг тогтоох, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.2. Нүүдлийн соёл иргэншлийн дурсгалт газарт уламжлалт ахуйг хамгаалах тааламжтай нөхцөлийг бүрдүүлж, хуульд зааснаас бусад дэглэмийг тогтоох, уламжлалт ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

8.3. Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүний алдар, дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандаж, хамгаалах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

8.4. Үндэсний өв уламжлал, гэр бүлийн соёл, хүмүүжлийн зан заншлыг эрхэмлэн, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх арга хэмжээг орон даяар зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

8.5. Монголын соёлын давтагдашгүй хэв шинж, уламжлалт мэдлэг, сэтгэлгээний илэрхийлэл болсон соёлын өвийг хамгаалж, баталгаажуулна.

8.6. Хүүхэд, залуучуудын авьяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг урамшуулж, соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжинэ.

8.7. Соёлын үнэт зүйлийг устах эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, сэргээх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагааны чиглэл

9.1. Соёлын үйл ажиллагааг дараах чиглэлээр явуулна:

9.1.1. соёлын өвийг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа;

9.1.2. музейн үйл ажиллагаа;

9.1.3. номын сангийн үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.4. ном, утга зохиолын бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.5. хөгжмийн урлагийн бүтээл туурвих, үйлдвэрлэх, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.6. тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.7. дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг, гар урлал, хэрэглээний урлагийн бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.8. кино урлаг, дуу-дүрсний уран бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

9.1.9. интернэт орчин, тоон технологид суурилсан соёлын агуулга, харилцаа бүхий цахим уран бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;



9.1.10. дизайн, архитектурын бүтээл туурвихтай холбоотой үйл ажиллагаа;

9.1.11. соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, наадам зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаа;

9.1.12. соёлын боловсрол олгохтой холбоотой үйл ажиллагаа;

9.1.13. соёл судлалын үйл ажиллагаа.

9.2. Соёлын өвийг хамгаалахтай холбогдсон харилцааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9.3. Музейн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Музейн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9.4. Номын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Номын сангийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9.5. Кино урлагтай холбогдсон харилцааг Кино урлагийг дэмжих тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

10 дугаар зүйл. Соёл судлалын үйл ажиллагаа

10.1. Соёл судлалын үйл ажиллагаа нь соёлын үнэт зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр танин мэдэх, хадгалж хамгаалах, бүтээн туурвих, судалгааны үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдэнэ.

10.2. Төрөөс соёл судлалын үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлнэ.

10.3. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, арга хэмжээ нь соёл судлалын үйл ажиллагааны үр дүнд үндэслэнэ.

10.4. Соёлын салбарын хөгжлийн стратеги, төлөвлөлт, бодлогын суурь судалгаа хийх, судалгааны мэдээллээр хангах байгууллагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллуулна.

11 дүгээр зүйл. Соёлын боловсрол олгох үйл ажиллагаа

11.1. Соёлын боловсрол хүнийг соён гэгээрүүлэх, авьяас, ур чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, эх оронч сэтгэлгээг

төлөвшүүлэх, үндэсний соёлын үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх, хүндэтгэх, хамгаалах дадал, чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

11.2. Хүүхэд өөрийн хүсэл, сонирхолд нийцсэн соёлын боловсрол эзэмших эрхтэй ба эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн хүсэл, сонирхолд нийцүүлж соёлын боловсрол олгох үүрэгтэй.

11.3. Соёлын боловсрол олгох үйл ажиллагааг боловсролын албан болон албан бус хэлбэрээр дамжуулж олгох зарчмыг баримтална.

11.4. Соёлын боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг Засгийн газар батлах бөгөөд уг арга хэмжээ, төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

11.4.1. иргэний соёлын боловсролыг дээшлүүлэх;

11.4.2. соёлын боловсрол олгох багшийг мэргэшүүлэх;

11.4.3. соёлын ажилтныг мэргэжил эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх;

11.4.4. соёлын боловсролын судалгаа, шинжилгээ явуулах;

11.4.5. соёлын боловсрол олгох сургалтын хөтөлбөр, агуулгыг тодорхойлох;

11.4.6. соёлын боловсрол олгох сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих;

11.4.7. соёлын боловсрол олгох төрийн өмчийн сургалтын байгууллагын барилга байгууламж, түүний ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээ, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх;

11.4.8. соёлын боловсролыг дэмжих бусад асуудал.

11.5. Боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн заавал судлах уран бүтээлийн жагсаалт, түүнийг судлахтай холбогдсон журмыг боловсролын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

11.6. Соёлын байгууллага өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд соёлын боловсрол олгох хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.



11.7. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг сургалтын хөтөлбөр, агуулгад нь тусгагдсан соёлын боловсрол олгохтой холбоотой сургалтын орчин, техник, тоног төхөөрөмж, хүний нөөц, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг төрөөс авна.

12 дугаар зүйл. Соёлын үнэт зүйлийн бүртгэл

12.1. Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

12.2. Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.3. Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан соёлын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төрөлжсөн мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд төрөлжсөн мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбогдох хууль болон энэ хуулийн 12.2-т заасан журмаар зохицуулна.

12.4. Гадаад улсад байгаа монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийг үндэсний бүртгэл, мэдээллийн санд бүртгэж болно.

13 дугаар зүйл. Соёлын үнэт зүйлийн үнэлгээ

13.1. Соёлын үнэт зүйлийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан журмын дагуу үнэлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ИРГЭН, СОЁЛЫН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

14 дүгээр зүйл. Соёлын талаарх иргэний эрх, үүрэг

14.1. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн соёлын талаар дараах эрх эдэлнэ:

14.1.1. авьяас, ур чадвар, уламжлалт мэдлэг, итгэл үнэмшилдээ

тулгуурлан амьдралын хэв маяг, соёлын үйл ажиллагааны чиглэлийг чөлөөтэй сонгох;

14.1.2. соёлын үнэт зүйлтэй танилцах, хүн төрөлхтний болон үндэсний соёл иргэншлийн ололт, соёлын үйл ажиллагааны үр шимийг хүртэх;

14.1.3. уран бүтээлийн сэдэв, төрөл зүйл, арга барил, дэг сургууль, урсгал чиглэлийг чөлөөтэй сонгож, бүтээл туурвих, үр чадварынхаа нууцыг хамгаалуулах;

14.1.4. соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих, соёлын үйл ажиллагаа эрхлэх, тэдгээрийн үр шимийг хүртэх;

14.1.5. Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомжоор хориглосноос бусад соёлын үйл ажиллагааг гадаад улсад явуулах, түүнд оролцох;

14.1.6. эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг өвлөн хөгжүүлэх;

14.1.7. соёлын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтарч ажиллах;

14.1.8. соёлын үйл ажиллагаа эрхлэх, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор төрийн бус байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх.

14.2. Монгол Улсын иргэн соёлын талаар дараах үүрэг хүлээнэ:

14.2.1. эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэх;

14.2.2. соёлын илэрхийллийн олон төрлийг хүндэтгэх, соёлын үнэт зүйлийг хамгаалах;

14.2.3. гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх;

14.2.4. соёлын үнэт зүйлийг хууль бус халдлагаас хамгаалах.

14.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 14.2.2, 14.2.4-т заасан үүрэг хүлээнэ.



15 дугаар зүйл. Соёлын ажилтны эрх, үүрэг

15.1. Соёлын ажилтан дараах эрх эдэлнэ:

- 15.1.1. хууль тогтоомжийн хүрээнд соёлын үйл ажиллагаа эрхлэх нөхцөл, бололцоогоор хангуулах;
- 15.1.2. төрийн болон төрийн бус байгууллага, түүний удирдлага, иргэнд эрхэлж байгаа соёлын үйл ажиллагааны чиглэлийн асуудлаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шаардлага тавих;
- 15.1.3. соёл, урлагийн наадам, уралдаан, тэмцээнд оролцох;
- 15.1.4. мэргэжлийн төрийн бус байгууллагад гишүүнээр элсэх;
- 15.1.5. уран бүтээлээ бодитойгоор үнэлүүлж, тохирсон шагнал, урамшуулал хүртэх, хөнгөлөлт эдлэх;
- 15.1.6. мэдлэг боловсрол, ур чадвараа бие даан болон байгууллагын дэмжлэгтэйгээр дээшлүүлэх, давтан сургалтад хамрагдах;
- 15.1.7. уран бүтээл туурвихдаа архив, номын сангийн үйлчилгээг чөлөөтэй авах;
- 15.1.8. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангуулах, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх;
- 15.1.9. оюуны өмч, зохиогчийн эрхээ хамгаалах, эрх бүхий байгууллагын дэмжлэг, туслалцаа авах.

15.2. Соёлын ажилтан дараах үүрэг хүлээнэ:

- 15.2.1. мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх;
- 15.2.2. эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэхэд идэвх санаачилгатай ажиллах;
- 15.2.3. оролцож байгаа соёлын арга хэмжээний журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 15.2.4. эрхэлж байгаа чиглэлийн хүрээнд соёлын үйлчилгээ хүргэх, иргэнийг соён гэгээрүүлэх, соёлын боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах;
- 15.2.5. эрдэм шинжилгээний ажил эрхлэх;

- 15.2.6. соёлын үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх;
- 15.2.7. соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэхэд аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

16 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаарх аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо

16.1. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаар аж ахуйн нэгж, байгууллага дараах хэлбэрээр оролцоотой байна:

- 16.1.1. соёлын илэрхийллийн олон төрлийг хүндэтгэх, соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах;
- 16.1.2. ажиллагсдын урлаг, уран сайхны мэдрэмж, авьяас, ур чадварыг хөгжүүлэх, соёлын боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах, шаардагдах хөрөнгийг жил бүр төсөв, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;
- 16.1.3. ажиллагсдын оюуны болон соёлын хэрэгцээг хангах зорилгоор соёлын үйлчилгээ явуулах, соёлын үйл ажиллагаа эрхлэх нэгж байгуулж, ажиллуулах;
- 16.1.4. соёлын үйл ажиллагаанд тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт хийх, хандив өгөх;
- 16.1.5. үйлдвэрлэл, үйлчилгээний соёл, гоо зүй, дизайн бүхий орчныг бүрдүүлж, хөгжүүлэх.

16.2. Аж ахуйн нэгж, байгууллага тухайн орон нутгийн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг тэргүүн ээлжид худалдан авах зарчмыг баримтална.

17 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаарх төрийн бус байгууллагын оролцоо

17.1. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаар мэргэжлийн төрийн бус байгууллага дараах үйл ажиллагааг явуулж болно:

- 17.1.1. соёлын хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;



17.1.2. соёлын илэрхийллийн олон төрөл, үндэсний соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

17.1.3. соёлын боловсрол олгох ажлыг дангаар болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах.

17.2. Соёлын үнэт зүйлийг ашиглах, хамгаалах онцгой эрхийг хэрэгжүүлэх зорилго бүхий ашгийн төлөө бус хамтын удирдлагын байгууллагын саналыг салбарын хууль тогтоомж боловсруулахад харгалзан үзэж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж болно.

18 дугаар зүйл. Соёлын байгууллагын эрх, үүрэг, удирдлага

18.1. Соёлын байгууллага дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

18.1.1. хуулиар хориглосноос бусад үйл ажиллагааны чиглэл, төрлийг чөлөөтэй сонгох, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх;

18.1.2. дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдах, бусад байгууллагатай мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах;

18.1.3. соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний стандарт хангасан түвшинд явуулах;

18.1.4. төсөв, төсөл болон хандивын хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

18.1.5. соёлын ажилтны ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг нь хангах;

18.1.6. зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, соёлын ажилтны хөдөлмөрийн онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байх;

18.1.7. соёлын үйл ажиллагааны стандартыг мөрдөн ажиллах;

18.1.8. үйл ажиллагааны чиглэл, статистик мэдээллийг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх.

18.2. Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг аймаг,

нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

18.3. Төрийн өмчийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүргийн соёлын байгууллагын удирдлагыг аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагатай зөвшилцөн сум, дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.

18.4. Энэ хуулийн 18.3-т зааснаас бусад соёлын байгууллагын удирдлагыг үүсгэн байгуулагч нь томилж, чөлөөлнө.

18.5. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь мэргэжлийн холбоод, иргэний төлөөллийг оролцуулсан олон нийтийн зөвлөлтэй байж болно. Олон нийтийн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮРЭН ЭРХ

19 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо

19.1. Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

20 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

20.1. Монгол Улсын Засгийн газар соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1. соёлын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;



20.1.2. соёлын төлөв байдлын тайланг хоёр жил тутам Улсын Их Хуралд танилцуулах;

20.1.3. соёлын цогцолбор байгуулж хөгжүүлэх, үйл ажиллагааг нь зохион байгуулах;

20.1.4. хүүхдийн соёл, урлагийн цогцолбор байгуулах, хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих;

20.1.5. соёлын үйл ажиллагааны чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээ, төлөвлөгөөг батлах;

20.1.6. үндэсний бахархлыг тодорхойлох, тогтоох;

20.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.

21 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

21.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1. соёлын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

21.1.2. хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд соёлын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлэх;

21.1.3. соёлын үйл ажиллагааны чиглэлээр захиалгат судалгаа, шинжилгээ хийх, инновац нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21.1.4. соёлын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, үйлчилгээний орчны шаардлагыг боловсруулж, батлуулах;

21.1.5. соёлын байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

21.1.6. төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын оновчтой тогтолцоо, бүтцийг бий болгож ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах;

21.1.7. соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

21.1.8. соёлын салбарт хүний нөөц бэлтгэх, соёлын байгууллагыг мэргэжлийн ажиллах хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэх;

21.1.9. соёлын ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

21.1.10. соёл судлалын үйл ажиллагааг дэмжих;

21.1.11. соёлын боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах;

21.1.12. хуульд заасан бусад бүрэн эрх.

22 дугаар зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

22.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1. соёлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

22.1.2. дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох арга хэмжээг авах;

22.1.3. соёлын статистик мэдээллийг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийх;

22.1.4. соёлын үнэт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;

22.1.5. түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах болон дотоод, гадаадад үзэсгэлэн гаргахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих;

22.1.6. соёлын салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

22.1.7. соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

22.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.



23 дугаар зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

23.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

23.1.1. харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд соёлын боловсрол олгох, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр баталж, хэрэгжилтийг хангуулах;

23.1.2. тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, хөгжлийн хэтийн төлөв байдлыг тодорхойлж, хяналт тавих;

23.1.3. уран бүтээл туурвихад бүх талын дэмжлэг үзүүлэх.

24 дүгээр зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

/Энэ зүйлийн гарчигт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

24.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

24.1.1. орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, брэнд бий болгох, баяжуулан хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

24.1.2. орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах.

25 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн соёлын газар, сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны чиг үүрэг

25.1. Аймаг, нийслэлийн соёлын газар соёлын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.1.1. соёлын хууль тогтоомжийн дагуу соёл, урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

25.1.2. соёлын байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу төрөөс санхүүжүүлэх, тэдгээрт дэмжлэг, тусалцаа үзүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах;

25.1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

25.1.4. харьяалах нутаг дэвсгэрийн соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;

25.1.5. соёлын статистик мэдээлэл, соёлын байгууллагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх.

25.2. Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна.

25.3. Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааны жишиг дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.4. Энэ хуулийн 25.2-т заасан байгууллага үйл ажиллагаагаа дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, олон нийтийн төлөөлөлтэй хамтран явуулна.



ТАВДУГААР БҮЛЭГ

СОЁЛЫН САЛБАРЫН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

26 дугаар зүйл. Соёлын салбарын түншлэл

26.1. Соёлын салбарын түншлэл нь соёлын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүх хэлбэрийг хангасан байх ба оюуны бүтээлч үйл ажиллагаа, санхүү, шинжлэх ухаан, технологийн болон хүний нөөцийг багтаасан, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэний үр ашигтай, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ.

26.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын салбарын бүтээн байгуулалтад болон нийгмийн ач холбогдол бүхий, эсхүл хувийн хэвшил дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулахыг төрөөс дэмжинэ.

26.3. Энэ хуулийн 26.2-т заасан төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Засгийн газар батална.

26.4. Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд уг байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт болон холбогдох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа

27.1. Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ:

27.1.1. монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах;

27.1.2. монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах;

27.1.3. хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах;

27.1.4. монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах;

27.1.5. соёлын биет өвийг сэргээн засварлах;

27.1.6. уран бүтээл хамтран бүтээх, солилцох;

27.1.7. соёлын ажилтныг сургах, мэргэшүүлэх;

27.1.8. соёлын үйл ажиллагаанд шинэ техник технологи, инновац, тоног төхөөрөмж нэвтрүүлэх;

27.1.9. соёлын боловсрол олгох сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөрийг харилцан солилцох.

27.2. Төрийн холбогдох байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн 27.1-д заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхэлнэ.

28 дугаар зүйл. Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнийг соёлын үйл ажиллагаанд оролцуулах

28.1. Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын үнэт зүйлийг таниулахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг гадаад харилцаа, санхүү, төсвийн болон соёл, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.

28.2. Олон улсад танигдсан, гадаад улсад соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг эх орондоо соёлын үйл ажиллагаа эрхлэх, хамтарч уран бүтээл туурвихад төрийн болон төрийн бус байгууллага, соёлын байгууллага дэмжиж ажиллана.

28.3. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд гадаад улсад соёлын үйл ажиллагаа эрхлэхэд төрийн холбогдох байгууллага зохион байгуулалт, санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлж болно.

29 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагааг олон улсад сурталчлахад иргэнийг оролцуулах

29.1. Монгол Улсын соёлын үнэт зүйл, соёлын үйл ажиллагааг сурталчлах, олон улсын дэмжлэгийг татах зорилгоор урлаг, спорт, шинжлэх ухааны болон бусад салбарын нэр хүндтэй, олон улсад



хүлээн зөвшөөрөгдсөн иргэнийг хоёр жилийн хугацаатайгаар соёлын элчээр томилон ажиллуулж болно.

29.2. Соёлын элчийн ажиллах журмыг Засгийн газар батална.

30 дугаар зүйл. Соёлын орчин, орон зайг хөгжүүлэх

30.1. Аймаг, сум, нийслэл, дүүрэгт түүх, соёл, урлаг, эсхүл соёлын үнэт зүйлийг төлөөлж, илэрхийлэх соёлын орчин, орон зайг бүрдүүлж, хөгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

30.2. Энэ хуулийн 30.1-д заасан соёлын орчин, орон зайг бүрдүүлэх, хөгжүүлэх чиг үүргийг Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлнэ. Иргэн, хуулийн этгээд соёлын орчин, орон зайг бий болгох, санал санаачилгыг гаргаж, тухайн шатны Засаг даргад уламжлан шийдвэрлүүлнэ.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

30.3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн онцлог бүхий соёлын орчин, орон зайг тодорхойлж, хот, суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, батална.

30.4. Түүх, урлаг, уран сайхны үнэт ач холбогдолтой, эсхүл өвөрмөц хийцтэй, үндэсний хэв загварыг хадгалсан салангид буюу цогцолбор барилга байгууламж, түүний тодорхой хэсэг, хөшөө, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээлийг хадгалж, хамгаална.

30.5. Энэ хуулийн 30.4-т заасан барилга байгууламж, хөшөө, урлагийн бүтээлийн жагсаалтыг Засаг даргын санал, эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЛЭЛ

31 дүгээр зүйл. Өмч

31.1. Соёлын байгууллагын өмчтэй холбогдсон харилцааг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

31.2. Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.

32 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагааны санхүүжилт

32.1. Соёлын үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо нь иргэнд тэгш, хүртээмжтэй, чанартай соёлын үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ.

32.2. Соёлын үйл ажиллагааны төсөв нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын хандив, соёлын байгууллагын төлбөртэй үйлчилгээ, дотоод, гадаадад зохион байгуулсан соёл, урлагийн арга хэмжээнээс олсон орлого, өөрийн үйл ажиллагааны орлого, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

32.3. Соёлын үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт бие даасан хөтөлбөр болгож батална.

32.4. Төрийн өмчит соёлын байгууллагын улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг өөрийн үйл ажиллагааны орлого болон байгууллага, иргэний хандивын хэмжээгээр багасгаж төлөвлөх, соёлын үйл ажиллагаанд зориулсан төсвийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

32.5. Төрийн өмчийн соёлын байгууллагаас бусад ашгийн төлөө бус соёлын байгууллагад тодорхой төслийг үндэслэн төрөөс санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.



32.6. Соёлын үйл ажиллагааг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор иргэн, хуулийн этгээдээс оруулсан хандив, хөрөнгө оруулалтад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх журмыг холбогдох хуулиар тогтооно.

32.7. Хөгжим, дүрслэх урлаг, утга зохиолын шилдэг бүтээлийг улсын санд худалдан авна. Шилдэг бүтээл шалгаруулах, худалдан авах, хадгалах, ашиглах журмыг Засгийн газар батална.

32.8. Үндэсний болон сонгодог урлагийн бүтээл, хүүхдэд зориулсан уран бүтээлд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

32.9. Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

32.10. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага соёлын үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг ивээн тэтгэж болно.

32.11. Нийтийн ашиг тусын тулд чиглэсэн соёлын үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах дотоодод үйлдвэрлэдэггүй тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, түүхий эд материал, урвалж бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд татвараас хөнгөлж, чөлөөлнө.

32.12. Соёлын арга хэмжээний шагналын орлогыг татвараас чөлөөлнө.

32.13. Энэ хуулийн 32.11, 32.12-т заасан татвараас хөнгөлж, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

33 дугаар зүйл. Соёлын ажилтны үнэлэмж, нийгмийн баталгаа

33.1. Соёлын салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө, арга хэмжээг Засгийн газар батална.

33.2. Соёлын ажилтан соёлын үйл ажиллагаа эрхлэн, үүсгэн байгуулагчаас тогтоосон цалин, нэмэгдэл хөлс авна.

33.3. Соёлын ажилтанд мэргэшлийн зэрэг, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

33.4. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох хөрөнгийг үүсгэн байгуулагч өөрийн байгууллагын төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

33.5. Соёлын ажилтан хөдөлмөрийн шинж чанар, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, нөхөх олговор, шагнал урамшуулал авч, хуульд заасан бусад хөнгөлөлт эдэлнэ.

33.6. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын ажилтны нэмэгдэл хөлс, нийгмийн баталгааг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар зохицуулна.

33.7. Энэ хуулийн 33.6-д зааснаас бусад соёлын байгууллагын ажилтны нийгмийн баталгааг үүсгэн байгуулагч хариуцна.

33.8. Соёлын ажилтан ажлын онцлогоос хамаарч мэргэжлийн хөдөлмөрийн чадвараа эрт алдсан тохиолдолд түүний хүсэлтийг нь үндэслэн дотоодын их, дээд сургууль, урт, дунд, богино хугацааны тусгай мэргэжил эзэмших сургалтын зардлыг төр хариуцна.

33.9. Тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд 5 жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгоно.

34 дүгээр зүйл. Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээ

34.1. Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг Засгийн газар батална.

34.2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тогтооход дэвшилтэт технологи, инновацад суурилсан үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортлоход чиглүүлэх, нөөцийг оновчтой байршуулах, төрийн дэмжлэгийн үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтална.



34.3. Төрөөс соёлын бүтээлч үйлдвэрлэлд дараах дэмжлэг үзүүлнэ:

34.3.1. соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх;

34.3.2. соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт төвлөрүүлэх, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох;

34.3.3. инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

34.3.4. соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

34.3.5. соёлын арга хэмжээ, соёлын бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх, хуваарилах арга хэлбэрийг сайжруулж, хүртээмжтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

34.4. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг Засгийн газар батална.

34.5. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага Төсвийн тухай хуульд нийцүүлэн худалдаа, үйлчилгээ эрхэлж болно.

35 дугаар зүйл. Мерчандайзийн гэрээ

35.1. Иргэний хуулийн 338¹ дүгээр зүйлийн дагуу мерчандайзийн гэрээгээр өмчлөгч, түүний зөвшөөрснөөр эзэмшигч соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь үйл ажиллагаа явуулж, эзэмшигчид борлуулалтын орлогоос соёлын үнэт зүйл ашигласны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

35.2. Мерчандайз нь зохиогчийн эрх, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загварын эрхээр хамгаалагдана.

35.3. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг олгоно:

35.3.1. төрийн өмчийн соёлын байгууллагын эзэмшиж байгаа соёлын үнэт зүйл, урлагийн бүтээл, соёлын биет өв;

35.3.2. төрийн өмчийн музейд хадгалагдаж байгаа үзмэр;

35.3.3. түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

35.4. Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад орон нутгийн өмчийн соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн шатны Засаг дарга олгоно.

35.5. Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад төрийн өмчийн байгууллагын эзэмшиж байгаа соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

35.6. Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг Иргэний хуулийн дагуу бичгээр байгуулж, дараах зүйлийг тусгана:

35.6.1. мерчандайзийн зүйлийн хэмжээ, загвар, өнгө, материалын дэлгэрэнгүй тодорхойлолт;

35.6.2. мерчандайзийн гэрээний дагуу үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээ;

35.6.3. үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулагч, борлуулах цэгийн мэдээлэл;

35.6.4. мерчандайзийн зүйлийг үйлдвэрлэх, борлуулахад шаардлагатай санхүүжилтийн хэлбэр, нөхцөл;

35.6.5. мерчандайзийн зүйлийг гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, борлуулах болон чанарын баталгаа;

35.6.6. загвар ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөл;

35.6.7. мерчандайзийн гэрээний хугацааг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, мерчандайзийн гэрээ ба холбогдох бусад гэрээ хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол, гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх журам;

35.6.8. талууд харилцан тохиролцсон бусад зүйл.



36 дугаар зүйл. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр, хөнгөлөлт

36.1. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийн хэмжээг үүсгэн байгуулагчтай зөвшилцсөний үндсэн дээр тогтооно.

36.2. Энэ хуулийн 36.1-д зааснаас бусад соёлын байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг өөрөө бие дааж тогтооно.

36.3. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь хүүхэд, өндөр настан, хугацаат цэргийн алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй хүний соёлын үйл ажиллагаанд оролцох сонирхлыг нь дэмжих бөгөөд төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ЗӨВШӨӨРӨЛ, ХЯНАЛТ, ХЯЗГААРЛАЛТ

37 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага

37.1. Соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн эрхэлнэ.

37.2. Соёлын байгууллагын үйлчилгээний болон барилга байгууламж, орчны стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ.

37.3. Соёлын үйлчилгээ эрхлэх барилга байгууламж, танхим, талбай нь стандарт, эрүүл ахуйн болон хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байна.

37.4. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын үйлчилгээ үзүүлэх барилга байгууламж, талбайн зориулалтыг өөрчлөхийг хориглоно. Хувьчлах болон тухайн барилга байгууламж, талбайг буулгаж, шинээр барих тохиолдолд зориулалтыг хэвээр хадгална.

37.5. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагаа эрхлэх зориулалт бүхий хувийн өмчийн барилга байгууламжийг ашиглан иргэнд соёлын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж болно.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

37.6. Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37.7. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг хуулиар хориглосноос бусад нөхцөлд хүн бүрд нээлттэй байлгаж, соёлын үнэт зүйлтэй танилцах боломжоор хангана.

37.8. Соёлын байгууллага үйл ажиллагаа, үйлчилгээний жагсаалт, нөхцөлийг нэгдсэн журмаар тогтоож, иргэний мэдээлэл авах боломжийг бүрэн хангасан байна.

37.9. Соёлын байгууллагын үйлчилгээг зөөврийн болон нүүдлийн хэлбэрээр хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил соёлын үйлчилгээ авахад зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авна.

38 дугаар зүйл. Зөвшөөрөл

38.1. Соёлын зуучлал нь соёлын үнэт зүйлийн болон соёлын ажилтны зуучлалын хэлбэртэй байна.

38.2. Соёлын үнэт зүйлийн зуучлалыг Иргэний хууль, Оюуны өмчийн тухай хуульд заасны дагуу эрхэлнэ.

38.3. Соёлын ажилтныг олон улсын түвшинд соёлын үйл ажиллагаанд оролцуулах, санал болгох, түүний ашиг сонирхлыг төлөөлөн хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, менежментийн үүрэг гүйцэтгэх соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагааг зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд эрхэлнэ.



38.4. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох бөгөөд холбогдох журмыг батална.

38.5. Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь зөвшөөрлийн холбогдох хуульд заасан баримт бичгээс гадна зөвшөөрөл хүсэгч иргэний, хуулийн этгээд бол удирдах, шийдвэр гаргах, соёлын ажилтантай шууд харилцан ажиллах иргэний хууль, эрх зүй, эдийн засаг, менежментийн талаарх мэдлэгийг нотлох баримт бичиг, эдийн засаг, хүний эрүүл мэнд, хүч хэрэглэсэн гэмт хэрэгт холбогдож байгаагүй талаарх тодорхойлолтыг өргөдөлд хавсаргана.

38.6. Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь ажилтан тус бүртэй бичгээр гэрээ байгуулна.

38.7. Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, менежер өөрчлөгдөхөд зөвшөөрөл олгогч байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

38.8. Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь уран бүтээлчийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц нөхцөлд ажиллуулахаар явуулахгүй байх бөгөөд зуучлан ажиллуулах газрыг урьдчилан судалсан байна.

38.9. Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь хүүхдийг согтууруулах ундаа борлуулах, худалдах, гтүүгээр үйлчлэх орчинд ажиллуулахаар явуулахыг хориглоно.

38.10. Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22¹.1.6-д заасны дагуу хураамж төлнө.

39 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагаанд тавих хяналт, хязгаарлалт

39.1. Соёлын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллага, соёлын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

39.2. Аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллагад соёлын хяналтын улсын байцаагч ажиллана.

39.3. Хууль тогтоомжоор хориглоогүй соёлын үйл ажиллагаа эрхлэхэд төрийн болон бусад байгууллага, улс төрийн нам, эвсэл, холбоо, тэдгээрийн албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

39.4. Угсаатны соёлын үнэт зүйлийн өвөрмөц илэрхийллийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.

39.5. Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй болон дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах соёлын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

39.6. Уран бүтээлчийн анхдагч санаа, ур чадварын нууцыг түүний зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно.

39.7. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн 70 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

39.8. Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

39.9. Театр, үзвэрийн цэгээр сар тутам түгээх кинонд үндэсний киноны эзлэх хувь, интернэт протоколд суурилсан телевиз (Ай-Пи телевиз)-ийн уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн видео санд байршсан нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байна.

39.10. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс нь зөвшөөрөл аваагүй, холбогдох даатгалд даатгуулаагүй тохиолдолд соёлын гадаад үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүнийг оролцуулахыг хориглоно.



39.11. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хөшөө дурсгалын цогцолбор байгуулах, соёлын байгууллага байгуулах, соёлын үнэт зүйлийг тогтоож хамгаалалтад авах тухай шийдвэр гаргахад соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн холбоодын саналыг авна.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

40 дүгээр зүйл. Соёлын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

40.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

41 дүгээр зүйл зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

40.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

41.1. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:



3.1.1. “соёлын өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;

3.1.2. “соёлын биет өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;

3.1.3. “түүх, соёлын үл хөдлөх дурсгал” гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дурсгалыг;

/Энэ заалтад “илэрхийлэгдэх” гэсний дараа “дангаар болон цогцолбор байдлаар орших” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

3.1.4. “түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл” гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг;

3.1.5. “соёлын биет бус өв” гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг;

3.1.6. “соёлын өвийн дурсгалт газар” гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг;

3.1.7. “түүх, соёлын дурсгалт газар” гэж энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлийг;

3.1.8. “соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч” гэж соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн, түүнийгээ олны хүртээл болгож, дараагийн үедээ өвлүүлэн уламжлуулж байгаа хамт олон, бүлэг, хувь хүнийг;

3.1.9. “шавь сургалт” гэж соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаас тодорхой мэдлэг, арга ухаан, ур чадварыг шавьдаа биечлэн заан сургаж, эзэмшүүлдэг сургалтын арга барилыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

4 дүгээр зүйл. Соёлын өвийн ангилал

4.1. Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна.

4.2. Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.

4.3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь дангаар болон цогцолбор байдлаар оршино.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

5 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал

5.1. Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:

5.1.1. эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;

/Энэ заалтаас “чулуужсан” гэснийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

5.1.2. эртний хүний оршин сууж байсан үл мөрийг хадгалсан соёлт давхарга;

5.1.3. чулуун зэвсгийн олдворт газар;

5.1.4. хадны зураг, бичээс;

5.1.5. булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;

5.1.6. эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;

/Энэ заалтад “үлдэгдэл,” гэсний дараа “түүхэн дурсгалт барилга” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

5.1.7. хөшөө дурсгал;

5.1.8. эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж



үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;

5.1.9. тахилгат газар;

5.1.10. түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;

5.1.11. бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

6 дугаар зүйл. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл

6.1. Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна:

6.1.1. ховор эрдэс;

6.1.2. эрдэнийн чулууны ховор олдвор;

6.1.3. солир;

6.1.4. ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл;

6.1.5. эртний ургамал, амьтны олдвор;

6.1.6. археологийн олдвор;

6.1.7. угсаатны хувцас, чимэглэл;

6.1.8. уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг;

6.1.9. угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл;

6.1.10. уламжлалт тоглоом, наадгай;

6.1.11. уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл;

6.1.12. бичгийн дурсгалт зүйл;

6.1.13. дүрс, дуу авианы баримт;

6.1.14. дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл, холбогдох эд өлгийн зүйл;

6.1.15. уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.16. гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.17. бусад түүх, соёлын дурсгалт зүйл.

/Энэ заалтад “соёлын” гэсний дараа “хөдлөх” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

6.2. Энэ хуулийн 5.1.1, 6.1.1-6.1.3-т зааснаас бусад байгалийн өвийг хамгаалах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

/Энэ заалтад “холбогдох” гэсний дараа “бусад” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7 дугаар зүйл. Соёлын биет бус өв

7.1. Дараах соёлын өвийг соёлын биет бус өвд хамааруулна:

7.1.1. эх хэл, бичиг, түүний хүрээний соёл;

7.1.2. аман зохиолын уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэр;

7.1.3. урлагийн тоглох үзүүлбэр;

7.1.4. үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил;

7.1.5. уламжлалт гар урлалын дэг сургууль, арга барил;

7.1.6. ардын ёс заншил, зан үйл;

7.1.7. ардын уламжлалт мэдлэг, арга ухаан;

7.1.8. ардын бэлгэдэх ёсны уламжлал;

7.1.9. үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл;

7.1.10. ардын уламжлалт технологи;

7.1.11. угийн бичиг хөтлөх уламжлал;

7.1.12. гэрийн дэг сургуулийн шилдэг өв уламжлал;

7.1.13. уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл, ёс заншил;

7.1.14. газар, усны уламжлалт нэр;

7.1.15. бусад соёлын биет бус өв.



8 дугаар зүйл. Соёлын өвийн зэрэглэл

8.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалтын түвшингээр нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалттай гэж зэрэглэнэ.

8.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтын зэрэглэл тогтооно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

8.2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээс энэ хуулийн 8.3-т заасан шалгуурын дагуу хосгүй үнэт, үнэт гэж зэрэглэл тогтооно.

8.2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан үнэт, хосгүй үнэт зэрэглэл тогтооно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

8.3. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлийг дараах шалгуураар тогтооно:

8.3.1. түүх, соёл, урлаг, гоо зүй, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол;

8.3.2. холбогдох цаг үе;

8.3.3. дахин давтагдашгүй байдал;

8.3.4. ур хийц, дэг сургууль;

8.3.5. үнэт металлын орц, эрдэнийн чулууны хэмжээ.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

8.4. Соёлын биет бус өвийг төлөөллийн үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэж хамгаална.

8.4. Соёлын биет бус өвийг түүх, соёл, урлаг, гоо зүйн болон шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэнэ.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

8.5. Энэ хуулийн 8.4-т заасан жагсаалтад оруулах соёлын биет бус өвийг дараах шалгуураар тогтооно:

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

8.5.1. түүх, соёл, заншил, уламжлалыг илэрхийлэх байдал;

8.5.2. ховордсон, устсан, эрсдэлд орсон байдал.

8.6. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журмыг Засгийн газар батална.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

8.7. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

8.8. Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан зэрэглэлийг шатлан дэвшүүлэх зарчмаар тогтоох бөгөөд давхардуулж тогтоохгүй.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./



9 дүгээр зүйл. Соёлын өвийн үнэлгээ

/Энэ зүйлийн гарчигт “Соёлын” гэсний дараа “биет” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

9.1. Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

9.2. Нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөл тодорхойлно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

9.3. Өмчлөгчийн хүсэлтээр хувийн өмчийн соёлын биет өвд энэ хуулийн 9.1-д заасан журмын дагуу үнэлгээ тогтоож болно.

/Энэ хэсгийг 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

10 дугаар зүйл. Соёлын биет өвийн даатгал

10.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үзэсгэлэнд оролцуулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээ хийлгэх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд заавал даатгуулна.

10.2. Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад тохиолдолд соёлын биет өвийг даатгуулж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН
ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

11 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

11.1. Монгол Улсын Ерөнхийлөгч соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. Их эзэн Чингис хаан, монголын хаад, хатдын булш, бунхан, дурсгалын орчин болон олдворыг судлах, хамгаалах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох этгээдэд чиглэл өгөх;

11.1.2. хууль бусаар алдагдсан соёлын өвийг Монгол Улсыг төлөөлөн гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нэхэмжлэх эрхийг итгэмжлэлээр олгох, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох;

11.1.3. Ерөнхийлөгчийн ивээл доор хамгаалж болох соёлын өвийг зарлах, уул, усыг төрийн тахилгатай болгох шийдвэр гаргах;

11.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

12.1. Улсын Их Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. соёлын өвийг хамгаалах, ашиглах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

12.1.1. төрөөс соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлогыг тодорхойлох;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

12.1.2. соёлын өвийг хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;



12.1.3. Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёлын өвийн дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авах, түүний хилийн заагийг тогтоох;

12.1.4. соёлын өвийг хамгаалахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг батлах;

12.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

13 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

13.1. Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. соёлын өвийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

13.1.2. соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх;

13.1.3. соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг батлах;

13.1.4. язгуур гарал үүсэл нэг, илэрхийлэгдэх шинжээрээ нийтлэг, монгол угсаатны түүхэнд ач холбогдол бүхий соёлын өвийг хамгаалах талаар уг өв хадгалагдаж буй гадаад улстай хэлэлцээр хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

13.1.5. улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.6. соёлын өвийн үзлэг, тооллого хийх, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг тус тус батлах;

13.1.7. улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

13.1.7. улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

13.1.8. соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний болон түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг тус тус батлах;

13.1.8. түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

13.1.9. Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

13.1.10. соёлын өвийг хувиалан олшруулах, хуулбарлах, бүтээгдэхүүний загварт оруулах, кино, дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх журам батлах;

13.1.11. соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам батлах;

13.1.12. түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох;

13.1.12. түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоох, өөрчлөх, цушлах;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

13.1.13. соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./



13.1.14. соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтыг тус тус батлах;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

13.1.14. хуульд заасан бусад бүрэн эрх.

/Энэ заалтын дугаарт 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

14.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, зааврыг баталж, хэрэгжилтийг хангах;

14.1.2. соёлын өвийн улсын үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, дүнг Засгийн газарт тайлагнах;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

14.1.3. соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

14.1.4. соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журмыг тус тус батлах;

14.1.5. аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл

хөдлөх дурсгалын жагсаалтыг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг харгалзан батлах;

14.1.5. аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14.1.6. түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах;

14.1.7. соёлын өвийг хувилах, бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

14.1.8. дуудлага худалдаагаар худалдах соёлын биет өвийн бүртгэлийг хөтлөх, тайланг хүлээн авах, хяналт тавих;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

14.1.9. нийтийн өмчийн соёлын өвийг хадгалах, бүртгэх ажлыг мэргэжлийн ажилтнаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

14.1.10. устгах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

14.1.11. соёлын биет өвийг хилээр нэвтрүүлэх, сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, маллага, судалгаа хийх зөвшөөрөл олгох;

14.1.11. түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх, палеонтологи, археологийн хайгуул, маллага, судалгаа хийх зөвшөөрөл олгох;



/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14.1.12. соёлын өвийг судлах, сэргээн засварлах, зэрэглэл, үнэлгээ тогтоох чиг үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

14.1.12. мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14.1.13. соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх журам батлах;

14.1.14. соёлын өвийн дурсгалт газрын менежментийн төлөвлөгөөг батлах;

14.1.15. соёлын өвийг хамгаалах, сурталчлах үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

14.1.16. соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны удирдлагыг томилж, чөлөөлөх;

14.1.17. түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх, соёлын биет бус өвийг ЮНЕСКО-ийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14.1.17. хуульд заасан бусад бүрэн эрх.

/Энэ заалтын дугаарт 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14¹ дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

14^{1.1}. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын өвийг хамгаалах чиглэлээр дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14^{1.1.1}. төрөөс соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

14^{1.1.2}. соёлын өвийн улсын үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, дүнг Засгийн газарт тайлагнах;

14^{1.1.3}. соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах;

14^{1.1.4}. соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14^{1.1.5}. соёлын өвийг хувилах, бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;

14^{1.1.6}. дуудлага худалдаагаар худалдах соёлын биет өвийн бүртгэлийг хөтлөх, тайланг хүлээн авах, хяналт тавих;

14^{1.1.7}. нийтийн өмчийн соёлын өвийг хадгалах, бүртгэх ажлыг мэргэжлийн ажилтнаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

14^{1.1.8}. устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

14^{1.1.9}. соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг хөтлөх;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй



болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14¹.1.10. дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх, бүрэн бүтэн байдлыг хамгаалах, сэргээн засварлах, ЮНЕСКО-ийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлсэн соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг хамгаалж, бэхжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14¹.1.10. хуульд заасан бусад бүрэн эрх.

/Энэ зүйлийг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтын дугаарт 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

15.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1. нутаг дэвсгэртээ соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, хяналт тавих;

15.1.2. түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус хайгуул, малтлагаас урьдчилан сэргийлэх, соёлын өвийн зөрчлийн талаар олон нийтээс мэдээлэл авах, соёлын өвийг хамгаалах ажилд иргэдийг татан оролцуулах арга хэмжээ авах;

15.1.3. соёлын өвийг хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр Засаг даргад чиглэл өгч, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг хэлэлцэж дүгнэлт өгөх;

15.1.4. харьяалах нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалах чиглэлээр санал гаргах, хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих;

15.1.5. хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу орон нутгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт газрыг аялал жуулчлалын байгууллагад гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах;

15.1.6. устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах арга хэмжээ авах;

15.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.

15.2. Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталж, хилийн зааг, хамгаалалтын дэглэмийг тогтоон хяналт тавина.

15.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батална.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

16.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1. соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

16.1.2. соёлын өвийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;



16.1.3. соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

16.1.4. соёлын өвийн судалгаа, тайлан мэдээллийг зохих журмын дагуу гаргаж, аймаг, нийслэл, улсын бүртгэл, мэдээллийн санд хүргүүлэх;

16.1.5. зохих журмын дагуу соёлын өвийн үзлэг, тооллого хийх;

16.1.6. соёлын өвд эрсдэл учруулахуйц аливаа үйл ажиллагааг таслан зогсоож, хуульд заасны дагуу арга хэмжээ авах;

16.1.7. палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, багт дэмжлэг үзүүлэх;

16.1.8. соёлын өвийг сурталчлах;

16.1.9. дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

16.1.10. соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хуульд заасан дэмжлэг үзүүлэх;

16.1.11. түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр арга хэмжээ авах ажлыг удирдан зохион байгуулах;

16.1.12. соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах;

16.1.13. хуульд заасан бусад бүрэн эрх.

17 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

17.1. Сум, дүүргийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

17.1.2. соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

17.1.3. палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, багт зориулалт бүхий газрыг ашиглуулах;

17.1.4. палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгааны ажил дууссаны дараа судалгаа явуулсан байгууллагаас уг газрыг аюул осолгүй болгохыг шаардах, хүлээн авах.

18 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын бүрэн эрх

18.1. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1. соёлын өвийг хамгаалахад олон нийтийг татан оролцуулах;

18.1.2. соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх саналыг дээд шатны хуралд хүргүүлэх;

18.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

19 дүгээр зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

19.1. Баг, хорооны Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1. соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

19.1.2. палеонтологи, археологийн хууль бус хайгуул, малтлагыг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх талаар холбогдох албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх;

19.1.3. түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний орчныг цэвэр үзэмжтэй байлгах, хог хаягдлыг цэвэрлэхэд иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

19.1.4. соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай



оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хуульд заасны дагуу урамшуулах, дэмжлэг үзүүлэх, дээд шатны байгууллагад уламжлах;

19.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

20 дугаар зүйл. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо

20.1. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь дараах тогтолцоотой байна:

20.1.1. байгууллагын бүртгэл, мэдээллийн сан;

20.1.2. сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.3. аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.4. улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан.

20.2. Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг соёлын төвд; аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд; нийслэлийн бүртгэл, мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид; улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална.

20.3. Соёлын өвийн үндэсний төв нь Монгол Улсын соёлын өвийг бүртгэх, мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

20.3. Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

20.4. Төрийн болон орон нутгийн музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах,

сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

20.5. Сум, дүүргийн соёлын төв нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах үүргийг гүйцэтгэнэ.

20.6. Дараах аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлнэ:

20.6.1. Монголбанк;

20.6.2. дурсгалт газрын хамгаалалтын захиргаа;

20.6.3. музей, галерей, номын сан, сүм хийд;

20.6.4. эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори.

20.6.5. үндэсний төв архив.

/Энэ заалтыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн./

20.7. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд иргэн, хуулийн этгээд өөрийн өмчилж, эзэмшиж байгаа соёлын өвийг бүртгүүлж болно.

20.8. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна.

20.9. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь төрийн өмчид байна.

20.10. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн байрлал, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг тухайн санг бүрдүүлсэн байгууллага хариуцна.

21 дүгээр зүйл. Соёлын өвийн бүртгэлийн бүрдэл

21.1. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь соёлын өвийг эвдэрч гэмтсэн, устсан, мартагдсан тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан байвал зохино.



21.2. Соёлын өвийн бүртгэл нь дараах дагалдах хэрэглэгдэхүүнээс бүрдэнэ:

- 21.2.1. соёлын өвийн тодорхойлолт;
- 21.2.2. судалгаа, шинжилгээний ажлын тайлан;
- 21.2.3. сэргээн засварласан ажлын тайлан;
- 21.2.4. үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт;
- 21.2.5. дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт;
- 21.2.6. гэрэл зураг, түүнийг агуулсан хальс, зээрэнцэг;
- 21.2.7. дуу, дүрс агуулсан бүх төрлийн бичлэг;
- 21.2.8. хэв, хуулбар, дардас;
- 21.2.9. соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн талаарх мэдээлэл;
- 21.2.10. сэргээн засварлах ажлын хэмжилт, судалгаа, зураг төсөл;
- 21.2.11. бүртгэлд холбогдох бусад хэрэглэгдэхүүн.

21.3. Соёлын өвийн бүртгэл, түүнд дагалдах хэрэглэгдэхүүн нь лавлагаа, мэдээллийн хувьд нэгдмэл цогц байх нөхцөлийг бүрдүүлнэ.

21.4. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэлийг хуульд зааснаас бусад үндэслэлээр дамжуулах, ашиглуулах, хувилах, үрэгдүүлэх болон стандартын бус орчинд хадгалахыг хориглоно.

21.5. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийг архивын байгууллагад хадгалуулна.

22 дугаар зүйл. Соёлын өвийг бүртгэх

22.1. Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

/Энэ хэсэгт “түүх, соёлын” гэсний дараа “хөдлөх” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

22.2. Нийтийн өмчийн соёлын биет өвийн талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэнэ.

22.3. Энэ хуулийн 22.2-т зааснаас бусад соёлын биет өвийг өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зохих шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлж болно. Бүртгүүлсэн мэдээллийн нууцлал, хадгалалтын нөхцөлийг гэрээгээр зохицуулна.

22.4. Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тухай мэдээллийг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ.

22.5. Соёлын өв устсан, үрэгдсэн тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр төрийн болон орон нутгийн өмчөөс хасна.

22.6. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас мэдээлэл хасахыг хориглоно.

23 дугаар зүйл. Соёлын өвийг бүртгэх хугацаа

23.1. Соёлын өвийг нээж, илрүүлсэн байгууллага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн бүртгэл, мэдээллийн санд 15 хоногийн дотор мэдэгдэж, анхан шатны бүртгэл хийлгэнэ.

23.2. Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ.

23.3. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаадын байгууллага, иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын соёлын өвтэй холбоотой зүйлийг өөрийн санаачилгаар төрийн өмчид өгсөн тохиолдолд уг дурсгалыг соёлын өвийн улсын нэгдсэн



бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, түүнийг хадгалах үүрэг бүхий байгууллагад шилжүүлнэ.

24 дүгээр зүйл. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах

24.1. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно. Мэдээллийг ашиглуулахдаа өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хөндөж үл болно.

24.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн мэдээллээр нийтэд зориулан сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргаж болно.

24.3. Соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариусан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна.

25 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын кадастр, өмчлөх, эзэмших эрхийн бүртгэл

25.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний оршин байгаа газрыг өмчлөгч, эзэмшигч нь эд хөрөнгийн эрхийн болон газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан бүртгэлийг Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хадгална.

26 дугаар зүйл. Соёлын өвийн үзлэг, тооллого

26.1. Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

26.2. Соёлын өвийг эзэмшигч нь тооллогоор илэрсэн зөрчлийг арилгах талаар тухайн шатны нутгийн захиргааны байгууллага болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран нэн даруй арга хэмжээ авна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

ТАВДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН СУДАЛГАА

27 дугаар зүйл. Соёлын өвийн судалгаа

27.1. Соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

27.2. Палеонтологи, археологийн хайгуул, маллага, судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байна.

27.3. Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, маллага хийх болон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн, судалгааны баг, байгууллагад угсаатны судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

27.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, маллага судалгаа хийх болон соёлын биет бус өвийн судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх харьяалах Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27.4. Соёлын өвийн судалгаа хийх журмыг соёлын болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.



/Энэ хэсэгт “Соёлын өвийн судалгаа” гэснийг “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27.5. Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад олгоно.

27.6. Авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн судлаачдын багт олгож болно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27.7. Соёлын биет өвийг таньж тогтоох судалгаа, шинжилгээг өмчийн бүх хэлбэрийн эрдэм шинжилгээний лабораторид хийж болно.

27.8. Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна.

27.9. Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна.

27.10. Урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

27.11. Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх ажлыг холбогдох журмын дагуу мэргэжлийн соёл, урлаг, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд эрхлэн явуулна.

28 дугаар зүйл. Палеонтологи, археологийн хайгуул, маллага, судалгаа хийхэд хориглох зүйл

28.1. Палеонтологи, археологийн хайгуул, маллага, судалгаа хийхэд дараах зүйлийг хориглоно:

28.1.1. геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээх;

28.1.2. тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх;

28.1.3. судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашиглах;

28.1.4. маллага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээх.

29 дүгээр зүйл. Соёлын өвийн судалгааны ажлын тайлан

29.1. Соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэг хувийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлнэ.

29.2. Тайлан бүрэн эхээрээ нийтлэгдээгүй тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

30 дугаар зүйл. Олдвор

30.1. Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн.

30.2. Олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээхийг хориглоно.

/Энэ хэсэгт “анхны төрх байдал” гэснийг “эх төрх, бүрэн бүтэн байдал” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./



30.3. Олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалахыг хориглоно.

30.4. Олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

30.5. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олдворыг хадгалах, эзэмших байгууллагад шилжүүлэхдээ илрүүлсэн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг харгалзана.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

30.5. Олдворыг эзэмшүүлэх, түр хадгалах зорилгоор музей, эрдэм шинжилгээний байгууллага болон холбогдох бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олдворыг анх илрүүлсэн эрдэм шинжилгээний байгууллага, судлаачийн саналыг харгалзан шийдвэрлэнэ.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

30.6. Олдворыг хадгалж, ашиглахдаа гарал үүслийн нэгдмэл цогц байдлыг хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

СОЁЛЫН ӨВИЙГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ

31 дүгээр зүйл. Соёлын биет өвийг эзэмших

31.1. Нийтийн өмчийн соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага өмчлөгчийн тогтоосон нөхцөлөөр тус тус эзэмшинэ.

31.2. Доор дурдсан байгууллага, хуулийн этгээд нийтийн өмчийн соёлын биет өвийг эзэмшинэ:

31.2.1. төрийн болон орон нутгийн музей;

/Энэ заалтад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

31.2.2. галерей;

- 31.2.3. эрдэм шинжилгээний байгууллага;
- 31.2.4. үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн номын сан;
- 31.2.5. үндэсний төв архив, аймаг, нийслэлийн архив;
- 31.2.6. шашны байгууллага;
- 31.2.7. хууль тогтоомжоор соёлын өвийг хадгалж, хамгаалах үүрэг хүлээлгэсэн бусад байгууллага.

32 дугаар зүйл. Төрийн өмчийн соёлын биет өвийг эзэмшигчийн эрх, үүрэг

32.1. Соёлын биет өвийг эзэмшигч дараах эрх эдэлнэ:

- 32.1.1. өмчлөгчтэй тохиролцсоны дагуу нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд оролцуулах, түүнээс олсон орлогын тодорхой хувийг авах;
- 32.1.2. ангилал, зэрэглэлийг харгалзан холбогдох журмын дагуу тэдгээрийг түр солилцох, түрээслэх, худалдаж авах;
- 32.1.3. сурвалжлан олж цуглуулах, судалж шинжлэх, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах;
- 32.1.4. стандартын шаардлага хангасан байр, лаборатори, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах;
- 32.1.5. соёлын биет өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэх.

32.2. Соёлын биет өвийг эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

- 32.2.1. соёлын өвийн бүртгэл хөтөлж, бүртгэл, мэдээллийн сан үүсгэх;
- 32.2.2. дээд шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;
/Энэ заалтад “Соёлын” гэсний өмнө “харьяалах аймаг, нийслэлийн” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 32.2.3. бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх;
- 32.2.4. түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;



32.2.5. соёлын биет өв алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тухайн шатны бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

32.2.6. өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр соёлын биет өвийг сэргээн засварлах, бусдад ашиглуулахгүй байх.

33 дугаар зүйл. Соёлын биет өвийг өмчлөгчийн эрх, үүрэг

33.1. Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах эрх эдэлнэ:

33.1.1. язгуур зориулалтаар ашиглах;

33.1.2. нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд тавих, түүнээс олсон орлогоос авах;

33.1.3. зайлшгүй сэргээн засварлах шаардлагатай тохиолдолд зохих журмын дагуу улсаас санхүүгийн дэмжлэг авах;

33.1.4. түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг өөрийн хүсэлтээр төрд худалдсан тохиолдолд татварын хөнгөлөлт эдлэх;

33.1.5. музей, галерей байгуулах.

33.2. Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

33.2.1. соёлын өвийн гарал үүслийн байдлыг тодорхойлох;

33.2.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

/Энэ заалтад “Соёлын” гэсний өмнө “харьяалах аймаг, нийслэлийн” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

33.2.3. худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх;

33.2.4. түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

33.2.5. алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

33.2.6. түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавих;

33.2.7. түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд бэлэглэх, өвлүүлэх зэргээр түүний өмчлөлд шилжүүлэхгүй байх.

34 дүгээр зүйл. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн эрх, үүрэг

34.1. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь дараах эрх эдэлнэ:

34.1.1. соёлын биет бус өвийг яаралтай хамгаалах, өвлүүлэх, сэргээн уламжуулах зайлшгүй тохиолдолд санхүүгийн дэмжлэг авах.

34.2. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь дараах үүрэг хүлээнэ:

34.2.1. соёлын биет бус өвийг хойч үедээ өвлүүлэх, шавь сургах;

34.2.2. соёлын биет бус өвийг сурталчилж, түгээн дэлгэрүүлэх;

34.2.3. соёлын биет бус өвийн бүртгэл хийх, мэдээлэл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

35 дугаар зүйл. Соёлын биет өвийг худалдах, худалдан авах

35.1. Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.2. Соёлын биет өвийг худалдан авах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, улс, орон нутгийн музей, номын сан олон нийтэд нээлттэй, ил тод хэлбэрээр зохион байгуулна.
/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

35.3. Соёлын биет өвийг худалдан авсан байгууллага жил бүр үзэсгэлэн зохион байгуулж, нийтэд сурталчилна.



35.4. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно.

35.5. Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.

36 дугаар зүйл. Соёлын биет өвийг ашиглах

36.1. Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

36.2. Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

36.3. Төрийн өмчид байгаа соёлын биет өвийг язгуур зориулалтаар ашиглахыг хориглоно. Энэ хэсгийн заалт нь түүх, соёлын дурсгалт барилга, байшинд хамаарахгүй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО

37 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тогтолцоо

37.1. Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

37.2. Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

37.3. Соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр төрийн болон, орон нутгийн музейд шилжүүлэн хадгалж болно.

/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

37.4. Сум, дүүргийн Засаг дарга түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

37.5. Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд тухайн дурсгалын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж, байрлуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

37.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтооно. Өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

38 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа

38.1. Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно:

38.1.1. түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах;



38.1.2. палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;

38.1.3. хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх;

38.1.4. улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх.

38.2. Палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно.

38.3. Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

39 дүгээр зүйл. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах

39.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бүх шатны Засаг дарга соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн угсаатан ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлөн уламжлуулах, хадгалж хамгаалах асуудлыг хариуцна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

39.2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх,

олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор гурван жил тутам улсын хэмжээнд соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

39.3. Соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, шавь сургалт зохион байгуулах асуудлыг бүх шатны Засаг дарга зохион байгуулна.

40 дүгээр зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах

40.1. Соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулах, авран хамгаалах, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах, сэргээн уламжлуулах, сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.

40.2. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэнийг төрөөс алдаршуулж, урамшуулна.

40.3. Энэ хуульд заасан шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлсэн, соёлын өвийг хуулбарласан, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан тухай мэдээлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулд борлуулалтын орлогын 15 хувийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгоно.

40.4. Зөрчлийн тухай мэдээллийг худалдан авах журмыг Засгийн газар батална. Мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжийн дагуу чандлан хадгална.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

40.5. Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийг жил бүр тодруулж, мөнгөн шагнал олгох бөгөөд мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар батална.



41 дүгээр зүйл. Соёлын өвийн санхүүжилт

41.1. Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг доор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

41.1.1. улсын төсөв;

41.1.2. орон нутгийн төсөв;

41.1.3. Монгол Улсын болон гадаадын иргэн, олон улсын байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж;

41.1.4. бусад эх үүсвэр.

НАЙМДУГААР БҮЛЭГ ДУРСГАЛТ ГАЗРЫГ ХАМГААЛАХ

42 дугаар зүйл. Соёлын өвийн дурсгалт газар

42.1. Улсын Их Хурал соёлын өвийн дурсгалт газрын унаган төрх, соёлын үнэт зүйлийн язгуур шинжийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргаж, хилийн заагийг батална.

42.2. Соёлын өвийн дурсгалт газар байгуулах саналыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт өргөн мэдүүлнэ. Саналд тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг харгалзан үзэж болно.

42.3. Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна.

42.4. Соёлын өвийн дурсгалт газрыг дараах бүсэд хуваана:

42.4.1. хамгаалалтын бүс;

42.4.2. орчны бүс.

42.5. Соёлын өвийн дурсгалт газарт хэд хэдэн түүх, соёлын дурсгалт газар байрлаж болно.

42.6. Хамгаалалтын болон орчны бүсэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр байгаль, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж болно.

42.7. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын менежментийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгаалалтын захиргаа ажиллана.

42.8. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа энэ хуулийн 43, 44-т заасан үйл ажиллагаатай уялдуулан нэмэлт дэглэм тогтоож болно.

42.9. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаанд хэд хэдэн дурсгалт газрын хамгаалалтын асуудлыг харьяалуулж болно.

43 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм

43.1. Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

43.1.1. онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд нисэх онгоц буулгах;

43.1.2. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;

43.1.3. мод, элс, хайрга, чулуу авах зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

43.1.4. хот суурин, цахилгаан станц байгуулах;

43.1.5. тэсэлгээ хийх;

43.1.6. шинээр барилга байгууламж барих.

44 дүгээр зүйл. Орчны бүсийн дэглэм

44.1. Орчны бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

44.1.1. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;

44.1.2. хот суурин, цахилгаан станц байгуулах;

44.1.3. тэсэлгээ хийх.

45 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт газар

45.1. Засгийн газар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, харагдах сүр барааг хадгалах зорилгоор хамгаалалтын бүс тогтооно.



/Энэ хэсэгт “тогтооно.” гэсний дараа “Хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

45.2. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 45.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна.

45.3. Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

45.3.1. газар, түүний хэвлийг хөндөх;

45.3.2. мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй мод бут, төрөл бүрийн ургамал тарих;

45.3.3. гэр, сууц, барилга, байгууламж барих;

/Энэ заалтад “гэр” гэсний өмнө “энэ хуулийн 45.5-д зааснаас бусад зорилгоор” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

45.3.4. мал бэлчээх;

45.3.5. онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд өөрөө явагч хэрэгсэл нэвтрүүлэх, нисэх онгоц буулгах;

45.3.6. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;

45.3.7. мод, элс, хайрга, чулуу авах.

45.4. Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд судалгаа шинжилгээ хийх, сэргээн засварлах, аялал жуулчлалын зорилгоор сурталчлах үйл ажиллагаа явуулж болно.

45.5. Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд байгаа үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдлыг сайжруулах зорилгоор түүний эх төрх, бүрэн бүтэн байдалд нь хохирол учруулахгүй байх хэлбэрээр шинээр барилга байгууламж барьж, судалгаа, сурталчилгааны зориулалтаар ашиглаж болно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

45.6. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор энэ хуулийн 45.1-д заасан хамгаалалтын бүсийн эргэн тойронд Соёлын тухай хуульд нийцүүлэн соёлын орчин, орон зайг бий болгож болно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

СОЁЛЫН ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ

46 дугаар зүйл. Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага

46.1. Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулсан сэргээн засварлах зураг төслийн дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага, иргэн гэрээгээр гүйцэтгэнэ.

46.2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл ажиллана. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

46.3. Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

46.4. Хуульд өөрөөр заагаагүй бол соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага соёлын биет өвийг сэргээн засварлаж болно.

46.5. Соёлын биет өвийг зөвшөөрөлгүй сэргээн засварлахыг хориглоно.



46.6. Монгол Улсын хэмжээнд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Соёлын биет өвийг сэргээн засварлах газар гүйцэтгэнэ.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

46.7. Соёлын биет өвийг сэргээн засварлах ажилд туслан гүйцэтгэгчийг гэрээгээр ажиллуулж болно.

47 дугаар зүйл. Соёлын биет өвийг сэргээн засварлах үйл ажиллагаа

47.1. Соёлын биет өвийг сэргээн засварлахад дараах зарчмыг баримтална:

47.1.1. анхны төрх, хийц бүтээцийг хадгалж үлдээх;

47.1.2. аюулгүй, удаан хугацаанд хадгалах нөхцөлийг хангах.

47.2. Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

47.3. Соёлын биет өвийг сэргээн засварласан ажлын дэлгэрэнгүй тайланг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, архивт шилжүүлнэ.

48 дугаар зүйл. Соёлын биет бус өвийг сэргээн уламжлуулах

48.1. Соёлын биет бус өв устсан, мартагдсан тохиолдолд сэргээн уламжлуулах арга хэмжээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох бүртгэл, мэдээллийг үндэслэн зохион байгуулна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

48.2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөл соёлын биет бус өвийг сэргээгдсэнд тооцож, дүгнэлт гаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙГ СУРТАЛЧЛАХ

49 дүгээр зүйл. Соёлын өвийн боловсрол

49.1. Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлал болон боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

49.2. Соёлын өвийн боловсрол эзэмшүүлэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

49.2.1. соёлын өв, түүнийг хамгаалах мэдлэгийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн боловсролын сургалтын стандартад тусгах;

49.2.2. коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагын суралцагчид соёлын өвийг хамгаалах, ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрол эзэмшүүлэх;

49.2.3. олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соёлын өвийг хамгаалах, өв уламжлал, ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

50 дугаар зүйл. Соёлын өвийн үзэсгэлэн

50.1. Нийтийн өмчийн соёлын биет өвөөр дотоод, гадаадад үзэсгэлэн гаргах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүнээс эрх олгосон байгууллага зохион байгуулна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

50.1. Төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага зохион байгуулна. Энэ заалт хувь хүн, хуулийн этгээд хувийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргахад хамаарахгүй.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./



50.2. Энэ хуулийн 50.1-д заасан эрх бүхий байгууллага соёлын биет өвийг эзэмшигчтэй гэрээ байгуулна. Гэрээнд биет өвийг ашиглах нөхцөл, хугацаа, даатгалын баталгааны хэмжээ, түрээсийн төлбөр, ашиглагч этгээдийн хүлээх хариуцлага, хамгаалалтын болон эрсдэлийн баталгааны нөхцөлийг тусгана.

50.3. Хувийн өмчийн соёлын өвийг өмчлөгч, эзэмшигчтэй нь байгуулсан гэрээний үндсэн дээр үзэсгэлэнд оролцуулж болно.

50.4. Соёлын биет өвийг гадаадад үзэсгэлэнд гаргах гэрээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянана.

50.5. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргах, музей байгуулахыг хориглоно.

51 дүгээр зүйл. Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх

51.1. Соёлын биет өвийг хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг бүрэн хангасны үндсэн дээр зөөж тээвэрлэнэ.

51.2. Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмыг Засгийн газар тогтооно.

52 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх

/Энэ зүйлийн гарчигт “соёлын” гэсний дараа “хөдлөх” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

52.1. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл, эх олдворыг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрлөөр нэг жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Энэ хэсгийн заалт нь түүний хувилсан эх хуулбарт хамаарахгүй.

/Энэ хэсэгт “зүйл” гэснийг “зүйлийг” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсгээс “эх олдворыг” гэснийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн

хуулиар хассан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

52.2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг соёлын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

52.3. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.1-д зааснаас бусад түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараах зорилгоор, эргүүлэн авчрах нөхцөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно:

52.3.1. палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх;

52.3.2. сэргээн засварлах;

52.3.3. гадаад улсад үзэсгэлэнд гаргах;

52.3.4. өмчлөгч өөрөө язгуур зориулалтаар нь ашиглах.

/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

52.3. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.1-д зааснаас бусад нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараах зорилгоор эргүүлэн авчрах нөхцөлтэйгөөр улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

52.4. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр хоёр жилээс дээшгүй хугацаагаар нэвтрүүлнэ. Энэ хуулийн 52.3.1, 52.3.2-т заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уг хугацааг сунгаж болно.

52.4. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хоёр жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас уг хугацааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх



түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн нэг удаа 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

52.5. Энэ хуулийн 52.3-т заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлж байгаа этгээд түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангасан байна.

52.6. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу мэдээллийг үйлдэж, хадгалалтын байдлын тайлан, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулан соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулна.

52.7. Хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, эсхүл энэ хуулийн 52.1, 52.3-т заасны дагуу улсын хилээр гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болохыг зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон цагдаагийн байгууллага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулна.

Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

52.8. Шүүхийн шийдвэрээр төрийн өмчид шилжүүлсэн болон гаалийн байгууллагад хураагдсан соёлын биет өвийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрөл зүйлээр нь ялгаж, холбогдох журмын дагуу мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

52.8. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг

холбогдох журмын дагуу музей, эрдэм шинжилгээний байгууллагад шилжүүлнэ.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

52.9. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хувийн өмчид байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг дурсгалт зүйлийг өмчлөгч, эсхүл өмчлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгоно. Улсын хилээр нэвтрүүлэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь энэ хуулийн 20.7, 32.2.2-т заасан бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

53 дугаар зүйл. Соёлын өвийг хувилах

53.1. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөлгүйгээр нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 масштабаар хувиан олшруулахыг хориглоно.

53.2. Энэ хуулийн 53.1-д зааснаас өөр масштабаар хувиан олшруулах эрхийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

53.3. Соёлын өвийг хувилах болон бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

54 дүгээр зүйл. Соёлын өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх

54.1. Энэ хуулийн 53.2-т заасан зөвшөөрөл авсан этгээдтэй мерчандайзийн гэрээг зөвхөн төрийн болон орон нутгийн музей, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон соёлын бусад байгууллага байгуулна.



/Энэ заалтад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

54.2. Төрийн болон орон нутгийн музей болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон соёлын бусад байгууллага нь бүтээгдэхүүний борлуулагч байж болно.

/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

54.3. Төрийн болон орон нутгийн музей болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагч нь мерчандайзийн гэрээ байгуулна. Гэрээний загварыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ МЕРЧАНДАЙЗИЙН ГЭРЭЭ

55 дугаар зүйл. Мерчандайзийн гэрээ

55.1. Иргэний хуулийн 338¹ дүгээр зүйлийн дагуу мерчандайзийн гэрээгээр өмчлөгч, түүний зөвшөөрснөөр эзэмшигч нийтийн өмчийн соёлын өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь эзэмшигчид борлуулалтын орлогоос соёлын өвийн загвар ашигласны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

55.2. Мерчандайз нь барааны тэмдэг, бүтээгдэхүүний загварын эрхээр хамгаалагдана.

/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

56 дугаар зүйл. Мерчандайзийн гэрээний талууд

56.1. Дараах этгээд мерчандайзийн гэрээний тал байна:

56.1.1. нийтийн болон хувийн өмчийг өмчлөгч;

56.1.2. төрийн болон, орон нутгийн музей, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон соёлын бусад байгууллага;

/Энэ заалтад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

56.1.3. эрх олгогдсон үйлдвэрлэгч, борлуулагч.

/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./

57 дугаар зүйл. Мерчандайзийн гэрээний нөхцөл

57.1. Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг Иргэний хуулийн дагуу бичгээр байгуулж дараах зүйлийг тусгана:

57.1.1. мерчандайзийн зүйлийн хэмжээ, загвар, өнгө, материалын дэлгэрэнгүй тодорхойлолт;

57.1.2. мерчандайзийн гэрээний дагуу үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээ;

57.1.3. үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулагч, борлуулах цэгийн мэдээлэл;

57.1.4. мерчандайзийн зүйлийг үйлдвэрлэх, борлуулахад шаардлагатай санхүүжилтийн хэлбэр, нөхцөл;

57.1.5. мерчандайзийн зүйлийг гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, борлуулах болон чанарын баталгаа;

57.1.6. соёлын өвийн загвар ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөл;

57.1.7. мерчандайзийн гэрээний хугацааг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, мерчандайзийн гэрээ ба холбогдох бусад гэрээ хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол



ба гэрээ цулах, дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх журам;

57.1.8. талууд харилцан тохиролцсон бусад зүйл.

/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН ХЯНАЛТ

58 дугаар зүйл. Соёлын өвийн хяналт

58.1. Соёлын өвийн хяналтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, улсын байцаагч, гэрээт харуул хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

58.2. Соёлын өвийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, дүрэм журам, түүнтэй холбогдсон норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

58.3. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтад байгаль орчны хяналтын улсын байцаагч хяналт тавина.

/Энэ хэсэгт “хамгаалалтад” гэсний дараа “соёлын болон” гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

58.4. Соёлын өвийн хяналтын улсын байцаагчийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

58.5. Соёлын өвийн гэрээт харуулыг сум, дүүргийн Засаг дарга томилно.

59 дүгээр зүйл. Соёлын өвийн гэрээт харуулын эрх, үүрэг

59.1. Соёлын өвийн гэрээт харуул нь дараах эрх, үүрэгтэй:

59.1.1. түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх мэдээлэл, хамгаалалтын хэрэгслээр хангагдах, цалин хөлс, урамшуулал авах;

59.1.2. түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийг засварлах, авран хамгаалах талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх;

59.1.3. түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг үзэж сонирхох, судлахаар ирсэн иргэнийг бүртгэх, тэдний багаж хэрэгслийг шалгах, соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг тайлбарлаж таниулах;

59.1.4. түүх, соёлын үл хөдлөх дурсгалын орчинд зөвшөөрөлгүйгээр металл хайгч, тусгай багаж ашиглуулахгүй байх;

59.1.5. хууль бус хайгуул, малтлага хийхийг хориглох, таслан зогсоох, үйл ажиллагааг нь баримтжуулах, мэдээлэх;

59.1.6. хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн этгээдийг улсын байцаагч болон холбогдох хуулийн байгууллагад мэдээлэх;

59.1.7. хамгаалж байгаа соёлын өвийн ойролцоо байнга оршин суух.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

60 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

60.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

60.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/



61 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

61.1. Энэ хуулийг 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс, мөн хуулийн 20.3, 20.4, 20.5, 46.6, 58.1 дэх хэсгийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 6-р сарын 20-ны өдөр Дугаар 184

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Соёлын биет бүс өвийн үзлэг хийх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам"-ыг 2 дугаар хавсралт, "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 233 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

У.ХҮРЭЛСҮХ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙД

Ц.ЦОГЗОЛМАА



ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТООЛЛОГО ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь түүх, соёлын үл хөдлөх дурсгал (цаашид “үл хөдлөх дурсгал” гэх)-ын эх төрх, бүрэн бүтэн байдлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1-д заасны дагуу таван жил тутам нягтлан шалгаж, хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Үл хөдлөх дурсгалын тооллогын комисс байгуулах, тооллого хийхэд бэлтгэх, зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Тооллогын ажилд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй үл хөдлөх дурсгалын жагсаалт бүхий тооллогын дэвтрийг ашиглана.

Хоёр. Тооллогын комисс байгуулах

2.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тооллогын ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Улсын комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг тухайн жилийн 2 дугаар сарын 15-ны дотор баталж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тооллогын ажлыг зохион байгуулах үүрэг бүхий салбар комиссын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг тухайн жилийн 3 дугаар сарын 15-ны дотор батална.

2.3. Комиссын бүрэлдэхүүн нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэдийн төлөөллийг оролцуулна. Комиссын бүрэлдэхүүн нь сондгой тооны төлөөллөөс бүрдэнэ.

2.4. Улсын комиссын орон нутагт ажиллахад шаардагдах зардлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, салбар

комиссын орон нутагт ажиллахад шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус хариуцна.

2.5. Сум, дүүргийн Засаг дарга, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хил хамгаалах байгууллага, түүний харьяа анги, нэгтгэлүүд нь улсын болон салбар комиссын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

Гурав. Тоолмогод бэлтгэх

3.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үл хөдлөх дурсгалын тооллогын ажлын бэлтгэлийг хангах талаар дараах ажлыг зохион байгуулна:

3.1.1. тооллого явуулах талаар сургалт зохион байгуулах;

3.1.2. тооллогын ажилд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг холбогдох байгууллагад хуваарилах;

3.1.3. тооллогын ажлыг зохион байгуулах талаарх мэдээллийг онцгой байдал, хил хамгаалах болон мэргэжлийн хяналтын байгууллага, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд мэдэгдэх;

3.1.4. тооллогын ажилд ашиглах тооллогын дэвтрийг хэвлэж бэлтгэх.

3.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга салбар комиссын орон нутагт ажиллахад ашиглах туулах чадвар сайтай, техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан тээврийн хэрэгслийг бэлтгэнэ.

Дөрөв. Тооллогын ажлыг зохион байгуулах

4.1. Улсын комиссын дарга тооллогын дэвтэрт гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан салбар комисст хүлээлгэж өгнө.

4.2. Салбар комиссын дарга тооллогын ажлыг орон нутагт зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, гишүүдийн ажил үүргийн хуваарийг энэхүү журмын 2.1-д заасан удирдамжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ.



4.3. Салбар комисс улсын хилийн бүс, улсын тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах бол холбогдох зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авна.

4.4. Салбар комисс тооллогын ажлыг холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд заасны дагуу үнэн зөв, шуурхай, чанартай зохион байгуулна. Салбар комисс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. тооллогын дэвтэрт бичигдсэн үл хөдлөх дурсгалыг тооллогод бүрэн хамруулах;

4.4.2. үл хөдлөх дурсгалын гэрэл зургийг харьцуулах хэмжээстэй авах, дүрс бичлэг хийж байршлыг тогтоох;

4.4.3. шинээр илэрсэн дурсгалыг зохих журмын дагуу бүртгэж, тооллогод хамруулах;

4.4.4. үл хөдлөх дурсгалын талаар тооллогын дэвтэрт буруу бичигдсэн тохиолдолд бичвэрийн шалтгааныг судлан тодруулж, тэмдэглэл бичих;

4.4.5. тооллогын ажлын явцын мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг дарга болон улсын комисст 30 хоног тутам мэдээлэх;

4.4.6. хууль бус үйл ажиллагаанд өртсөн үл хөдлөх дурсгалын талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад хүргүүлэх.

4.5. Салбар комисс тооллогын явцад галын аюулгүй байдлын хууль тогтоомжийг чанд мөрдөж, аливаа эрсдэлээс өөрсдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалж ажиллана.

4.6. Салбар комиссын дарга тооллогын явцад тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийлгэнэ.

4.7. Улсын болон салбар комиссын бүрэлдэхүүнд ажилласан гишүүдэд комиссыг томилсон соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн төсвийн зардалаас мөнгөн урамшуулал олгоно.

Тав. Тооллогын ажлын дүнг тайлагнах

5.1. Салбар комисс тооллогын ажлын тайланг мөн оны 11 дүгээр сарын 1-ний дотор эцэслэж, холбогдох баримт бичгийн хамт аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулна.

5.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тооллогын ажлын тайлантай танилцаад мөн оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор зохих санал дүгнэлтийн хамт Улсын комисст хүргүүлнэ.

5.3. Улсын комисс аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн тайланг нэгтгэж дүнг мөн оны 12 дугаар сарын 15-ны дотор соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулна.

5.4. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тооллогын ажлын нэгдсэн дүнг тухайн жилд багтаан Засгийн газарт танилцуулна.

5.5. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн тайлан, холбогдох бусад баримт бичгийг Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өгч хадгалуулна.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.



СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/14


Улаанбаатар хот

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын
тооллогын ажил зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журмын 2.1 дэх хэсэг, Соёлын сайдын "Үзлэг, тооллого хийх тухай" 2021 оны А/54 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын мэдээлэл цуглуулах маягт-2022"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан, Соёл, урлагийн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын ажил зохион байгуулах тухай" А/45/1 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  МОНХЗУЛ



1522110023

2

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 95 дугаар
сарын 06-ны өдрийн тушаалын нэгдүгээр хавсралт

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН УЛСЫН ТООЛЛОГЫН УДИРДАМЖ

Зорилго: Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам"-ын (цаашид журам гэх) хэрэгжилтийг хангах, дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад оршино.

Зохион байгуулах хугацаа: 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл.

Хамрах хүрээ:

- Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дүгээр тушаалаар баталсан аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал;
- Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон RICH 3.0 программд бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгал (цаашид дурсгал гэх).

Зохион байгуулагч: Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар.

Нэг. Салбар комисс, ажлын хэсэг

- 1.1. Салбар комиссын даргаар аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга, нарийн бичгийн дарга нь соёлын өв хариуцсан мэргэжилтэн байна.
- 1.2. Соёл, урлагийн газар байгуулагдаагүй аймагт Салбар комиссын даргаар Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга эсхүл музейн захирал, Нарийн бичгийн даргаар Нийгмийн бодлогын хэлтсийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн эсхүл музейн Бүртгэл, мэдээллийн санч байж болно.
- 1.3. Салбар комиссын гишүүдэд аймаг, нийслэлийн музей, сум, дүүргийн Соёлын төв, тусгай хамгаалалттай газрын мэргэжилтэн, судлаачид, мэргэжлийн хяналтын улсын байцаагч, архитектор, газрын харилцаа хариуцсан мэргэжилтэн болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөл болон орон нутгийн соёлын өвийн идэвхтнийг оролцуулна. Салбар комиссын бүрэлдэхүүн нь сондгой тооны төлөөлөлөөс бүрдэнэ.
- 1.4. Сум, дүүргийн Засаг дарга өөрийн нутаг дэвсгэрт орших сум, дүүргийн хамгаалалтад байх болон RICH 3.0 программд бүртгэлтэй дурсгалыг тоолох "Ажлын хэсэг"-ийг байгуулж болно.



- 1.5. Тооллогын бүртгэл, баримтжуулалтыг чанартай, үр дүнтэй гүйцэтгэх шаардлагын үүднээс Салбар комисс болон Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тусгай мэргэжил шаардсан гэрэл зурагчин, зураглаачийг оруулж болно.
- 1.6. Салбар комисс нь ажлын төлөвлөгөөнд "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам"-ын 4.4-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох зардлыг заавал тусгана.
- 1.7. Салбар комисс нь тооллогод хэрэглэгдэх зарим тоног төхөөрөмж, байгалийн бартаа туулах морь, мотоцикл ашиглах, түрээслэх зардал, зарцуулах шатахуун, томилолтыг тус тус тусгана.
- 1.8. Тооллогын явцад Салбар комиссын дарга, гишүүдийг хүндэтгэн үзэх шалтгаангүй чөлөөлж, өөрчлөхгүй.
- 1.9. Тооллогын явцад байгаль, нийгмийн давагдашгүй хүчин зүйл, ямар нэгэн зөрчил, дутагдал гарсан үед Ажлын хэсэг салбар комисст, Салбар комисс Улсын комисст тус тус мэдэгдэж заавар, зөвлөмж авч болно.

Хоёр. Тооллогыг зохион байгуулах

- 2.1. Салбар комисс нь үйл ажиллагаанд харьяалах нутаг дэвсгэрт орших Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дүгээр тушаалаар баталсан аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тус тус тооллогод хамруулна.
- 2.2. Ажлын хэсэг нь аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон бүртгэлийн RICH 3.0 программд бүртгэлтэй дурсгалыг тус тус тооллогод хамруулна.
- 2.3. Улсын комисс нь бүртгэлийн дугаар, сумын нэр, дурсгалт газрын нэр, дурсгалын төрөл, тоо ширхэг, солбицол, тэмдэглэлээс бүрдсэн жагсаалт бүхий тооллогын дэвтрийг Салбар комисст хүлээлгэн өгнө.
- 2.4. Ажлын хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалтын зөвлөмжийг сургалтаар өгнө.
- 2.5. Салбар комисс улс, аймгийн хамгаалалтад байх дурсгалыг тоолох явцдаа Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлнэ.
- 2.6. Тооллого хийх нэгдсэн арга зүй, зөвлөгөө өгөх сургалт болон 2021 онд зохион байгуулсан тооллогын ажлыг дүгнэж цаашид хийх үйл ажиллагааны чиглэлийг Салбар комисст хүргүүлэх ажлыг Улсын комисс зохион байгуулна.
- 2.7. Дурсгалыг оршин байгаа газарт нь очиж тоолохдоо 2015 оны улсын тооллогоос хойш үүссэн эвдрэл гэмтэл, хууль бус үйл ажиллагаанд өртсөн эсэх, хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөл байдал, нүдэнд ил харагдах аюулыг тэмдэглэж, зургаар баримтжуулна.
- 2.8. Тооллогын мэдээллийг дурсгалын төрөл тус бүрийн хадгалалт хамгаалалтын онцлогийг тусгасан хэзрийн бүртгэлийн маягтад тулгуурлан хийх ба www.nch.mongoluv.mn онлайн программд нэгтгэн боловсруулна.
- 2.9. Хэзрийн бүртгэлийн маягтаар цуглуулсан мэдээлэл, гэрэл зургийг бүртгэлийн программд зөрүүгүй, бүрэн гүйцэт оруулна.
- 2.10. Тооллогын үед дурсгалын байршлыг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор баталсан олон улсын геодезийн "WGS-84" солбицлын системийг ашиглан газарзүйн координат буюу градус, минут, секунд /Degree, minute, second/-ийн утгаар байрлалыг тогтооно.
- 2.11. Дурсгалыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулахдаа дурсгалын нэр, тоологдсон он, сар, өдрийг самбарт бичсэн байна.
- 2.12. Тооллогоор өмнөх бүртгэлийн алдааг залруулж, сайжруулах ажлыг хийнэ.

- 2.13. Ажлын хэсэг тоолсон дурсгалын мэдээллийг Салбар комисст хүргүүлж, Салбар комисс програмд оруулах ажлыг хариуцна.
- 2.14. Тоолсон дурсгалын мэдээллийг интернэттэй газраас бүртгэлийн www.rich.mongoluv.mn онлайн программд оруулах ажлыг Салбар комисс зохион байгуулна.
- 2.15. Салбар комисс тооллогын явцыг баримтжуулсан 10-15 минутын видео (FULL HD) танилцуулгыг чанарын өндөр түвшинд хийж, Улсын комисст тайлангийн хамт ирүүлнэ.
- 2.16. Тооллогын явцын дүн мэдээг 14 хоног тутам www.rich.mongoluv.mn онлайн программд оруулна.
- 2.17. Журмын 4.4.5 дахь заалтын дагуу тооллогын явцын мэдээллийг цахимаар хүргүүлнэ. Тооллогын явцын дүн мэдээг веб хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэнэ.
- 2.18. Салбар комисс хээрийн судалгаагаар ажиллахдаа журмын 4.5, 4.6-д заасан аюулгүй ажиллагааг чанд баримтлан ажиллана.

Гурав. Тооллогын ажлын дүнг тайлагнах

- 3.1. Улсын тооллогоор бүртгэсэн мэдээллийг Салбар комисс нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тооллогын мөрөөр цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан тайланд тусгана. Үүнд:
 - Өмнөх тооллогын бүртгэлд залруулга, нэмэлт хийсэн талаарх мэдээлэл, тоон дүн;
 - Хашаа, хайсаар хамгаалагдсан дурсгалт газрын төрөл, тоон дүн;
 - Дурсгалт газрыг гэрээгээр хариуцаж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагын тоон дүн;
 - Кадастрын хэмжилт хийсэн дурсгалт газрын төрөл, тоон дүн;
 - Газрын кадастрын системд бүртгэсэн дурсгалт газрын төрөл, тоон дүн;
 - Хаяг, тайлбартай дурсгалт газрын төрөл, тоон дүн;
 - Дурсгалт газар дахь дурсгалын эвдрэл гэмтлийн төрөл тус бүрийн тоон дүн, хувь (дурсгалын 7 төрөл тус бүрээр);
 - Тооллогын мөрөөр цаашид авах арга хэмжээний санал.
- 3.2. Салбар комисс тооллогын дүн мэдээ, тооллогын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулна.
- 3.3. Тооллогын ажлын дүн, тайланг журмын 5.1, 5.2-т заасны дагуу шатлан хүргүүлнэ.
- 3.4. Салбар комисс тооллогын тайланг 2 хувь үйлдэж нэгийг аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд, нэгийг Улсын комисст тус тус хүргүүлнэ.

---oOo---



5

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 25 дугаар
сарын 06-ны өдрийн 14 тушаалын хоёрдугаархавсралт

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТООЛЛОГО
ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээний нэр	Тооллого зохион байгуулах хугацаа (сараар)	Хариуцагч байгууллага
1	Тооллогын ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Улсын комиссыг байгуулж, бүрэлдэхүүнийг батлах	5-р сар	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар
2	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын удирдамж, төлөвлөгөө, төсөв боловсруулж батлуулах	5-р сар	Улсын комисс
3	2021 онд тооллоготой холбоотой хийгдэж байсан үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, цаашид хийх үйл ажиллагааг төлөвлөх	5-р сар	Улсын комисс
4	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллоготой холбогдуулан RICH 3.0 программыг хөгжүүлэх	5-р сар	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв
5	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг мэргэжил арга зүйгээр хангах гарын авлага боловсруулах, хэвлүүлэх, түгээх	5-р сар	Улсын комисс
6	Мэргэжил, арга зүйгээр хангах нэгдсэн сургалтыг цахимаар зохион байгуулах	5-р сар	Улсын комисс
7	Салбар комиссын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж Улсын комисст ирүүлэх	5,6-р сар	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
8	Салбар комисс болон сум, дүүргийн Ажлын хэсэг тооллого зохион байгуулах	6,7,8,9-р сар	Салбар комисс, Ажлын хэсэг
9	Улсын комисс тооллогын явцтай газар дээр нь танилцан, салбар комисст чиглэл өгөх (баруун, төвийн бүс)	6-р сар	Улсын комисс

10	Улсын комисс тооллогын явцтай газар дээр нь танилцан, салбар комисст чиглэл өгөх (зүүн, говийн бүс)	6-р сар	Улсын комисс
11	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын явцыг олон нийтэд мэдээлэх	7-р сар	Улсын комисс, Салбар комисс
12	Салбар комисс тооллогын ажлын явцын мэдээг нэгтгэх, мэдээлэх	6-11-р сар	Салбар комисс
13	Салбар комисс тооллогын тайланг нэгтгэн боловсруулж, аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулах	10-р сар	Салбар комисс
14	Аймаг, нийслэлийн Засаг дарга тооллогын тайланг зохих санал, дүгнэлтийн хамт Улсын комисст хүргүүлэх	11-р сар	Салбар комисс
15	Улсын комисс тооллогын ажлын нэгдсэн дүнг Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулах	11-р сар	Улсын комисс

--oOo--



ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ ЦУГАУУЛАХ МАЯГТ-2022

НЭГ. Үндсэн мэдээлэл

1	Дурсгалт газрын бүртгэлийн дугаар:													
---	------------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

2	Аймаг, нийслэл:	
---	-----------------	-------

3	Сум, дүүрэг:	
---	--------------	-------

4	Нэр:	
---	------	-------

5	Дурсгалт газрын солбицол:	N°’”	E°’”	ΔГД (м)
---	---------------------------	------------------------	------------------------	---------------

6	Бүрдэл:	☐ Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн үл мөр бүхий дурсгалт газар
		☐ Хадны зураг, тамга, тэмдэг, бичгийн дурсгал
		☐ Хөшөө дурсгал
		☐ Булш оршуулга, тахил тайлгын дурсгал
		☐ Барилга, архитектурын дурсгал,
		☐ Палеонтологийн олдворт газар

7	Хамгаалалтын зэрэглэл:	☐ Улсын хамгаалалтад
		☐ Аймаг, нийслэлийн хамгаалалтад
		☐ Сум, дүүргийн хамгаалалтад

8	Дурсгалт газрын мэдээлэл
	
	
	
	
	
	
	
	
	

Дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтын байдал			
9	Дурсгалт газрыг гэрээгээр хариуцаж байгаа иргэн, аж ахуй нэгж байгаа эсэх:	☐ Тийм	
		☐ Үгүй	
10	Хашаа, хайстай эсэх:	☐ Тийм	
		☐ Үгүй	
11	Хашаа, хайс нь дурсгалд эрсдэл дагуулж буй эсэх:	☐ Тийм	
		☐ Үгүй	
12	Хашаа, хайс бүрэн бүтэн эсэх:	☐ Тийм	
		☐ Үгүй	
13	Хаяг тайлбартай эсэх:	☐ Тийм	
		☐ Үгүй	
14	Кадастрын хэмжилт хийсэн эсэх:	☐ Тийм	
		☐ Үгүй	
15	Газрын кадастрын система бүртгэгдсэн эсэх:	☐ Тийм	
		☐ Үгүй	

		Latitude Longitude		Alt (m)
		N°	N: E:	
16	Дурсгалт газрын хамрах хүрээний солбицол:	1		
		2		
		3		
		4		
		5		
		6		
		7		
		8		

Мэдээлэл цуглуулсан:

Нэр:..... Албан тушаал: Он сар өдөр:



ХОЁР. Гэмтлийн мэдээлэл

1. Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн үл мөр бүхий дурсгалт газар

Дурсгалын бүртгэлийн дугаар:													
------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Дурсгалын дэд төрөл	
1	☐ Чулуун зэвсгийн дурсгалт газар
2	☐ Үйлдвэрлэлийн үл мөр бүхий дурсгалт газар
3	☐ Бусад

Гэмтлийн мэдээлэл					
№	Гэмтлийн төрөл	Гэмтэлгүй	10% хүртэл	10-50%	50%-с дээш
		0	1	2	3
1	Дурсгалт (олдворт) газраас элс шороо авсан эсэх	☐	☐	☐	☐
2	Газар тариаланд өртсөн эсэх	☐	☐	☐	☐
3	Орон нутгийн чанартай замд өртсөн эсэх	☐	☐	☐	☐
4	Сүүрьшлын бүс, газар олголтод өртсөн эсэх	☐	☐	☐	☐
5	Жуулчны баазтай ойр эсэх	☐	☐	☐	☐
6	Хог хаясан эсэх	☐	☐	☐	☐
Нийт					

☐ 0-3 Сайн; ☐ 4-8 Дунд; ☐ 9-13 Муу; ☐ 14-18 Маш муу


7	Дэлгэрэнгүй мэдээлэл:
7	Мэдээллийн эх сурвалж:

2. Хадны зураг, тамга, тэмдэг, бичгийн дурсгал

Дурсгалын бүртгэлийн дугаар:												
------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Дурсгалын төрөл	
1	☐ Хадны сийлмэл зургийн дурсгал
2	☐ Хадны зосон зургийн дурсгал
3	☐ Тамга тэмдгийн дурсгал
4	☐ Бичгийн дурсгал
5	☐ Бусад

Гэмтлийн мэдээлэл					
№	Гэмтлийн төрөл	Гэмтэлгүй	10% хүртэл	10-50%	50%-с дээш
		0	1	2	3
1	Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон эсэх	☐	☐	☐	☐
2	Өгөршсөн эсэх	☐	☐	☐	☐
3	Хагарал, цууралттай эсэх	☐	☐	☐	☐
4	Биологийн бохирдолтой (Хаг, сангас, ургамал...г.м) эсэх	☐	☐	☐	☐
5	Эрдэсжилтэй (Хадан дээр шохойжилт үүссэн) эсэх	☐	☐	☐	☐
6	Өөх, тос түрхсэн (Хүний үйл ажиллагаа) эсэх	☐	☐	☐	☐
7	Будаж балласан (Хүний үйл ажиллагаа) эсэх	☐	☐	☐	☐
8	Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажиллагаа) эсэх	☐	☐	☐	☐
Тоон дүнгийн нэгтгэл:					
☐ 0-6 Сайн; ☐ 7-12 Дунд; ☐ 13-18 Муу; ☐ 19-24 Маш муу					



9	Дэлгэрэнгүй мэдээлэл:
	Мэдээллийн эх сурвалж:

10	Хэв хуулбар, дардас, 3D баримтжуулалт:	☐ Хэв хуулбар авсан
		☐ Дардас авсан
		☐ 3D баримтжуулалт хийгдсэн
		(Хэв хуулбар, дардас авсан, 3D баримтжуулалт хийсэн он, товч мэдээлэл, тайлангийн нэр ...г.м)
		
		
		


3. Хөшөө дурсгал (Буган чулуу, хүн чулуу, гэрэлт хөшөө)

Дурсгалын бүртгэлийн дугаар:													
------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Дурсгалын төрөл	
1	☐ Буган чулуун хөшөө
2	☐ Хүн чулуун хөшөө
3	☐ Гэрэлт хөшөө
4	☐ Амьтдын дүрст хөшөө
5	☐ Бусад

..... дугаар дурсгал

Гэмтлийн мэдээлэл					
№	Гэмтлийн төрөл	Гэмтэлгүй	10% хүртэл	10-50%	50%-с дээш
		0	1	2	3
1	Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон эсэх	☐	☐	☐	☐
2	Өгөршсөн эсэх	☐	☐	☐	☐
3	Хагарал, цууралттай эсэх	☐	☐	☐	☐
4	Биологийн бохирдолтой (Хаг, сангас, ургамал...) эсэх	☐	☐	☐	☐
5	Эрдэсжилттэй (хадан дээр шохойжилт үүссэн) эсэх	☐	☐	☐	☐
6	Хазайсан эсэх	☐	☐	☐	☐
7	Өөх, тос түрхсэн (Хүний үйл ажилагаа) эсэх	☐	☐	☐	☐
8	Будаж балласан (Хүний үйл ажилагаа) эсэх	☐	☐	☐	☐
9	Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажилагаа) эсэх	☐	☐	☐	☐
Тоон дүнгийн нэгтгэл:					
☐ 0-6 Сайн; ☐ 7-13 Дунд; ☐ 14-20 Муу; ☐ 21-27 Маш муу					
10	Дэлгэрэнгүй мэдээлэл:				
					
					
					
					
10	Мэдээллийн эх сурвалж:				
					
					
					
					
11	Хэв хуулбар, дардас, 3D баримтжуулалт:	☐ Хэв хуулбар авсан ☐ Дардас авсан ☐ 3D баримтжуулалт хийгдсэн			



4. Булш оршуулга, тахил тайлгын дурсгал

Дурсгалын бүртгэлийн дугаар:												
------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Дурсгалын төрөл	
1	☐ Булш оршуулга
2	☐ Тахил тайлгын дурсгал
3	☐ Бусад

Гэмтлийн мэдээлэл					
№	Гэмтлийн төрөл	Гэмтэлгүй	10% хүртэл	10-50%	50%-с дээш
		0	1	2	3
1	Аж ахуйн нөлөөлөлд өртсөн эсэх	☐	☐	☐	☐
2	Газар тариаланд өртсөн эсэх	☐	☐	☐	☐
3	Ухагдсан, тоногдсон эсэх	☐	☐	☐	☐
4	Хог хаясан эсэх	☐	☐	☐	☐
5	Булшны дараас чулуу газрын хөрсөнд дарагдсан эсэх	☐	☐	☐	☐
Тоон дүнгийн нэгтгэл:					
☐ 0-3 Сайн; ☐ 4-7 Дунд; ☐ 8-11 Муу; ☐ 12-15 Маш муу					

6	Дэлгэрэнгүй мэдээлэл:
	Мэдээллийн эх сурвалж:

[illegible]

5. Барилга, архитектурын дурсгал

Дурсгалын бүртгэлийн дугаар:

Дурсгалын төрөл	
1	☐ Эртний хотын туурь
2	☐ Сүм хийдийн туурь
3	☐ Сүм хийд
4	☐ Дурсгалт барилга
5	☐ Архитектурын дурсгал (Уран баримал хөшөө, Сүрлэг чимэглэлийн дурсгал г.м)
6	☐ Бусад

.....дурсгал

ГЭМТЛИЙН МЭДЭЭЛЭЛ					
№	Гэмтлийн төрөл	Гэмтэлгүй	10% хүртэл	10-50%	50%-с дээш
		0	1	2	3
1	Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон эсэх	☐	☐	☐	☐
2	Өгөршсөн эсэх	☐	☐	☐	☐
3	Хагарал, цууралттай эсэх	☐	☐	☐	☐

110

6. Палеонтологийн олдворт газар

Дурсгалын бүртгэлийн дугаар:											
------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Дурсгалын төрөл	
1	☐ Кайнозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд
2	☐ Кембрийн өмнөх цаг үе буюу архей протерозойн эриний олдворт газрууд
3	☐ Мезозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд
4	☐ Палеозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд

Гэмтлийн мэдээлэл					
№	Гэмтлийн төрөл	Гэмтэлгүй	10% хүртэл	10-50%	50%-с дээш
		0	1	2	3
1	Аж ахуйн нөлөөлөлд өртсөн эсэх	☐	☐	☐	☐
2	Газар тариаланд өртсөн эсэх	☐	☐	☐	☐
3	Орон нутгийн чанартай замд өртсөн эсэх	☐	☐	☐	☐
4	Суурьшлын бүс газар олголтод өртсөн эсэх	☐	☐	☐	☐
5	Дурсгалт (олдворт) газраас элс шороо авсан эсэх	☐	☐	☐	☐
6	Хог хаясан эсэх:	☐	☐	☐	☐
Нийт					
☐ 0-5 Сайн; ☐ 6-10 Дунд; ☐ 11-15 Муу; ☐ 16-21 Маш муу					
7	Дэлгэрэнгүй мэдээлэл:				
7	Мэдээллийн эх сурвалж:				



8	Сүүлийн 5 жилд тоногдсон тухай мэдээлэл	
Газрын нэр	Тайлбар (Хууль хяналтын байгууллагад мэдэгдсэн эсэх, авсан арга хэмжээ, он сар өдөр зэргийн талаар бичих)	



II БҮЛЭГ

БҮРТГЭН БАРИМТЖУУЛАХ АРГАЧЛАЛ






II.1. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТАНИЛЦУУЛГА


Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн үл мөр бүхий дурсгалт газар

Чулуун зэвсгийн дурсгалт газарт түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн аж төрж байсныг гэрчлэх чулуун зэвсэг, түүнийг хийхэд үлдсэн чулууны үлдэгдэл, хоол хүнсний үлдэгдэл болон бусад хүмүүсийн хэрэглэж байсан эд зүйлсийн үл мөр бүхий олдвортой (соёлт давхарга бүхий) дурсгалт газрыг хамруулдаг. Эртний хүмүүсийн тодорхой бүс нутагт аж төрж байсан цаг хугацааг шинжлэх ухааны ололтоор нарийн тогтоох боломж хомс байдаг учир тэдгээрийн хэрэглэж байсан зэр зэвсгийн онцлог, газрын хөрсөнд үлдсэн үл мөр зэргээр тоймлон авч үздэг. Судлаачид чулуун зэвсгийн үеийг

- Палеолит (хуучин чулуун зэвсэг),
- Мезолит (дунд чулуун зэвсэг),
- Неолит (шинэ чулуун зэвсэг) гэж гурван хэсэг болгон авч үздэг байна.



Хуучин чулуун зэвсгийн
үеийн дурсгалууд
(А.П.Деревянко нар., 2000)



Шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгалууд
(Б.Цогтбаатар нар., 2002)

1. Палеолит буюу хуучин чулуун зэвсгийн үе

Хуучин чулуун зэвсгийн үе нь Монгол нутагт одоогоос 800,000-12.000 жил үргэлжилсэн бөгөөд дотор нь:

- ♦ Доод үе 800.000–100.000 жил
- ♦ Дунд үе 100.000–40.000 жил
- ♦ Дээд үе 40.000–12.000 жил хэмээн 3 үе болгон ангилдаг.


2. Мезолит буюу дунд чулуун зэвсгийн үе

Дунд чулуун зэвсгийн үе нь одоогоос 12000-6000 жил хооронд үргэлжилсэн байдаг.

3. Неолит буюу шинэ чулуун зэвсгийн үе

Шинэ чулуун зэвсгийн үе нь 6000-3000 жил хооронд үргэлжилсэн байдаг.

Ийнхүү он цагаар зааглан авч үзэх гол үндэслэл нь эртний хүмүүсийн хэрэглэж байсан чулуун зэвсгийн хэлбэр хэмжээ, чулууны төрөл, хийсэн арга барил зэрэг нь өөр хоорондоо харилцан адилгүй



Илээр орших чулуун зэвсгийн дурсгалт газар (А.П.Деревянко нар., 2000)



байдаг шинж тэмдэг болно. Чулуун зэвсгийн бууц суурин, дархны газар байх газар нутаг нь уул нуруудын ам, энгэр эзвэр газар болон чулуун зэвсэг хийх тохиромжтой чулуулгийн баялаг илэрч бүхий газар нутгаар ихэвчлэн тохиолддог байна. Энэ нь хүмүүсийн цаг агаарын тааламжтай цаг хугацаанд тодорхой бүс нутагт суурьшин аж төрөхдөө тухайн газрын чулуулгийг ашиглан чулуун зэвсэг үйлдэж ахуй амьдралдаа хэрэглэхээс гадна үр жимс, ан гөрөө, зэрэг байгалийн баялгийг хүртэж байсантай холбоотой юм. Зарим тохиолдолд ялангуяа хад асганы нөмөр, агуйн хонгил зэрэгт хүний хөгжлийн хэд хэдэн үед холбогдох үе давхарга бүхий үл мөр илэрч мэдэгддэг ажээ. Чулуун зэвсгийн бууц суурингаас элдэв төрлийн чулуун зэвсэг, үр тарианы үлдэгдэл, мал амьтны яс, гал түлж байсан ор мөр зэрэг илэрч олддог бол дархны газраас чулуун зэвсэг хийх явцад үлдэж хоцорсон үлдцүүд ихээр олддог байна. Энэ төрлийн дурсгалт газраас олддог чулуун зэвсэг түүний үлдэгдлүүд нь хэдэн арваас хэдэн мянган ширхэг тоотойгоор илэрч мэдэгддэг ажээ. Чулуун зэвсгийн бууц, суурин, дархны газар нь хамрах газар нутгийн хувьд хэдхэн метр талбайгаас хэдэн арван км өргөн дэлгэр газар нутгийг хамрах нь ч бий.

Эртний хүний сууж байсан оромж, сууц, агуй

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн орогнож байсныг гэрчлэх олдвор бүхий агуй, нүхэн сууц зэргийг хамруулна. Чулуун зэвсгийн үеийн хүмүүс байгаль цаг уурын тааламжгүй нөлөө, болон араатан амьтдын дайралтаас биеэ хамгаалах зорилгоор хадны агуй, нөмөр нөөлөг бүхий байгалийн тогтоц бүхий газарт орж хорогддог байжээ.

Энэ нь эртний хүмүүсийн оюун ухаан хөгжихийн хэрээр



*Хуучин чулуун зэвсгийн үеийн сууц (сэргээсэн зураг)
(А.И. Мартынов., 2000)*

амьдралын нэг салшгүй хэсэг болж улмаар орон сууц үүсэх үндэс болсон ажээ. Байгалийн элдэв тогтоц бүхий газар хүмүүсийн хоргодон аж төрөх явдал чулуун зэвсгийн үеэр хязгаарлагдаж байсангүй. Хожмын соёлт хүн төрөлхтний элдэв шалтгаанаар тодорхой хугацаанд ийм газар оршин сууж байсан олон арван жишээг бид мэднэ. Энэ бүхэн нь бидний түүхийн нэгэн хэсэг болохынхоо хувьд анхааралгүй үлдээж үл болох дурсгалт газар болдог билээ. Эртний хүмүүсийн болон хожуу үеийн хүний оршин сууж байсан хадны агуй хонгил, нүхэн сууц зэргийн оршин байх газар нутаг нь байгалийн тогтцыг дагахаас гадна тухайн бүс нутгийн ан амьтан, үр жимсний бүрэлдэхүүн, усны хангамж, аюулгүй орчин зэрэг хүний хэрэгцээний бүх зүйлсийг харгалзан үзэж сонгосон байдаг. Хожуу үед хүмүүсийн оршин сууж байсан хадны агуй хонгилтой холбоотой олон арван үлгэр, домог, хууч яриа, хөдөө орон нутгаар элбэг байдаг бөгөөд энэ нь шашин мөргөлийн зан үйл, эрдэм чадалтай бөө, лам нарын намтар цадигтай холбоотой байх нь элбэг байдаг.

Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар

Төмөрлөг боловсруулалтын үл мөр

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн төмөрлөг олзворлож байсан уурхай болон түүнийг боловсруулж байсныг гэрчлэх үл мөр бүхий дурсгалт газрууд хамаарна. Төв Азийн өргөн уудам нутаг дээр эдүгээгээс тав гаруй мянган жилийн тэртээ төрж байсан хүмүүс хүрлийг гарган авч амьдрал ахуйдаа хэрэглэж эхэлжээ. Эртний хүмүүс хүрлийн агууламжтай хүдрийг уулын салхи ихтэй онги хөтөл дээр овоолон салхин талаас нь илч ихтэй мод, нүүрсны галаар хөөлгөн гарган авдаг. Үүнийг Монголын түүхэнд “Бух дарах арга” хэмээдэг. Манай ард түмэн төмөрлөгийн агууламжтай орд газрыг таньж мэдэн агуулагдах баялагийнх нь нэрээр нэрлэж ирсэн түүхэн уламжлалтай билээ. Тухайлбал Эрдэнэт, Оюу толгой, Төмөртэй, Зэст, Оюут, Эрдэнэхайрхан гэх мэт нэртэй газар орноос баялаг агууламжтай орд газрууд илэрдэг. Өгүүлэн буй дурсгалт газар



ихэвчлэн хөрсөн дороо төмөрлөгийн агууламжтай уулархаг газраар тохиолддог байна. Манай орны баруун, төв, өмнөд бүс нутгуудаас ийм төрлийн дурсгалт газар илэрч олддоод байгаагаас дурдвал Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгойн эртний зэсийн уурхай гэх мэт газруудыг нэрлэж болно. Төмөрлөг олзворлож байсан эртний уурхайн болон түүнийг боловсруулж байсныг гэрчлэх үл мөр бүхий дурсгалт газрууд нь ихэвчлэн төмөрлөгийн агууламжтай орд газруудтай давхцан оршдог учир уул, уурхайн зориулалтаар ашиглах газарт орж устгагдах аюултай байдаг.

Шавар боловсруулалтын үл мөр

Тодорхой түүхэн цаг үед хүмүүсийн шавраар ахуйн хэрэгцээний сав суулга, барилгын хэрэглэгдэхүүн зэрэг эд зүйлс хийж байсан болон хийсэн зүйлсээ шатаан боловсруулж байсан үл мөр бүхий дурсгалт газрууд хамаарна. Энэ төрлийн дурсгалт газар манай оронд олон биш илэрч мэдэгдээд байгаа боловч бидний өвөг дээдсийн түүх, соёл, аж ахуйн хөгжлийн талаар үнэтэй мэдээлэл агуулсан байдаг билээ. Шавар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан газар нь ихэвчлэн шатаах зуух хэлбэрээр илэрч мэдэгддэг ба тэндээс шатаасан болон түүхий барилгын дээврийн тосгуур, нөмрөг, нүүр, вааруудын үлдэгдэл, тоосго, шавар ваар, сав суулганы хагархай хэсгүүд зэрэг олддог байна. Судлаачид хүрэл зэвсгийн түрүү үеэс буюу одоогоос 5000-4000 жилийн тэртээгээс шавар сав суулгаа шатааж бэхжүүлэх арга технологийг Төв Азийн нүүдэлчин ард түмнүүд эзэмшсэн хэмээн тэмдэглэсэн байдаг. Шавар бүтээгдэхүүний шаварлагийн найрлага, хэлбэр хийц, бат бөх байдал зэрэг нь тухайн бүтээгдэхүүний цаг хугацааг тодруулах баримт болохоос гадна ямар ард түмний хийж бүтээсэн дурсгал болохыг гэрчлэх баримт болдог байна. Энэ төрлийн дурсгалт газрууд нь хамрах газар нутгийн хувьд их талбай эзэлдэггүй бөгөөд ихэвчлэн хот хэрмийн ойролцоо, томоохон гол мөрний шаварлаг хөрсийг даган байрладаг. Гэхдээ энэ төрлийн дурсгалт газруудын ашиглалтын байдал нь цаг зуурын шинжтэй байх нь их байдаг. Их Монгол улсын нийслэл Хархорум хотын үлдэгдлийг малтан

шинжлэх явцад барилгын материал шатааж байсан зуух илэрч олдсон бөгөөд энэ нь байнгын үйл ажиллагаатай байсан байна.

Газар тариалангийн ул мөр

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн газар хагалж, суваг шуудуу татах зэргээр тариалан эрхэлж байсныг гэрчлэх ул мөр бүхий газар нутаг хамаарна. Манай орны газар нутаг дээр эрт цагаас аж төрж ирсэн нүүдэлчин түмэн мал аж ахуй голлон эрхлэхийн зэрэгцээ газар тариаланг томоохон гол мөрний сав дагуух үржил шим бүхий газраар тариалан эрхэлж байсан нь сурвалжийн болон археологийн хэрэглэгдэхүүнээр гэрчлэгддэг. Судлаачид Төв Азийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн үеэс буюу эдүгээгээс тав гаруй мянган жилийн тэртээгээс зээтүүт тариалангийн эх үүсвэр тавигдсан гэж үздэг байна. Гэвч эх газрын эрс тэрс уур амьсгалтай монгол нутагт газар тариалан эрчтэй хөгжиж чадаагүй ажээ. Хүмүүсийн газар тариалан эрхэлж байсныг гэрчлэх ул мөр бүхий газрын хөрс нь тодорхой нэгэн цагт хүний гараар шулуун тууш хэдэн зуун мөр гарган хөндөгдсөн байдаг учир таньж мэдэхэд хялбар байдаг. Зарим тариан талбай руу томоохон гол мөрнөөс суваг шуудуу татаж усжуулсан байдаг. Манай оронд тохиолдож байгаа эртний хүмүүсийн тариа тарьж байсан талбайнууд нь ихэвчлэн Орхон, Сэлэнгэ, Туул, Хэрлэн, Онон, Ховд, Буянт зэрэг томоохон гол мөрний ай саваар байдаг. Гэхдээ эдгээр тариан талбайнууд нь бүгдээрээ нэг цаг үед холбогдохгүй учир хэлбэр хэмжээ, ил мэдэгдэх шинж зэргээрээ харилцан адилгүй. Жишээлбэл эртний шинж бүхий тариан талбайнууд нь хөрсөн дээрх ихэд баларсан мөрний шинжээрээ танигддаг бол хожуу үед холбогдох хагалсан тариан талбай нь харьцангуй дээрх шинж нь тод байдаг. Тариалан эрхэлж байсан газарт томоохон гол мөрнөөс суваг шуудуугаар дамжуулан ус татаж тариалангийн талбайгаа усжуулж байсан ул мөр их байдаг.



Хадны зураг, тамга, тэмдэг, бичгийн дурсгал:

Хадны зураг, тамга, тэмдэг, бичгийн дурсгалд байгалийн хад чулууны гадаргуу дээр ямар нэгэн тусгай багажийн тусламжтайгаар эртний хүмүүсийн аж байдал, ан гөрөө, нүүдэл суудал, дайн тулаан, шүтлэг бишрэл зэргийг араатан, жигүүртэн, тэрэг, зэр зэвсэг, тамга тэмдэг, хүний нүүр, баг, үйл хөдлөл зэргээр төлөөлүүлэн харуулсан зураг болон түүхийн олон үед хамаарах сийлмэл болон зос, бэхэн зураг, тамга тэмдэг болон бичээсийг хамруулна.

Сийлмэл зураг

Энэ төрлийн дурсгал нь манай орны бараг бүх нутгаас олон тоогоор илэрч мэдэгддэг төдийгүй Евразийн улс орнуудад ч тархсан тодорхой бүс нутгаар хязгаарлагддаггүй дурсгалын нэг юм. Хадны сийлмэл зургийн дүрслэл, зохиомж, сийлсэн арга барил, зэрэг шинжүүд нь харилцан адилгүй байх явдал нь холбогдох он цагийг тогтоох гол хэрэглэгдэхүүн болдог. Манай орны нутаг дэвсгэр дээр энэ төрлийн дурсгалыг судалсан




Хадны сийлмэл зураг
(А.П.Окладников., 1981)

эрдэмтэд сийлмэл зургийн хамгийн эртний зураг нь одоогоос хориод мянган жилийн тэртээд холбогдуулан авч үздэг. Хадны сийлмэл зурагт янгир ямаа, аргаль угалз, буга, адуу, үхэр, тэмээ, чоно, нохой, гахай, бар, могой зэрэг араатан амьтад дүрслэхээс гадна мал адгуулж, ан агнаж байгаа хүн, хоорондоо дайтаж байгаа хүмүүс, морь тэмээнд тэрэг хөсөг хэрэглэж буй хүн зэрэг хосолмол зургуудыг бодитоор болон загварчилсан санаа оруулан дүрсэлсэн байдаг.

Эдгээр зургуудын ойр орчинд элдэв төрлийн тамга тэмдэг, учир нь үл ойлгогдох дүрс, үсэг бичиг сийлж үлдээсэн нь олонтаа

тохиолддог. Хадны сийлмэл зургийг бүтээсэн хүмүүс тухайн зурагтаа дүрслэх амьтдынхаа бүх биеийг цоолборлож дүрслэхээс гадна амьтны биеийн гадаад хөвөөлөн цохиж дүрсэлсэн байдаг ба энэ хоёр аргыг хослуулан бүтээсэн ч цөөнгүй байдаг. Манай оронд илэрч мэдэгдээд байгаа хадны сийлмэл зургууд нь агуйн хана туурга, томоохон уул нуруудад байх хад чулууны толигор гадаргуу, голын хавцал дагасан хад чулуу, багавтар уул толгодын ургаа хад зэрэг газар ихэвчлэн тохиолддог. Гэхдээ дээр дурдсан хад чулууны сийлмэл зургууд нь нөмөр нөөлөг, нар дагасан энгэр газраар харьцангуй илүү байдаг. Хадны сийлмэл зургуудыг дан ганц эрт үед бүтээгдсэн байдаг гэж ойлгож болохгүй. Дундад зууны үе болон түүнээс хожуу үед ч зарим урлаачид хад чулуунаа элдэв зураг зурж үлдээсэн баримт нэлээд бий.



Хадны зургийг сийлсэн арга, барил (Ч.Болдбаатар., 2000)



Зос, бэхэн зураг

Манай оронд байгаа хадны зосон зургийг судалсан эрдэмтэд энэ дурсгалын үүслийг одоогоос хорь гаруй мянган жилийн тэртээ холбогдуулан үздэг байна. Зосоор зурсан зургийн зохиомж, зурсан арга барил, зурсан зос, зэргийн ялгаанаас хамаарч бүтээгдсэн он цагийн хувьд харилцан адилгүй байдаг ба энэ нь эртний хүмүүсийн оюун санааны хөгжил ямар төвшинд байсныг харуулах баримт болдог ажээ. Харин бэхээр зурсан зураг нь ихэвчлэн харьцангуй



*Хадны зосон зураг (Д.Дорж,
Э.А.Новгородова нар., 1975)*

хожуу буюу дундад зууны үед холбогддог байна. Манай оронд илэрч мэдэгдсэн зосоор зурсан зураг нь сийлмэл зургийн нэгэн адил агуйн хана туурга, томоохон уул нуруудад байх хад чулууны толигор гадаргуу, голын хавцал дагасан хад чулуу, багавтар уул толгодын ургаа хад зэрэг газар ихэвчлэн тохиолддог бөгөөд цөөн хэдээс эхлээд хэдэн зуу мянгаар тоологдох дүрслэлтэй байдаг.

Зосоор зурсан дүрслэгдсэн мал амьтныхаа тооноос хамаарч уг дурсгал орших газар хэдэн зуун метр хүртэлх талбайг хамрах нь байдаг бол бэхээр зурсан зураг нь тооны хувьд цөөн дүрслэлтэй эзлэх талбайн хувьд харьцангуй бага талбайг эзэлдэг. Улаан зос ашиглаж янгир, ямаа, буга, тэмээн хяруул, арслан заан, адуу, үхэр, тэмээ, шувуу, мал амьтан адгуулж байгаа хүн, ан агнуур хийж байгаа хүмүүс, тариан талбайд (зарим судлаачид ийм төрлийн зургуудыг оршуулгын газар гэдэг) ажиллаж байгаа хүмүүс, зэргийг зурсан байх бөгөөд мал амьтны биеийн гадаад хэлбэр, онцлогийг харуулахын тулд хөвөөлөн зурахаас гадна бүх биеийг нь нэлэнхийд нь будаж дүрслэх хоёр аргыг хослуулан хэрэглэсэн байдаг. Харин бэх ашиглаж зурсан зургууд нь тухайн дүрсэлж буй зургийнхаа утга агуулгад




*Хадан дээр уралсан Бурханы хөрөг зураг
(Түүх, соёлын..., 2017)*

нийцүүлэн хөвөөлөн зурахаас гадна бүх биеэр нь өнгө ялган зурсан тохиолдол ч байдаг. Зарим тохиолдолд хад чулуунд бурхад зэргийн дүрсийг сийлж гаргаад дараа нь өнгөөр ялган зурсан зураг байдаг. Ийм төрлийн дурсгал нь Монголд XVI зуунд нэвтэрсэн шарын шашны бурхны урлалтай нягт холбоотой байдаг.

Тамга, тэмдэг, бичгийн дурсгал

Тамга, тэмдэг, бичгийн дурсгалд байгалийн тогтцоороо байгаа хад чулууны толигор гадаргуу дээр овгийн тамга, болон тодорхой үсэг бичгийг ашиглан зос, бэх болон сийлбэрлэн гаргасан бүх төрлийн тамга тэмдэг, бичгийн дурсгалыг хамааруулна.

- ♦ Тамга, тэмдэг
- ♦ Бичгийн дурсгал
 - Түрэг
 - Уйгур
 - Кидан




- Монгол
- Тод
- Дөрвөлжин
- Манж
- Согд
- Араб
- Перс
- Санскрит
- Төвд
- Хятад

Тамга тэмдгийн бүтээгдсэн он цагийг нарийн тогтоох боломж хомс байдаг ч овгийн байгуулал задарч хувийн өмч үүссэн үед бий болсон гэж ихэнх эрдэмтэд үздэг ажээ. Харин бичиг үсгийн хувьд эртний монголчуудын бичиг үсэг үүсгэн хэрэглэж байсан үүх түүхтэй холбоотой байдаг учир бичигдсэн он цагийг тогтооход элдэв бэрхшээл учрах нь бага байдаг ажээ. Монгол нутгаар ганц нэгээр болон хэдэн арав, зуугаар тохиолдох тамга тэмдгүүд нь ихэвчлэн хад чулууны толигор гадаргуу дээр, тал хээр тохиолдох ургаа чулуун дээр, зарим багавтар толгодын хад чулуун дээр, хавцлын ханан дээр, агуйн хана туурга дээр сийлэгдэж, зурагдсан байдаг бөгөөд дүрслэлийн хувьд геометрийн үндсэн дүрс болох дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсүүд түүнийг баяжуулсан олон хэлбэр дүрс байхаас гадна хожмын монголчуудын дунд үлдсэн малын тамгатай ижилсэх тамга, дүрсүүд цөөнгүй байдаг. Хад чулуун дээрх бичиг үсгийн дурсгал нь сийлэх ба бэхээр бичих гэсэн хоёр аргаар үйлдэгдсэн байдаг байна. Монголчууд бичиг үсэг хэрэглэж хад чулууны толигор гадаргуу зэрэг бичиг үлдээж болох хад чулуунаа түүхэн хэрэг явдлын тухай болон элдвийн ерөөл үгс сийлсэн байх нь олонтаа тохиолдоно. Ийм бичээсүүдийг Монгол бичиг, дөрвөлжин үсэг, тод бичиг зэргээр үйлдсэн байдаг. Мөн Монголчуудын зохиосон бичиг үсгээс гадна түүхэн тодорхой үед харилцаж байсан Түрэг, Уйгур, Хятан, Хятад, Манж, Согд, Араб, Перс, Санскрит, Хятад зэрэг үсэг, бичгээр бичсэн

бичээсүүд ч олон бий. Ялангуяа дорно дахины шинжлэх ухааны хэл гэж нэрлэгдэж байсан Төвд үсгээр бичигдсэн шашны холбогдолтой “Ум ма ни бад ми хум” гэх мэт тарнийн үгтэй бичээсүүд цөөнгүй газарт бий.

Руни бичгийн дурсгал

Эртний Түрэгүүд Орхон-Енисейн буюу Руни бичиг хэмээн алдаршсан 38 үсэг бүхий авианы бичгийг хэрэглэж, төр улсынхаа түүхийг тэмдэглэн бичиж үлдээсэн байдаг. Тухайн үеийн нүүдэлчид Нангиад



Эртний руни бичиг (Л.Болд., 1990)

мэт улс оронтой хөрш зэргэлдээ нутаглаж соёлын ололт амжилтаас нь багагүй зүйл авч хэрэглэсэн боловч дүрс үсгийг авсангүй, харин өөрсдийн ахуй орчин, хэл соёлын өвөрмөц онцлогт тохирсон оюуны хэрэгцээ шаардлагыг хангахуйц бичиг үсгийг зохион хэрэглэж байжээ. Руни бичиг хаанаас гаралтай болох талаар судлаачид нэгдмэл саналд хүрээгүй байна. Ихэнх судлаачид үүнийг эртний арамей бичгээс үүсэлтэй, түүний хамгийн зүүн захын нэгэн салбар гэдэг. Гэтэл үүний зэрэгцээ, руни бичиг нь Төв Азийн нүүдэлчдийн дунд эртнээс уламжилж ирсэн овог аймгийн тамга тэмдэг, мод хэрчиж хэрэг тэмдэглэх арга зэргээс уламжлан үүссэн гэж үзэх нь бас бий. “Орхон-Енисейн буюу руни бичиг” нь зөвхөн гаднаас хуулбарлаж авсан бус, харин орон нутгийн хуучин уламжлалд тулгуурлан гарч ирсэн нь тодорхой хэмээн манай зарим судлаачид үздэг ажээ.

Энэхүү бичиг нь VII зууны хоёрдугаар хагаст үүсч улмаар XII зууныг хүртэл Эртний Түрэг овог аймгуудын тархан нутагласан бүх газар нутагт түгэн дэлгэрсэн байжээ. Тухайлбал Енисейн мөрний сав газар болон Орхон голын саваас хамгийн олон дурсгал илэрч олдсон учраас Орхон-Енисейн бичиг хэмээн алдаршжээ. Түрэгийн руни бичгийн дурсгал нь тусгайлж зассан пайлуур гэрэлт хөшөөнөөс




гадна байгалийн ердийн хад чулуун дээр одоогоор нийт 80 орчим дурсгал олдсоноос гадна барилгын хананы шаваас, дээврийн ваар, зоос мөнгө, судар номын баринтагийн тээг чулуун дээр бичсэн зэрэг олон хэлбэрээр олдож байна.

Монгол бичгийн дурсгал

Монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл бичиг үсгийн тогтолцоо нь түүхийн туршид нийгэм, соёлын шалгаруулалтаар шүүгдэж монгол хэл, аялгууны шаардлагад хамгийн зохистой нийцсэн нь ялгарч нийт монголчуудын хүртээл болсоор ирсэн билээ.

Эдгээрийн дотроос орон зайн хувьд хамгийн өргөн дэлгэр тархсан нийт монголчуудын дунд хамгийн урт удаан тогтвортой хэрэглэгдэж ирсэн нь Монгол бичиг болно. Уг бичиг нь үсэг зүйн хувьд монгол хэл, түүний нутаг нутгийн аялгууны онцлогт бүрэн зохицож нийт монгол туургатныг хэл болон бичгийнх нь хувьд нэгтгэж өгөхийн сацуу монгол хэлний аливаа аялгууны онцлогийг эрх тэгш хадгалан хөгжүүлэх бололцоог жигд хангаж чадсанд оршино хэмээн манай судлаачид тэмдэглэсэн байдаг. Монгол бичгийн гарлын тухайд Арамей гаралтай Согд үсгээс үүсэлтэй гэж судлаачид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг боловч цаг хугацааны хувьд чухам хэдий үед зохиогдсон талаар санал хуваагдсаар иржээ. Манай орны хөдөө хээр нутаг болон эртний хот суурины орчмоос хөшөө чулуунд болон




Монгол бичиг (А.Очир., 2011)

хад чулуунаа сийлж эсвэл бэхээр бичсэн монгол бичгийн дурсгалууд цөөнгүй илэрсэн байдаг.

Төвд бичгийн дурсгал

Монгол орны нутгаас түгээмэл олддог бичгийн дурсгал нь төвд бичиг юм. Төвд бичгээр байгалийн хад чулуу болон гэрэл хөшөөн дээр сийлж болон бэхээр бичсэн байдаг.



Төвд бичиг

Буддын номонд бурханы номыг харах, сонсох, хуулж бичих зэрэг бүгд буянтай хэмээн үздэг аж. Иймд тарни бичсэн газар элдэв муу зүйл бага болдог гэж хэлдэг. Нэг төрлийн засал болдог хэмээн үздэг байжээ. Энэ үүднээс эртнээс хөдөө орон нутагт маанийн зургаан үсэг, язгуур олноор сийлдэг байжээ.



Завхан аймгийн Алдархаан сумын Ширээгийн өвөлжөөний төвд бичиг



Хөшөө дурсгал

Хөшөө дурсгал (Буган чулуу, хүн чулуу, гэрэлт хөшөө)-д түүхэн тодорхой цаг үед зан үйл, шүтлэг бишрэл, түүхэн тэмдэглэлт үйл явдалд зориулан босгосон түүх, урлагийн үнэ цэнэ бүхий бүх төрлийн хөшөө дурсгал хамаарна.

Манай улсад түүхийн олон үед холбогдох олон төрлийн хөшөө дурсгал бий. Эдгээрээс хүрэл зэвсгийн үед холбогдох буган чулуун хөшөө болон хүн чулуун хөшөө, үсэг бичиг, тамга тэмдэг сийлсэн хөшөөд болон элдэв амьтадыг дүрсэлсэн чулуун хөшөөд түгээмэл.

Буган чулуун хөшөө

Байгалийн гонзгой урт чулууг засч янзлан (зарим тохиолдолд засаагүй байдаг) дээд хэсэгт нар сар, дунд хэсгээр буга, доод хэсгээр нь бүс, зэр зэвсэг сийлж цоолборлож гаргасан хөшөө дурсгалыг хамруулдаг. Монгол болон хөрш зэргэлдээ ОХУ-ын Буриад, Тувагийн



Саян-Алтайн
амьтны “бодит”
дүрст буган хөшөө
(Түүх, соёлын., 2017)



Монгол-Өвөрбайгалийн
бугын загварчилсан
дүрст буган хөшөө
(Түүх, соёлын., 2017)



Саян-Алтайн
амьтны “бодит”
дүрст буган хөшөө
(Ц.Төрбат нар., 2010)

нутгаар 700 орчим илрээд байгаагаас манай оронд 550 орчим нь байдаг ажээ. Эдгээр буган хөшөөд нь ихэвчлэн 1-4 м өндөр, 20-50 см зузаан, 30-80 см өргөнтэй байх ба зарим хөшөөдийн ойр орчимд тооны хувьд харилцан адилгүй хэмжээтэй дугуй чулуун дараас бүхий тахилын байгууламж байдаг. Буган чулуун хөшөөг судалсан судлаачид уг дурсгалыг бугыг загварчилсан байдлаар дүрсэлсэн, амьтны бодит байдлаар дүрсэлсэн, амьтны дүрслэлгүй гэж ерөнхийд нь гурав ангилан авч үздэг байна.

- Эхний төрөлд хамаарах буган хөшөөдийн ихэнх нь Монгол болон Өвөрбайгалийн нутгаар байдаг бөгөөд бугыг дээш дүүлж байгаар загварчлан дүрсэлж сийлсэн байдаг
- Хоёр дахь төрөлд хамаарах хөшөөдийн гадаргуу дээр адуу, зээр, гахай, шувуу зэрэг амьтдыг бодит байдлаар дүрслэн сийлсэн байдаг ажээ.
- Гурав дахь төрлийн хөшөөд нь гадаргуу дээрээ ямар нэг амьтны дүрс байхгүй ч буган чулуун хөшөөний нийтлэг дүрслэл болох нар сар, бүс, тагнай хээ бүхий бамбай, толь, зэр зэвсгийг сийлсэн байдаг байна.

Бугыг бодит байдлаар дүрсэлсэн болон дүрслэлгүй хөшөөд нь манай улсын нутаг дэвсгэрт цөөн тоотойгоор тохиолддог байна. Уг дурсгалын гадаргуу дээр дүрсэлсэн нар, зарим бүсний дүрсийг ихэвчлэн хүрээлэн сийлсэн байдаг бол толь, кинжаал хутга, буга болон амьтны дүрсийг бүх биеийн хэсгээр нь цохин дүрсэлсэн байдаг. Буган чулуун хөшөөг хэд хэдээр нь нэг дор босгосон байх ба дөрвөлжин булш (зарим тохиолдолд буган хөшөөг булшны нүхэнд хана болгон хэрэглэсэн байдаг), хиргисүүр зэрэг хүрэл зэвсгийн үеийн томоохон соёлууд зэрэгцэн оршсон цогцолбор дурсгал бүхий газар манай оронд цөөнгүй тохиолддог.



Хүн чулуу


- ♦ Хүрэл
- ♦ Түрэг
- ♦ Уйгур
- ♦ Кидан
- ♦ Монгол
- ♦ Тодорхойгүй

Дээрх төрөл зүйлийн аль нэгэнд тохирохгүй бүх дурсгалын оруулна. Түүхэн тодорхой цаг үед зан үйл, шүтлэг бишрэл, түүхэн тэмдэглэлт үйл явдалд зориулан босгосон түүх, урлагийн үнэ цэнэ бүхий бүх төрлийн хөшөө дурсгал хамаарна. Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгаа хүн чулуун хөшөөдийг бүтээгдсэн он цаг, дүрслэл, онцлогоор нь хүрэл зэвсгийн үе болон Түрэг, Монголын хүн хөшөөд гэж ялгаж авч үздэг. Түрэгийн хүн чулуун хөшөөд нь манай орны төвийн болон баруун аймгийн нутгаар элбэг тохиолддог бол Монголын хүн чулуун хөшөөд нь ихэвчлэн зүүн бүсийн аймгуудын нутгаар тохиолддог. Хүн чулуун хөшөөдөд хүний биеийн ерөнхий хэлбэрийг гаргасан нийтлэг шинжтэй байдаг боловч тухайн хөшөөг хийж бүтээсэн ард түмний ур хийц, дүрслэлийн онцлог шинжүүдээрээ ялгаатай байдаг.

Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө:

Түрэгийн хүн хөшөөдөд хүний нүүрийн хэсгийг хавтгайдуу гарган нүд хамар амыг мэдэгдэхүйцээр сийлж эрэгтэй хүнийг илтгэх сахлыг дүрсэлсэн байдаг. Баруун гартаа аяга, сав барин энгэртээ авч, зүүн гараараа бүснээс зүүсэн хутга, сэлэмний ишнээс барьсан байдалтай дүрсэлсэн байдаг. Мөн дээлийн энгэрийг ихэвчлэн буруу зөрүүлж дүрсэлсэн байхаас гадна товруун чимэг бүхий бүснээс хавтага, билүү зэргийн зүйлсийг унжуулсан байдалтайгаар дүрсэлсэн байдаг. Эдгээр нь Түрэгийн хөшөөдийн нийтлэг шинж юм. Энэ хөшөөд нь хөдөө орон нутагт ганц хоёроор тохиолдохоос гадна томоохон тахилга тайлгын онгоны бүрэлдэхүүнд орсон байдалтайгаар тохиолддог

байна. Зарим тохиолдолд Түрэгийн үеийн булш, тахил тайлгын байгууламжийн зүүн урд эгнүүлэн босгосон зэл чулуунд ч тааралддаг. Монголын үеийн хүн чулуун хөшөө: Монголын хүн хөшөөд нь Түрэгийн хүн хөшөөдийг бодвол илүү бодит дүрслэл сайтай урласан байхаас гадна хүнийг исэр дээр суулгасан байдлаар дүрсэлсэн байдаг байна. Монголын хүн хөшөөнд хүнийг баруун гартаа аяга, сав барьж энгэртээ аван зүүн гараараа сандлын түшлэгийг тохойлдсон зарим тохиолдолд өвдөг дээрээ тавьсан байдлаар дүрсэлсэн байдаг. Хөшөөнд дүрсэлсэн дээлийг ихэвчлэн зөв энгэртэй байдлаар дүрсэлж нэлээд



Түрэгийн үеийн
хүн чулуун хөшөө
(Түүх, соёлын., 2017)

хэлхэгэр том гэсэн санаа оруулан дүрсэлсэн байдаг нь Түрэгийн хүн чулуун эдийн хувцаснаас ялгаатай байдаг. Мөн хөшөөнд хүний толгой дээр малгай өмсгөсөн байхаас гадна дээлийн хормойн доод хэсгээр гутлын дүрсийг гаргасан байдаг. Монголын үеийн хүн хөшөөдийн өөр нэг онцлог бол маш уран нарийн аргаар жижиг дүрслэлүүдийг гаргасанд оршино. Жишээлбэл сандал исрийн хийц түүнийг чимэглэсэн хээ угалз, хүний үсний хэлбэр зэргийг гайхалтай урласан байдаг. Монголын хүн хөшөөд нь монгол орны зүүн бүс нутагт хүний нүдэнд ил мэдэгдэх газар чулуун овоолго дээр байрладаг.

Зарим тохиолдолд ойр орчиндоо ямар нэг дагуул дурсгалгүй ганцаар орших нь ч бий. Сүүлийн үеийн судалгаагаар дээр өгүүлсэн хоёр төрөл хүн хөшөөний аль нэгтэй нь үл ижилсэн өвөрмөц хийцийн хөшөөд монгол нутгаас цөөнгүй олдож байгаа билээ.



08-09-11 №31
0 Судлаачид – Даргачид 50
Анхны хүн үзүүл.

Монголын үеийн хүн чулуун хөшөө
(Түүх, соёлын., 2017)


Судлаачид эдгээр хөшөөдийн хэлбэр хийц, дүрслэгдэхүүн нь Түрэгийн хүн хөшөөдийн дараа үеийн шинжийг агуулсан гэж үзээд Уйгарын үед холбогдуулж байна. Ийм хөшөөд нь ихэвчлэн хоёр гараараа сав барьж цээжиндээ авсан байдалтай дүрслэгдсэн байх бөгөөд элдвийн зэр зэвсгийн дүрслэлгүй байх ажээ. Мөн хөшөөний толгойд дүрсэлсэн малгай нь Түрэг, Монголын хөшөөдийн алинтай н нь ч ижилсэх шинжгүй байна. Мөн Булган аймгийн Сэлэнгэ сумын Ингэт толгойн өвөрт байх нэгэн хүн хөшөөг судлаачид Киданы үед холбогдуулан үздэг. Энэ хөшөөний гол онцлог нь хувцасны дүрслэлд байх бөгөөд их хэлхэгэр дээлийг өргөн ханцуйтайгаар дүрсэлж, оройн хэсэгт үсийг овоолон боож малгайгаар дарсан байдалтай дүрсэлжээ. Энэ шинж нь Киданчуудын дунд өргөн дэлгэрсэн бомбын шашны хувцас хэрэглэлтэй адил байдаг ажээ.

Тамга тэмдэгтэй хөшөө чулуу

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн байгалийн чулууг засч янзлан гадаргуу дээр нь ямар нэг тамга тэмдэг сийлж үлдээсэн хөшөөд хамаарна.

Гэрэлт хөшөө

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн том чулууны дөрвөн талыг тэгшлэн засаад, яст мэлхийн хэлбэртэй суурь дээр тогтоон эртний түрэг, хятад бичээс бичсэн сүрлэг хөшөөд хамаарна. Ихэнх гэрэлт хөшөөд манай улсын төв ба баруун аймгийн нутагтаас илэрч олддог. Хөшөөний бичээсийн агуулгаас он цаг нь тодорхой байдгаас хэзээ хэнд зориулан босгосон нь мэдэгддэг. Түргийн үеийн язгууртаны гэрэлт хөшөөд хүн чулуун хөшөө, чулуун хавтан, амьтадын дүрстэй хөшөөд, зэл чулуу зэргийг нэг дор багтаасан цогцолбор байдалтай байдаг бол уйгурын үеийн гэрэлт хөшөө дангаар байдаг онцлогтой. Мөн ийм гэрэлт хөшөө босгох уламжлал Монголын эзэнт гүрний үед ч байсан бөгөөд энэ үед холбогдох томоохон суурин газар, хүрээ хийд болох Эрдэнзуугийн хэрмэн дотор байдаг. Хожим шарын шашин дэлгэрэх үед зарим гэрэлт хөшөөд дээр төвд, ланз үсэг сийлсэн нь цөөнгүй тохиолдоно.



*Руни бичээст гэрэлт хөшөө
(Provisional ..., 1999)*



Амьтны дүрслэлтэй хөшөө

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн амьтан эрхэмлэх зан үйлтэй холбоотойгоор байгалийн чулууг засч янзлан амьтны дүрс гарган урлаж хийсэн чулуун дурсгалууд хамаарна. Манай улсын нутагт энэ төрлийн дурсгал цөөнгүй тохиолддог бөгөөд харилцан адилгүй цаг хугацаанд бүтээгдсэн ч дорнын ард түмнүүдийн эрхэмлэдэг амьтнаа урлах нийтлэг шинжийг агуулсан чулуун арслан, яст мэлхий, хонь зэрэг дурсгалууд байдаг. Гэхдээ эдгээр дурсгалууд нь томоохон цогцолбор дурсгалын бүрэлдэхүүнд бүтээгдсэн



*Амьтны дүрслэлтэй хөшөө
(Provisional ..., 1999)*

байдгаараа онцлогтой. Чулуун арслангийн хувьд томоохон сүм хийд, хэрмийн хаалганы хоёр талд элдэв муу бүхнээс сэргийлэх гэсэн санааны илэрхийлэл болон байрладаг бол чулуун мэлхий нь урт удаан нас, энх амгалангийн илэрхийлэл болон хот суурины орчим бүтээгдсэн байдаг. Чулуун хонь нь ихэвчлэн Түрэгийн үеийн цогцолбор дурсгалын бүрэлдэхүүнд багтдаг. Чулуун хонь, мэлхий зэрэг дурсгалыг амьдчилан урлаж байсан нь хөдөө орон нутгаар тохиолдох энэ төрлийн дурсгалын гадаад төрх байдлаас харахад илэрхий байдаг. Эдгээр дурсгалыг хөлөө эвхэн хэвтэж толгойгоо өргөсөн байдалтай урласан байдаг бол чулуун арсланг сүр бараа оруулсан загварчлан суугаа байдлаар урладаг байжээ. Манай орны нутагт байгаа энэ төрлийн дурсгалууд нь үл хөдлөх дурсгалын үл хөдлөх дурсгалын хүрээнд хамрагддаг боловч зарим тохиолдолд анхны байрлалаасаа зөөгдөх зэргээр түүхэн үнэ ач холбогдлоо алддаг эмзэг дурсгал болно.

Цулгүй хөшөө

Байгалийн чулууг засаж янзалалгүйгээр ямар нэгэн түүхэн үйл явдал, зан үйл, шүтлэг бишрэлийн агуулгатай босгосон хөшөө чулуудыг хамааруулна.

Бусад

Дээрхи төрөл зүйлийн аль нэгэнд тохирохгүй бүх дурсгалын оруулна.

Булш оршуулга, тахил тайлгын дурсгал:

Булш оршуулга, тахил тайлгын дурсгалд түүхэн тодорхой цаг үед хүмүүс талийгаач болсон хүний бие цогцыг тусгай зан үйлийн дагуу, мод, чулуу, шороогоор дарж (хадны оршуулга) үйлдсэн бүх төрлийн эртний булш хамаарна. Тахил тайлгын байгууламж нь оршуулгын ёслол, хойд насанд зориулж эсвэл байгаль дэлхийгээ аргадах зорилгоор зан үйл гүйцэтгэн хийж бүтээсэн тахилыг байгууламжууд, түүний бүрдэл хэсгүүд болох хашлага, зэл чулуу, овоо зэрэг хамаарна.


- ♦ Неолитын булш
- ♦ Шоргоолжин булш
- ♦ Хиргисүүр
- ♦ Дөрвөлжин булш
- ♦ Пазырык булш
- ♦ Хүннү булш
- ♦ Түрэг булш
- ♦ Уйгур булш
- ♦ Хятан булш
- ♦ Монгол булш
- ♦ Хадны оршуулга
- ♦ Бусад




Дээрх төрөл зүйлийн аль нэгэнд тохирохгүй бүх дурсгалын оруулна.

Монгол нутагт анх шинэ чулуун зэвсгийн үед хүмүүс оршуулга үйлдэж эхэлсэн бөгөөд хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр, дөрвөлжин булш, шоргоолжин булш гэх мэт хэд хэдэн хэлбэртэй байдаг. Мөн энэ үеэс хойш монгол нутагт аж төрж байсан эртний нүүдэлчид, Хүннү, Уйгар, Кидан, Монголчууд талийгаачдаа тусгай зан үйлийн дагуу оршуулж байв. Манай оронд байгаа булш, оршуулгууд нь ихэвчлэн уул, толгодын энгэр газар, тэгш дэвсэг, гол мөрний ай саваар тохиолддог ба хадны оршуулга нь чулуу ихтэй уул нуруудаар байдаг ажээ. Хүрэл зэвсгийн үеийн хүмүүс чулуугаар том хэмжээний чулуун овоолго үйлдэж, түүнийхээ гадуур хүрээ татаж олон жижиг дугуй чулуун байгууламж дагалдуулан бүтээсэн бүх төрлийн хиргисүүрийн байгууламжууд хамаарна.

Төв Азийн газар нутгаар судалгаа хийсэн археологичид энэхүү дурсгалыг дөрвөлжин булш, буган чулуун хөшөөний нэгэн адилаар хүрэл зэвсгийн үеийн томоохон соёлын төвшинд авч үздэг билээ. Хиргисүүр нь ихэвчлэн нүдэнд үзэгдэх тэгш тал газар, гол мөрний ай сав, уул толгодын оройн дэвсэг газар, энгэр ээвэр газраар байх нь нэн элбэг бөгөөд ганц хоёр, хэдэн арваараа зэрэгцэн оршдог байна.



*Дугуй хүрээтэй хиргисүүр, дагуул байгууламж
(Түүх, соёлын..., 2017)*




Монголоос олдсон хиргисүүрийн хэлбэрүүд
(Ю.С.Худяков., 1987)

Мөн манай орны баруун болон төвийн нутгаар хүрлийн үеийн дөрвөлжин булш, буган чулууны дурсгалуудтай хамт нэг талбайд оршиж байх тохиолдол бий. Манай улсын нутагт явуулсан хиргисүүрийн малталгаас ихэвчлэн хүний оршуулга бүхий үл мөр илэрсэн бол бусдаас нь мал амьтны шатаасан болон шатаагаагүй яснууд, чулуун зэвсгийн үлдэгдэл, хүрэл товруу, товч, хутга, ваар савны хагархай хэсэг зэрэг эд өлгийн зүйлс илэрч мэдэгдэж байжээ. Хиргисүүр нь голдоо хэдэн мянган чулуун дараас бүхий овоолготой, овоолгоо тойрсон чулуу эгнүүлэн тавьсан дугуй, дөрвөлжин хүрээтэй, хүрээний гадуур хэмжээгээр багавтар чулуун дараас бүхий дагуул байгууламжаас бүрддэг цогцолбор дурсгал юм. Голдуу 2-3 метр диаметртэй багавтар чулуун дараас бүхий дагуул байгууламж нь голын том овоолгын зүүн, зүүн урд талаар Эдгээр дагуул байгууламжууд нь тухайн хиргисүүрийн голын овоолгын зэргээс шалтгаалан тооны хувьд харилцан адилгүй байдаг. Хиргисүүрийн




байгууламжаас адууны толгой, туурай, хүзүүний ясыг амьдчилан тавьсан ажээ. Хиргисүүрийн байгууламжийн голын чулуун дараасны зүүн урд хэсэгт буган хөшөө юм уу эсвэл нар сар сийлсэн цулгай хөшөө босгож тавьсан тохиолдол цөөнгүй илэрч мэдэгджээ. Мөн хүрэл зэвсгийн үеийн гол дурсгал дөрвөлжин булш юм. Манай орны зүүн болон төвийн нутгаар түгээмэл орших бөгөөд жижиг толгодын орой шил, даваа хөтөл дээр ганц нэг, хоёр гурваараа тохиолдохоос гадна тэднийг гол төлөв уулын энгэр, бэл, аманд мөн тэгш талын дунд нэг дор арваас хэдэн арав хүртэл тоотой хэсэг бүлгээр тохиолдоно.

Дөрвөлжин булшийг том зузаан хавтгай чулууг эгнүүлэн дөрвөлжилөн газарт зоож, гадна, дотор хаяаг жижиг чулуудаар дарж бэхэлсэн байх бөгөөд зарим дөрвөлжин булш дөрвөн буландаа хашлаганаас өндөр хөшөө чулуутай байдаг. Булшнд хайрцаглан хийсэн нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ оршуулж, зарим тохиолдолд бод, бог малын зарим яс, ваар савны хагархай, ясан нумын хэсгүүд, хүрэл эдлэлүүд дагалдуулсан байдаг. Судлаачдын дөрвөлжин булшны төрөлд оруулдаг дөрвөн тал нь дотогшоо хотгар ханатай булшийг шоргоолжин булш хэмээн нэрэлдэг. Тус булш манай орны говь талын бүс нутгаар тааралдах бөгөөд дөрвөлжин булштай



*Дөрвөлжин булшны дөрвөн талын хашлага жигд намхан хэлбэр
(А.Д.Цыбиктаров., 1998)*



*Дөрвөлжин булшны дөрвөн буландаа босоо чулуутай хэлбэр
(А.Д.Цыбиктаров..., 1998)*

ойролцоо газарт тохиолдоно. Шоргоолжин булшинд ихэвчлэн газрын хөрсөнд талийгчыг түрүүлгэ нь харуулан оршуулсан байдаг бөгөөд эд өлгийн зүйлс маш цөөн гардаг.

Монгол нутаг дахь булш оршуулгын (хадны оршуулгыг эс тооцвол) гадаад хэлбэр зохион байгуулалтаараа харилцан адилгүй байдаг. Монгол нутагт анхны төрт улсыг байгуулсан Хүннүгийн жирийн иргэдийн булш голдоо ухагдсан гэмээр ул мөртэй дугуйран хүрээлсэн чулуун дараастай байдаг бол Монголын үеийн булш оршуулгуудын хөрсөн дээрх чулуун дараасны хэлбэр зууван дугуй байдаг байна. Түрэгийн булш оршуулгууд нь ихэвчлэн дугуй хэлбэртэй чулуун дараастай, зүүн урд чигт босгосон олон тооны балбал (зэл чулуу) чулуугаараа ялгагддаг байна. Эртний булш оршуулгууд нь түүхийн тодорхой үед хүмүүсийн гараар хөндөгдөж анхны хэлбэр төрхөө алдан тоногдсон байх нь түгээмэл. Зарим булш оршуулга маш том хэмжээтэй байх нь бий. Манай улсад байгаа Хүннүгийн үед холбогдох булш оршуулгын дурсгалыг жирийн иргэдийн, язгууртны гэж 2 ангилан авч үздэг.




*Хүннүгийн жирийн булшны дараас
(Түүх, соёлын..., 2017)*

Язгууртны булш нь газрын хөрсөн дээр дөрвөлжлөн өрсөн чулуун өрлөгтэй, урд хэсэгтээ трапец хэлбэрийн үүдэвчтэй чулуун томоохон байгууламж байдаг. Хадны оршуулга нь ихэвчлэн санамсаргүй байдлаар хад чулууны завсар чөлөө, агуй хонгилоос илэрч олдцог ба одоогоор манай оронд цөөн тоогоор илэрч олдоод байгаа өвөрмөц дурсгал юм.

Тахил тайлгын байгууламж нь оршуулгын ёслол, хойд насанд зориулж эсвэл байгаль дэлхийгээ аргадах зорилгоор зан үйл гүйцэтгэн хийж бүтээсэн тахилыг байгууламжууд, түүний бүрдэл хэсгүүд болох хашлага, зэл чулуу, овоо зэрэг хамаарна.

- ♦ Тахилын онгон
 - Балбал
 - Хашлага чулуу



Хүннүгийн язгууртны булшны дэвсгэр зураг



- ♦ Тахилын сүмийн туурь
- ♦ Шивээ
- ♦ Овоо
- ♦ Бусад.

Дээрхи төрөл зүйлийн аль нэгэнд тохирохгүй бүх дурсгалыг оруулна.

Тахилын онгон

Манай улсын нутаг дэвсгэр дээр холбогдох цаг үеийн хувьд харилцан адилгүй үед бүтээгдсэн тахилын байгууламжууд элбэг тохиолддог. Тахил тайлгын байгууламж нь манай улсын хувьд хүрэл зэвсгийн үеэс



эхлэн бүтээгдсэн байдаг ба ихэвчлэн мал амьтны шатаасан болон шатаагаагүй яснууд, зарим төрлийн чулуун зэвсэг, хүрэл төмрөөр хийсэн эдлэл, сав суулган зүйлс гардаг байна. Тахилын байгууламж нь оршуулгын зан үйлийн нэг хэсэг болох боловч гадаад дотоод зохион байгуулалтаараа булш оршуулгаас ялгаатай байдаг. Гэхдээ үүнийг гаднаас нь хараад нарийн тогтоох боломжгүй бөгөөд археологийн малтлага судалгааны үр дүнгээр баталгаажуулдаг. Манай орны нутгаар тохиолддог тахил тайлгын байгууламжууд нь булш оршуулгын ойр хавьд уул толгодын энгэр ээвэр газар, ил харагдах тэгш дэвсэг, гол мөрний ай сав зэрэг газраар ганц нэгээрээ болон хоёр гурваараа зэрэгцсэн байдалтайгаар тохиолддог. Чулууг хэмжээний хувьд харилцан адилгүй дөрвөлжин, дугуй хэлбэрээр суулгаж үйлдсэн байдаг ба том жижиг чулуугаар голын талбайг дарсан байдаг. Тахил тайлгын байгууламжийн газрын ил мэдэгдэх хэсгийг харахад голоороо доош хонхойсон хэв шинж бараг ажиглагддаггүй бол булш оршуулгад ийм зүйл ихээр тохиолддог байна. Мөн манай улсын нутагт ихэвчлэн Түрэгийн жирийн иргэдэд холбогдуулан үздэг тахилын онгон хавтан чулууг газарт хайрцаглан



Түрэгийн тахилын онгон
(Түүх, соёлын., 2017)

суулгаж хийсэн дөрвөлжин хашлага, зарим үед дөрвөлжилсөн хашлга дунд хөшөө чулуу босгосон байх ба түүний өмнө (зүүн талд) хүн дүрст чулуун хөшөө, уг хөшөөний өмнөөс наран ургах зүгийг чиглүүлж цувруулан зоож тавьсан балбал хэмээх зэл чулуутай тохиолддог.

Харин угсаа сурвалжит язгууртны онгоныг үйлдэхдээ, өнгөлж засаад хээ угалз, амьтадын дүрс гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага босгож өмнө нь нэлээд бодитой уран хийштэй хүн чулуу тавьж олон тооны зэл чулуу цувуулсан байдаг.



Тахилын сүм

Түүхэн тодорхой цаг үед хүмүүс талийгаачийн хойт насанд зориулан тодорхой хугацааны давтамжтайгаар тахил тайлга хийх газар болгон барьж байгуулсан тахилын сүмүүд хамаарна. Манай улсын нутагт энэ төрлийн дурсгал төдийлөн олон биш боловч археологийн маллага судалгааны явцад тахилга хийхээр зориуд барьж байгуулсан тахилын сүмүүд илэрч мэдэгддэг. Эдгээр дурсгалууд нь хүний нүдэнд танигдахаар хадгалагдаж үлдээгүй, ихэвчлэн нуранги байдалтай байдаг нь таньж мэдэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг. Манай улсад төр улсаа тогтоон аж төрж байсан Түрэг үндэстнүүд нэр цуутай хүмүүсийнхээ хойт насанд зориулан тахилга үйлддэг тахилын сүмүүдийг барьж байгуулан үлдээсний хамгийн алдартай нь өнөөгийн Архангай аймгийн Хашаат сумын Хөшөө Цайдам дахь Билгэ хааны тахилын сүм болно. Тахилын сүмийн үлдэгдлээс тахилга үйлдэж байсан мал амьтны яс, гоёл чимэглэлийн эд зүйлс тэргүүтэн олдохоос гадна сүмийг барихад хэрэглэж байсан барилгын элдэв хэрэглэгдэхүүн олддог. Түрэгийн тахилын сүмүүдээс жишээ татан харахад энэ төрлийн дурсгал нь ганц дан тахилын сүм биш бүхэллэг цогцолбор дурсгал байдаг. Тахилын сүмийн гадуур шороо дагтаршуулан далан байгуулж түүнийхээ гадуур ус татах шуудуу ухаж гэрэлт хөшөө, хонины дүрс гарган урласан чулуун дурсгал, хүн хөшөө, балбал чулуу эс бүрдэх энэ төрлийн дурсгал нь ихэвчлэн Түрэгийн үед хамаардаг байна. Гэхдээ тахилын сүмийн үлдэгдлүүд нь Түрэгийн үед хамаарахаас гадна Хүннү, Кидан зэрэг эртний улсуудын үед холбогдох нь ч бий.

Шивээ

Манай улсын нутагт тэр дундаа говийн бүсэд өндөр уул, толгодын орой дээр чулуу, зарим тохиолдолд заг өрж үйлдсэн байгууламжууд цөөнгүй байдгыг шивээ хэмээн нэрэлдэг. Шивээн нь хэмжээний хувьд харилцан адилгүй байх бөгөөд алсын бараа харагдах байдлаар барж байгуулсан байдаг ба зарим тохиолдолд хоорондоо харагдахуйц хэмжээтэй зайд орших нь бий.

Овоо

Хүмүүсийн байгаль дэлхийгээ хамгаалах, газар орныхоо хилийн цэсийг тогтоох зэрэгтэй холбоотойгоор чулууг овоолон босгосон бүх төрлийн овоо хамаарна.

Манай улсын нутагт түүхийн олон үед бүтээгдсэн хэдэн зуун овоо бий. Овоо нь ихэвчлэн уул толгодын алсаас харагдах оройн хэсэг, булаг шандны эх орчмоор ганц нэгээрээ байдаг ажээ. Монголчуудын овоо босгох ёс тухайн газар нутгийнхаа уул, ус, ургамал амьтдаа хайрлан шүтэх, эрхэмлэн дээдлэх уламжлалтай



Овоо (Түүх, соёлын., 2017)

салшгүй холбоотой байдаг. Мөн бурхны шашны томоохон лам нарын хойд насанд буян үйлдэх сэтгэлээр шавь нар нь овоо босгох тохиолдол цөөнгүй байжээ. Нөгөөтэйгүүр газар нутгийнхаа хилийн цэсийг тогтоох зорилгоор уул толгодын дамнуулан овоо босгодог уламжлалтай байв. Энэ нь монголчууд Манж гүрний эрхшээлд орж газар нутгаа хэдэн хэсэг хуваалгасан тэр үеэс эхлэлтэй бөгөөд 1728 онд Орос-Манжийн хил тогтоосон гэрээ ёсоор өнөөгийн монгол хойд хил дагуу ийм овоо босгож байжээ. Овоо нь хэмжээний хувьд харилцан адилгүй агаад дунджаар 2-10 метрийн голч хэмжээтэй байдаг. Зарим тохиолдолд овоог нарийн шургааг модоор босгосон нь бий. Манай улсын зарим аймгийн нутгаар ойр хавь нь чөлөөтэй харагдах уулын өндөр орой дээр хавтгай чулууг өрж босгосон өндөр овоо цөөнгүй таардаг.

Барилга, архитектурын дурсгал

Барилга, архитектурын дурсгалд түүхэн тодорхой цаг үед хүмүүс урт хугацаагаар суурьшин барьж байгуулсан эртний хот, хэрэм (суваг, шуудуу)-ийн үлдэгдэл болон барилга байшин, суварга, сүм хийдийн туурь, архитектурын дурсгал (сүм хийд, уран барилга,



түүхийн дурсгалт байшин, баримал, хөшөө, сүрлэг чимэглэлийн дүрслэл г.м) зэрэг хамаарна.

Суурьшлын үл мөр бүхий газар

Эртний хот

- ♦ Хүннү
- ♦ Түрэг
- ♦ Уйгур
- ♦ Кидан
- ♦ Монгол
- ♦ Манж
- ♦ Тодорхойгүй.



Уламжлалт барилга, архитектурын дурсгал (Д.Майдар...,1972)

Дээрх төрөл зүйлийн аль нэгэнд тохирохгүй бүх дурсгалын оруулна.

Манай орны нутагт оршин аж төрж байсан эртний нүүдэлчин ард түмнүүд тодорхой цаг хугацаанд нэг газарт төвлөрөн суухдаа хот хэрэм байгуулан сууж байсан нь хөдөө орон нутгаар дайралдах хэмжээний хувьд харилцан адилгүй олон тооны эртний хотын үлдэгдлүүд гэрчилнэ. Эдгээр хот суурины үлдэгдлийн хамгийн эртнийх нь Хүннүгийн үед хамаардаг байна. Үүнээс хойш Түрэг, Уйгур, Кидан, Монгол, Манжийн үед холбогдох хот суурины үлдэгдэлүүд олддог. Эртний хот хэрмийн үлдэгдлүүд нь хамрах газар нутгийн хувьд харилцан адилгүй байх бөгөөд нэг хоёр зуун метрээс хэдэн зуун метр байх нь олонтаа тохиолддог. Багахан хэмжээтэй хот хэрмийн үлдэгдэл нь ихэвчлэн эртний шинжтэй байдаг ба өндөр хэрэмтэй, эзлэх талбайн хувьд том хот нь харьцангуй хожуу үед холбогддог байна.

Эртний хот хэрмийн үлдэгдлүүд нь тодорхой цаг үед байгуулагдаад дайн байлдааны улмаас сүйтгэгдэх устаж үгүй болох явдал цөөнгүй байсан ба түүнийг нь хожуу үед сэргээн засварлаж дахин ашиглаж байсан ул мөр манай орны нутгаас олдсон байна.



Эртний хотын туурь (Түүх, соёлын., 2017)



Эртний хот суурины үлдэгдлүүдийн зарим нь газрын хөрсөн дээр анх барьсан байдлаа бага зэрэг алдсан ч бараг бүтнээрээ хадгалагдан үлдсэн байдаг бол зарим нь дөрвөлжин хүрээлсэн багахан дов төдийгөөр үлдсэн байдаг. Төв Азийн нүүдэлчид хот байгуулахдаа юун түрүүнд хэрэм барьж хэрмийнхээ гадуур ус татах суваг шуудуу ухдаг байжээ. Хэрмийнхээ дотор гудамж байшин барилга барьдаг байв. Энэ зохион байгуулалт нь манай орны нутагт эртний хот хэрмийн ерөнхий дүр зураг юм. Эдгээр эртний хот хэрмийн үлдэгдлийг малтан шинжихэд барилгын тоосго, дээврийн нөмрөг, тосгуур, нүүр, ваарны үлдэгдлүүд, барилгын гоёл чимэглэлийн материалууд зэрэг олон тооны барилгын хэрэглэгдэхүүн, элдэв төрлийн ваар сав суулга, хазаарын амгай, дөрөө, тэрэгний төмөр цөн, зоос, нумын наалт, сүмны зэв, жадны гилбэр зэрэг эд зүйлс олддог байна.

Хэрмэн зам

Манай орны зарим нутгуудад олон км үргэлжилсэн нутгийн ардын дунд домог, түүх бүхий “Хэрмэн зам”, “Илжгэн чихт хааны зам”, “Гүнжийн зам” зэргээр нэрлэгддэг чулуу, шороогоор байгуулсан эртний байгууламж тохиолддог.

Шуудуу

Манай улсын зарим нутагт эрт үед цэрэг дайн, газар тариалан зэрэг янз бүрийн зориулалтаар газар ухаж, түүнээс гарсан шороог хажуугаар нь овоолсон бололтой хэдэн арван км үргэлжлэх байгууламж тохиолддог. Нутгийн хүмүүс үүнийг шуудуу хэмээн нэрдэг.

Сүм хийдийн туурь

Суврага

Түүхэн тодорхой цаг үед шашны хурал номын үйл ажиллагаа явуулж байсан болон мөргөл, хүндэтгэлийн үүргийг гүйцэтгэж байгаад хожим нь эвдэрч сүйдсэн, эргэж сэргээн засварлагдсан томоохон суварга, сүм хийд, түүний туурь үлдэгдлүүд хамаарна.

Сүм хийд, суварга нь монголчуудын сүсэг бишрэлийн илэрхийллийн томоохон жишээ болохынхоо хувьд оюуны болон эдийн соёлын үнэт дурсгал болдог. Манай улсад бурханы шашин дэлгэрсэн үеэс хойш хөдөө орон нутагт олон тооны сүм хийд барьж байгуулан хурал номын үйл ажиллагаа явуулж байсан ба сүм хийдийг даган хүмүүсийн төвлөрөл бий болж байв. Манай орны нутагт 1930-аад оны сүүлийн их хэлмэгдүүлэлтээс өмнө 1000 гаруй сүм хийд хурал номын үйл ажиллагаа явуулж байсан гэсэн албан бус тоо баримт байдаг.

Гэвч эдгээр сүм хийд томоохон суваргыг 1937-1940-аад оны хооронд зориудаар эвдэн сүйтгэж үгүй хийсэн бөгөөд цөөхөн хэдэн тооны сүм хийдийг зориулалт нь өөрчлөн ашиглахаар авч үлдсэн байдаг. Манай орны нутагт байгаа сүм хийд, суваргын үлдэгдэл нь дан ганц бурхны шашны дэлгэрсэн үеэс хойш байдаггүй бөгөөд эртний Киданчууд болон дундад эртний монголчууд ийм төрлийн дурсгал барьж байгуулж байсныг олон жишээнээс харж болно.




Хийдийн туурь (Түүх, соёлын., 2017)



Тухайлбал: Их Монгол Улсын нийслэл Хархорум хотын үлдэгдлээс томоохон сүмийн туурь олдсон, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг дахь «Барс хот” хэмээгдэх Киданы хотын үлдэгдэл дэх 5 давхар суварга гэх мэтийн дурсгалаас харж болно. Хөдөө орон нутагт байгаа сүм хийд, суваргын үлдэгдлүүдээс элдвийн барилгын шавар болон модон материалууд, шавар бурхадын үлдэгдлүүд, ахуйн хэрэглээний сав суулга зэрэг зүйлс олдог байна. Мөн ийм дурсгалт газруудад аж төрөх хүмүүс тухайн дурсгалтай холбоотой маш олон тооны хууч яриа, домог ярилцдаг.

Түүхэн дурсгалт байшин

Түүхэн тодорхой цаг үед баригдаж хот байгуулалт, уран барилгын түүхийн аль нэг хэсгийг төлөөлж чадах болон түүхэн үйл хэргийн бодит дурсгал болж үлдсэн, нэрт хүмүүсийн ажиллаж амьдарч байсан бүх төрлийн барилга байшин, орон сууцны барилга хамаарна. Өнөөдөр дэлхий нийтэд барилга байшингийн түүхэн тодорхой үнэ цэнийг харгалзан үзэхээс гадна ерөнхийдөө 100 гаруй жилийн настай барилга байшинг түүх, соёлын дурсгалд хамааруулан хадгалж хамгаалдаг. Манай улсад уран барилгын дурсгал бусад суурин иргэншилт улс түмнүүдийг бодвол харьцангуй цөөхөн боловч



Дурсгалт барилга (Улаанбаатар хотын музейн барилга., 1989)

XX зууны эхэн үеийн түүхэнд холбогдол бүхий, байшин барилга өнөөгийн Улаанбаатар, Сэлэнгэ, Улиастай, Ховд зэрэг хотуудад цөөнгүй үлдэн өнөөг хүрчээ. Эдгээр дурсгалыг модоор бүтээгдэж шавраар өнгөлсөн байдаг тул цаг хугацааны эрхээр эвдэрч муудах нь их. Манай улсын нутагт байгаа түүхэн үйл хэрэг, нэрт хүмүүсийн амьдралтай холбоотой барилга байшингууд нь тухайн цаг үеийнхээ барилгын нийтлэг хэв шинжийг илэрхийлэхээс гадна гадаад улс орны барилга байшингийн загварын нөлөөг ихээхэн тусгасан байдаг.

Агуй, оромж, түр сууц

Бусад.

Дээрх төрөл зүйлийн аль нэгэнд тохирохгүй бүх дурсгалыг оруулна.


Палеонтологийн олдворт газар

Палеонтологийн олдворт газрыг түүхэн хөгжлийн он дарааллаар, хронометрийн аргаар эртний үеэс хожуу үе рүү шатлан ангилж судалдаг. Хроностратиграф (аливаа хурдас чулуулгийг нас, тэдгээрийн цаг хугацааны харьцааг судалдаг стратиграфийн салбар) -ийн аргаар геологийн цаг хугацааг Эон, Эрин, Галав, Галчин, Зуун, Хрон гэсэн нэгжүүдэд хувааж олдворт газруудыг энэхүү аргаар системчлэн ангилдаг байна.

- ♦ Кембрийн өмнөх цаг үе буюу архей протерозойн эриний олдворт газрууд
 - Стратиграфийн тулгуур зүсэлт газрууд
 - Урьд кембрийн амьтны олдворт газрууд Тайлбар: Кембрийн өмнөх цаг үеийн судалгаа буюу бактерийн палеонтологийн судалгаатай холбоотой олдворт газрууд (2500-540 сая жилийн өмнөх)
- ♦ Палеозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд
 - Далай тэнгисийн амьтны олдворт газрууд, тулгуур зүсэлтүүд



Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бүгийн цавын палеонтологийн олдворт газарт орших үлэг гүрвэлийн мөр



Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хонгилын палеонтологийн олдворт газар

- Мөр хөлтөн
- Далайн шүр Тайлбар: Палеозойн эриний амьтан ургамлын судалгаа буюу эртний далай сав газрын амьтан ургамлын судалгааны олдворт газрууд юм (540-250 сая жилийн өмнөх)
- ♦ Мезозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд
 - Нуур усны амьтан ургамлын олдворт газрууд, тулгуур зүсэлтүүд
 - Ургамлын дардас
 - Чулуужсан мод
 - Эртний загас
 - Дун хясаа
 - Эх газрын амьтан ургамлын олдворт газрууд, тулгуур зүсэлтүүд
 - Үлэг гүрвэл
 - Үлэг гүрвэлийн өндөг Тайлбар: Мезозойн эриний амьтан ургамлын судалгаа буюу эртний эх газрын ноёлогч бүлгүүдийн гол цөм олдож судлагдаж байгаа олдворт газрууд /250-65 сая жилийн өмнөх/
- ♦ Кайнозойн эриний амьтан ургамлын олдворт газрууд, тулгуур зүсэлтүүд
 - Эртний хөхтөн амьтдын олдворт газрууд
 - Хөхтөн Тайлбар: Кайнозойн эриний амьтан ургамлын судалгаа буюу эртний хөхтөн амьтад /сүүн тэжээлтэн/-ын олдворт газрууд /65-1,8 сая жилийн өмнөх/



II.2. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН БАЙРШИЛ ТОГТООХ

Дэлхийн эргэлтийг даган тогтмол байдлаар хамт эргэлдэх тойрог замд оруулсан хиймэл дагуулаас мэдээлэл авч дэлхийн гадарга дээр байрлал тодорхойлох арга Global Position System (GPS) гэдэг. Энэ технологийг ашиглан бүтээсэн юмсын байршил тогтоох багажийг GPS хэмээн товчлон нэрэлдэг.

GPS-ийн бүрдэл


GPS-ийн систем гурван хэсгээс тогтоно.

- ♦ Сансрын хэсэг
- ♦ Удирдлагын хэсэг
- ♦ Хэрэглэгчийн хэсэг

Сансрын хэсэг. GPS системийн сансрын хэсэг нь хиймэл дагуулаас тогтох ба дэлхийн тойрог замыг 12 цагт тойрдог. Эдгээр хиймэл дагуулууд нь сансраас радио долгионуудыг илгээдэг.

Удирдлагын хэсэг. Хяналтын хэсэг нь дэлхийн эргэн тойронд суурилагдсан тохируулгын станцуудаас тогтоодог. Хяналтын станц нь хиймэл дагуулыг мөрдөх бөгөөд мэдээллийг дараа нь төв станц уруу дамжуулдаг.

Хэрэглэгчийн хэсэг. GPS системийн хэрэглэгчийн хэсэг нь GPS системийн хүлээн авагч ба хэрэглэгчүүдээс бүрдэнэ. GPS системийг навигаци, байршил тогтоох, бусад судалгаа шинжилгээ хийхэд ашигладаг. X, Y, Z гурван хэмжигдэхүүнд байрлал тогтоох системийг анхны хувилбар нь GPS юм.



GPS-ийн хүлээн авагчийн төрөл

Байршил тогтоогчийн нарийвчлал, төрлөөр нь ерөнхий 3 ангилав.


- ♦ **Автомат навигациар байрлал тогтоох** - GPS хүлээн авагчийг электроник зарж борлуулдаг олон дэлгүүрт зардаг бөгөөд



гар утас, ухаалаг гар утас, PDA, onboder гэх мэт суулгагдсан байдаг. Хэрэглэгчдэд янз бүрийн төхөөрөмж, программ хангамжийн бүтээгдэхүүнийг санал болгодог бөгөөд энэ нь тэдний байршлыг газрын зураг дээр харах боломжийг олгодог; замын тэмдэг, зөвшөөрөгдсөн

эргэлт, бүр түгжрэл зэргийг харгалзан маршрут тавих боломжтой, Энэ нь ганц Gps-ийн (гар gps) хүлээн аварч тогтоох бөгөөд байрлалыг иргэний хэрэгцээнд зориулж 100м дотор тодорхойлох, 2-5м нарийвчлалтай байдаг. Явган аялал, ахуйн зориулалт, судалгаа шинжилгээ гэх мэт.

- ♦ **Дифференциалаар засварлагдсан байрлал тодорхойлох** - DGPS 0.5-5м дотор нарийвчлалтайгаар байрлал тодорхойлох чадвартай DGPS-н төрлүүд ордог бөгөөд далайн эрэг орчмын хөдөлгөөнт объектуудыг хянах, төрөл бүрийн GIS -ын мэдээлэл цуглуулах зэрэгт ашигладаг.



- ♦ **Фазын зөрүүгээр байрлал тодорхойлох** - Зураглалын түвшин өндөр нарийвчлалтай 0.5-5мм хүртэл нарийвчлалтай байрлал тогтоодог. Энэ хэмжилтээр олон төрлийн геодезийн зураглалын ажлууд, боловсруулах, хяналт зэрэгт ашигладаг.



Нэг мм-ээс см нарийвчлалтай хэмжилт хийдэг байршил тогтоох багаж, ихэвчлэн геодези, хэмжилт зурагзүй зураглал хийхэд ашигладаг.

Нийтлэг алдааны эх үүсвэр

- ♦ Агаар мандлаас шалтгаалах
 - долгионууд нь агаар мандал дундуур аялахдаа хоцордог
- ♦ Үзэгдэх орчин хязгаарлагдах
 - битүү ой шугуй
 - байшин барилга

GPS-үүдээс Автомат навигациар байрлал тогтоох судалгаа шинжилгээнд хэрэглэх Garmin Etrex төрлийн гар GPS-ийг илүү дэлгэрэнгүй задалж тайлбарлав.


Garmin eTrex Series төрлийн Gps-тэй танилцах



- 1). Power, Light  - Асаах, унтраах, Дэлгэцийн гэрэл тохируулга үйлдэл хийнэ. 2). Буцах товч - Орсон функцээс гаргах. 3). Цэс товч - Дар цэсний сонголтууд. 4). Торуулах товч - Суурь өгөгдөл буюу масштабын дагуу томруулж жижгэрүүлэх. 5). Гүйлгэх Click-stick OK товч хулганы үүрэг гүйцэтгэх дээш доош баруун зүүн түүш гүйлгэх зөвшөөрөх товчууур.
- 6). USB оролт - USB кабелиар мэдээлэл дамжуулах. 7). Тэжээлийн хэсэг - Тэжээл тагыг онгойлгох буюу баттерай зайн оролт

Garmin eTrex Series Gps

Gps-ийг ■ Асаах (Power) 3 секунд дарж асаа, төхөөрөмж гүйцэт астал 10 секунд хүлээ, Цэс (Menu) дарж үндсэн цэс (Main menu)-рүү орж, хиймэл дагуул (Satellite) сонгож хиймэл дагуулын мэдээлэл гүйцэт ортол хүлээх.



Хиймэл дагуулын мэдээлэл

Хиймэл дагуулын хуудсан байршлын мэдээлэл х, у координат, алдаа ± 24 fit, хиймэл дагуулын тоо, сигнал байна.

1. Цэг тэмдэглэж хадгалах - Marking and Saving Waypoints

Байршлын хадгалж цэг тэмдэглэхдээ зөөгч товчийг (Click-Stick хулганы үүрэг гүйцэтгэдэг товч) дарж орж хадгалж болно. Аль эсвэл Үндсэн цэс (Main menu) рүү орж цэг тэмдэглэх (mark waypoint) руу ор, эхний мөр цэгийн дугаар нэр, тэмдэгт, хоёр дахь мөрөнд **Note** буюу тэмдэглэл тодорхойлолт бичиж болно, **Location** буюу одоо байршил харагдана done дар.

The screenshot shows the waypoint details screen with the following information:

- Waypoint ID:** 001
- Note:** (Empty field)
- Location:** N 37°12.598', W 080°23.309'
- Elevation:** 2102'
- Buttons:** Map, Done


Цэг тэмдэглэх



Waypoint-тод автоматаар дугаарлагдаж явдаг. Текстээр мөн нэр өгч хадгалж болно.


2. Цэг олох навигаци - *Finding (navigating to) a Waypoint*

Gps нь өмнө тодорхойлсон, хадгалсан цэг рүү очих навигаци хийж чиглүүлэх цэс юм. Үндсэн цэс (**Main menu**) Хаашаа (**Where to ?**) дарж ор, цэгүүд (**waypoints**) рүү орж очих цэгээ сонгоод (**Go to** хийх) дар.



3. Цэг засварлах, оруулах *Waypoint edit*

Энд тэмдэглэх цэгүүдийн байршлыг гараас бичиж оруулж хадгалах, тэмдэгт өгөж ялгах, тэмдэглэл бичих, олох, хадгалсан цэг рүү **go to** хийнэ. **Location** гэсэн мөр лүү дарж ороод координатаа гараас бичиж оруулж хадгална. Газарзүй координат, **Lat/Long** тэгш өнцгийн **UTM** зэрэг координатын мэдээллийг гараар gps хүлээн авагчид оруулна.



Click-stick товч ашиглан **Mark waypoint page** рүү дарж ор. **Click-stick** ашиглан mark point-ийн **Location** хэсэг рүү дарж ор. Энэ хэсэгт шинэ координат а оруулна. Энд дэлгэц дээр гарсан тоонуудыг ашиглан **Click-stick** товч ашиглаж дээш доош баруун зүүн тийш гүйлгэн тодотгосон хэсгүүдэд тоонуудаа оруулан **Done** дарж хадгална.

Хадгалсан координатаа **where to ?** цэсийн waypoint орж чиглүүлэх буюу **navigate** хийнэ.





4. Байрлалын формат, Нэгж - Position format and Units

Байрлалын формат нь улс оны тусгагд зориулсан газрын зургийн датум, градус минут секунд, градус минут, desmal dergees буюу аравтын градус, UTM-ийн сонголт байдаг. **Click-stick** товчоор **Main menu** руу орж **Setup** цэсийг сонгож ороод **Position format** хуудсыг сонгож орно. "hddd°mm.mmm'", UTM гэх мэт.

Нэгж units зай талбайн хэмжээн утга (nm, kt, m) өндрийн утга (ft,m), гүний утга (m, ft гэх мэт) байдаг.


Click-stick товчоор **Main menu** руу орж **Setup** цэсийг сонгож ороод **Units** хуудсыг сонгож орно.





5. Газрын зураг - Map

Газрын зураг буюу **Map** хэсэг нь Gps-ийн эх дэлгэцээр гарах ба таны байршил тэмдэглэгээ, хурд (km, m), зай (m), зүг чигийн тэмдэг (N), масштаб, координат (Lat/Long), Газрын зургийн суурь буюу **basemap** (osm, dem) байдаг. **Click-stick** товчоо ашиглан **Main menu** руу орж Map хуудас руу ор.



Зураг

Гар GPS-ний функц тохиргооны тайлбар

	Map Газрын ерөнхий байршил замнал харагдана.
	Trip computer Хугацаа хэмжигч Хурд, явсан цаг, дундаж хурд тэмдэглэнэ.
	Mark waypoint Цэг тэмдэглэх координат гараас шивж оруулах, цэгийн нэр өгөх тэмдэглэгээ бичиж хадгална. Хадгалсан цэг рүү очих буюу Mark waypoint go to хийх.
	Compass Луужин зүг чиг, хурд, очих цэгийн зайг харуулна.

Setup доторх үндсэн тохиргоонууд	
	Setup Тохируулах Систем, дэлгэц, дуу, газрын зураг, track буюу явалтын мөр, дахин эхлүүлэх тохиргоо, нэгжийн тохиргоо, байршлын формат, луужингийн тохиргоо гэх мэт үндсэн тохиргоо байна. Нийтлэг гол хэрэглэх тохиргоог оруулья
	Units Хэмжих нэгж 2 цэгийн хоорондох зайн хэмжээн нэгж, хурдны нэгж, Өндрийн угтын нэгж Температурын нэгж гэх мэт
	Tracks Мөрдлөгийн тохиргоо Track-ийн тэмдэглэлийг асааж унтраах, Автоматаар архивлах, шугамын өнгө өөрчлөх гэх мэт
	System GPS-ийн тохиргоо Gps-Glonass ийн сонголт, Хэлний сонголт, Тэжээлийн сонголт буюу ашиглаж байгаа зайн төрлөө сонгож болно.
	Position Format Байрлалын формат Байрлалын формат: Тогтоосон байршлыг төрөл бүрийн (Энд тухайн улс оны тусгагд зориулсан нэгжүүд байдаг) уггаар харуулж хөрвүүлдэг. Бид ихэвчлэн градус минут секунд, градус минут, desmal dergees буюу аравтын градус, Тэгш өнцгийн буюу метрийн нэгжээр хэрэглэдэг.
	Газрын зургийн датум Энд газрын зургийн солбишлын системийг тохируулж сонгож өгдөг. Зарим улс орнууд өөрийн газар нутагт тохирсон солбишлын системийг ашигладаг ба нийтлэг хэрэглэгддэг датум нь WGS-84 юм. Манай улсын WGS84 UTM тусгагыг ашигладаг датумын WGS84 өөс өөрчлөөд байх шаардлага байхгүй. Ямарваа нэг алдаа гарч датум солигдоход байршил тогтоож буй координат буруу болдог.
	Map Газрын зураг Оршин байгаа байрлалын чиглэлийн зүг чигийн тохиргоо, Track буюу мөрдөлт, Автомат горим гэсэн сонголтууд байна. Мөн газрын зургийн ахисан түвшний бичвэр текстийн өөрчлөлтүүд, Газрын зургийн суурь өгөгдлүүд ӨТЗ, Автозамын тэмдэглэл OSM, гэх мэт
	Газрын зургийн сферойд бидний хэрэглэж буй төхөөрөмжийн үндсэн солбишлын систем WGS84 юм.



Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байршил тогтоон, GPS ашиглаж, хэмжилт хийхдээ тухайн дурсгалаас хамаарч хажуу булан болон гол хэсэгт нь байршил тогтооно.

1. Ихээхэн хэмжээний хиргисүүр булш оршуулга төрөл зүйл нэг бол төв хэсэгт нь хэмжилтийг авна.
2. Цогцолбор дурсгал, олон төрөл зүйлтэй бол төрөл ерөнхийд нь нэг хэмжилт авсны дараа дурсгал тус бүрийн байршлын тогтоох, нийт дурсгалын хамрах хүрээг тогтоож полигон байдлаар гурваас дээш цэг авбал зохино.
3. Цөөн тооны ганц нэг дурсгал бол хажууд тулгаж GPS-ийн төхөөрөмжийн сүлжээ унахгүй хэсэгт очиж байршлыг тогтооно.

II.3. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ГЭРЭЛ ЗУРАГ АВАХ

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалтын нэгэн чухал арга хэрэгсэл бол гэрэл зураг юм. Баримтжуулалтын гэрэл зураг авах ажил нь бэлтгэл ажлаас эхэлнэ. Бэлтгэл ажил гэдэгт техникийн бүрэн бүтэн байдлыг хангахаас гадна ажлын зорилго болон үр дүнгээ сайтар бодож төлөвлөх зэрэг ч орно. Энэ хэсэгт ТСҮХД-ыг гэрэл зургаар баримтжуулахад тавигдах ерөнхий шаардлага ба практик зөвлөмжүүдийг жишээ гэрэл зургийн хамт хүргэх болно.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрэл зургаар баримтжуулах нь

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал (Шаашид ТСҮХД гэнэ)-ыг баримтжуулах зорилгоор авсан гэрэл зургаас дурсгалын хүрээлэн байгаа орчин, үндсэн төрх байдал, овор хэмжээ, хадгалалт хамгаалалтын байдал болон эвдрэл гэмтэл зэрэг хэд хэдэн үндсэн мэдээллийг авах боломжтой. Түүнчлэн ТСҮХД-ын гэрэл зургийг судалгаа шинжилгээ, сурталчилгаа зэрэг олон хэлбэрээр ашигладгийг бодолцон олон талт зураг авахыг хичээх нь зүйтэй. Зарим тохиолдолд дурсгалын зургийг хөндлөн ба босоо зохиомжоор аль алинаар нь авах нь хожим хэвлэлийн дизайнд аль тохиромжтойг нь сонгон хэрэглэхэд тустай. Ихэнх ТСҮХД нь байгаль дээр ил задгай орших бөгөөд хэмжээ, хэлбэрийн хувьд харилцан адилгүй байдаг. Тиймээс тухайн дурсгалын төрөл зүйлийн 18 онцлогт тохируулан гэрэл зургаар баримтжуулах шаардлага үүсдэг. Үүнд: Хадны зураг, бичээс (хадны сийлмэл болон зосон зураг, бичгийн дурсгалууд г.м.), Булш оршуулга (булш, хиргисүүр), Хэрэм, шуудуу, хийдийн туурь, Хөшөө дурсгал (Буган чулуу, хүн чулуу, гэрэлт хөшөө), Дурсгалт газар (чулуун зэвсгийн дурсгалт газар, үйлдвэрлэлийн ул мөр бүхий газар, палентологийн олдворт газар), Барилга архитектурын (түүхэн барилга, сүм хийд) дурсгал зэргээр ангилан тус бүрийн онцлогт



тохирсон гэрэл зураг авахыг эрмэлзэх нь зүйтэй. ТСҮХД-ыг гэрэл зургаар баримтжуулахдаа баримтлах үндсэн хэд хэдэн зарчмууд байдаг. Үүнд,

Дурсгалын ойр орчинд нь байх онцлог зүйлсийг оруулан авах

Дурсгалыг ойр орчинд нь байгаа байгалийн онцгой содон тогтоц болон хүний барьж байгуулсан барилга байшинтай хамаатуулан авснаар тухайн дурсгалын байршлыг тодотгож өгөх давуу талтай. Мэдээлэл нь хуучирсан, газар орны нэр нь өөрчлөгдсөн тохиолдолд гэрэл зургийн арын хэсэгт орсон онцлог зүйлсийг баримжаалан дурсгалын байршлыг тогтоож болдог.



Гэрэл ойлгогч ашиглан нарны эсрэг зүгээс зураг авсан байдал

Нарны эсрэг зүгээс зураг авсан байдал

Дурсгалыг ерөнхий болон хэсэгчлэн авах

Дурсгалт газрыг гэрэл зургаар баримтжуулахдаа урдаас нь эхлэн нар зөв тойруулан тал бүрээс нь ерөнхий авах бөгөөд аппаратын дэлгэцэнд тухайн дурсгалт газрыг багтах харьцааг зөв хуваарилж, аль болохоор дэлгэцийг дүүргэж харагдах өнцгөө зөв сонгоно. Мөн дурсгалт газрын онцлогийг харуулсан гэрэл зургийг хэсэгчлэн авах шаардлагатай. Ингэж авснаар гэрэл зургаас дурсгалт газрын болон дурсгалын талаар бүрэн мэдээлэл авах боломж бүрдэх юм. Тухайлбал, Хадны зургийн дурсгалт газарт онцлог дүрслэлүүдийг, булш оршуулгын байгууламжуудаас хамгийн том болон хамгийн жижиг хэмжээтэйг, мөн өвөрмөц зохион байгуулалттайг нь тусгайлан авбал зохино. Түүнчлэн хэрэм, шуудуу, хийдийн тууриас харьцангуй

бүтэн, зохион байгуулалтыг харуулж чадах хэсгүүд болон үлдэж хоцорсон олдвор, эд өлгийг, хөшөө дурсгалын чухал дүрслэлтэй (буган хөшөөний дөрвөн тал, дээд хэсэг болон бүс, хүн чулуун хөшөөний малгай, нүүр, дээлийн энгэр, бүс, гарын байрлал, гутал, гэрэлт хөшөөний бичээстэй хэсгүүд г.м), Барилга архитектурын дурсгалаас хаалга, үүд, цонх, хээ угалз зэргийг тусгайлан авах шаардлагатай.



Хүн чулуун хөшөөний онцлог хэсгүүдийг хэсэгчлэн авсан байдал

Зориулалтын шугам тавьж авах.

Дурсгалын овор хэмжээг харуулах үүднээс дэргэд нь хэмжээ хувиар бүхий шугам тавьж авбал зохино. Мөн зарим чулуун дурсгалын хувьд чулууны төрөл, өнгийг нарийн тодорхойлохын тулд тусгай зориулалтын өнгөний хуваарьтай карт тавьж зураг авдаг. Тухайлбал, хадны зургийн онцлог дүрслэлтэй хэсгийг тусгайлан авахдаа тухайн дүрслэлийн доор 10-20 см хэмжээтэй шугамыг хөндлөн, булш оршуулгын дурсгалын дэргэд зориулалтын шугам,





Зориулалтын хэмжээсийг тэгш хэмд байрлуулан авсан байдал



хэрэм, шуудуу, хийдийн туурийн барилгын үлдэгдлийн дэргэд 1-1.5 хэмжээтэй зориулалтын шугамыг эгц босоогоор нь байрлуулах, хөшөө дурсгалын гэрэл зургийг түүний хэмжээнээс хамаарч 0.2-1 метр хэмжээтэй зориулалтын шугамыг босоо байдлаар байрлуулж авах нь зүйтэй.

Дурсгалын төв цэгийг олж, тэгш хэмээс авах.

Баримтжуулалт хийхдээ дурсгалыг үнэн зөв хэмжээтэй харуулахын тулд дүрсний хэт гажуудал үүсэхээс зайлсхийх хэрэгтэй. Ингэхийн тулд дурсгалын төв цэгийг олж аппаратаа тэгш хэмээр байрлуулж авна. Энэ нь дурсгалын хэлбэр дүрс, овор хэмжээг үнэн зөв харуулахаас гадна хожим гэрэл зургаас гар зураг болгон буулгахад тустай юм. ЗУРАГ



Дурсгалын төв цэгийг олж аппаратаа зөв байрлуулахыг харуулсан гар зураг

3.1.5. Дурсгалын нэр, байршил, он сар, өдрийг тэмдэглэсэн самбарыг дэргэд нь байрлуулж авах.

Хээрийн бүртгэлийн үеэр тусгай самбар дээр дурсгалын товч мэдээллийг тэмдэглэсэн самбарыг дурсгалын дэргэд байрлуулан гэрэл зураг авах явдал бий. Ингэж самбар дээр тэмдэглэл хийж гэрэл зураг авах нь адил төрлийн олон дурсгал дунд төөрч будилахаас




Дурсгалын нэр, байршил, он сар өдөр зэргийг тэмдэглэсэн байдал

сэргийлэнэ. Баримтжуулж буй дурсгалын дэргэд байрлуулсан самбарыг аппаратын дуранд 90 градус өнцгөөр харагдаж байхаар тохируулах ба тухайн газар орны засаг захиргааны нэр, дурсгалын нэр, огноог багтаасан багавтар хэмжээтэй самбар байвал тохиромжтой юм. Мөн бусад нэмэлт мэдээллийг самбарт багтаан бичиж болно.

3.1.6. Гэрэл ойлгогч зэрэг гэрэлтүүлгийн нэмэлт хэрэгслийг үр дүнтэй ашиглах

Хүн чулуу болон буган чулуун хөшөөн дээрх дүрслэлийг илүү тодорхой харуулахын тулд гэрэл ойлгогч нэмэлтээр ашиглах нь ихээхэн үр дүнтэй байдаг.



II.4. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ДУРСГАЛЫН ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ МАЯГТЫН БӨГЛӨХ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Тус маягт нь “Ерөнхий мэдээлэл” “Гэмтлийн мэдээлэл” гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. “Ерөнхий мэдээлэл” хэсэгт бүртгэлийн дугаар, дурсгалт газар байрлах засаг захиргааны нэгж, газар зүйн байршлын солбицол, тухайн дурсгалт газрыг бүрдүүлж байгаа дурсгалууд, хамгаалалтын зэрэглэл, дурсгалт газрын товч тодорхойлолт зэрэг дурсгалт газрын мэдээлэл болон гэрээт харуул, хашаа хайс, хаяг тайлбар, кадастрын хэмжилт бүртгэл зэрэг дурсгалт газрын бүртгэл, хадгалалт хамгаалалтын агуулга бүхий 16 асуулга багтсан.

“Гэмтлийн мэдээлэл” хэсэгт дурсгалыг төрөл зүйлээр нь Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн үл мөр бүхий дурсгалт газар, Хадны зураг, тамга, тэмдэг, бичгийн дурсгал, Хөшөө дурсгал (Буган чулуу, хүн чулуу, гэрэлт хөшөө), Булш оршуулга, тахил тайлгын дурсгал, Барилга, архитектурын дурсгал, Палеонтологийн олдворт газар хэмээн 6 ангилав.

Тухайн 6 төрлийн маягтаас аль тохирохыг сонгож, сонгосон маягтад байгаа дурсгалын дэд төрлүүдийг тэмдэглэн дурсгалын гэмтлийн мэдээллийн хувь хэмжээг сонгож, товч бичнэ. Гэмтлийн мэдээлэлд тухайн дурсгалын төрөлд хамгийн сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг сонгож оруулсан бөгөөд эдгээрээс өөр хүчин зүйл байгаа тохиолдолд гэмтлийн мэдээлэл хэсэгт товч бичнэ. Эдгээр гэмтлийн мэдээллийг хэмжихийн тулд: “Гэмтэлгүй”, “10% хүртэлх гэмтэлтэй”, “10-50% хүртэл”, “50% дээш” гэсэн 4 шатлал бүхий үзүүлэлтээс сонгоно.

Энэхүү маягтыг бөглөхдөө 2015 оны Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын тайлан, RICH 3.0 програм хангамж, археологи, палеонтологийн эрдэм шинжилгээний судалгааны тайлан, баяжилтын мэдээлэл болон орон нутгийн иргэдийн мэдээлэл зэрэг боломжит бүх эх сурвалжаас авч болох бөгөөд мэдээлэл авсан эх сурвалжийг тэмдэглэнэ.

НЭГ. Үндсэн мэдээллийн тайлбар (дэс дарааллаар)

1. **Дурсгалт газрын бүртгэлийн дугаар:** Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 2015 оны А/108 дугаар тушаалаар Улс орон даяар зохион байгуулагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллогын хүрээнд өгсөн бүртгэлийн дугаарыг бичнэ.
2. **Аймаг, нийслэл:** Тухайн дурсгалын оршин буй аймаг, нийслэлийн засаг захиргааны нэгжийн албан ёсны нэрийг тодорхой, үнэн зөв бичнэ.
3. **Сум, дүүрэг:** Тухайн дурсгалын оршин буй сум, дүүргийн засаг захиргааны нэгжийн албан ёсны нэрийг тодорхой, үнэн зөв бичнэ.
4. **Нэр:** Монгол Улсын ЗГ-ын 2020 оны 13-р тогтоол, 2021 оны 179-р тогтоол, БСШУС-ын Сайдын 2020 оны А/161 дугаар тушаалаар тус тус батлагдсан Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын албан ёсны нэрийг тодорхой, үнэн зөв бичнэ.
5. **Дурсгалт газрын солбицол:** WGS 84 солбицол уртраг (N), өргөрөг (E)-ийн хэм (°), минут ('), секунд (")-ын утгаар солбицлыг тухайн дурсгалын төв цэгт байршлыг тодорхойлж, далайн түвшинээс дээш (ΔТД) өндрийн утгийг тэмдэглэж бичнэ.
6. **Бүрдэл:** Тухайн дурсгалт газарт оршин байгаа Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн үл мөр, Хадны зураг, тамга, тэмдэг, бичиг, Хөшөө дурсгал, Булш оршуулга, тахил тайлга, Барилга архитектур, Палеонтологи зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудаас аль аль төрөл нь байгааг сонгож зөвлөнө.
7. **Хамгаалалтын зэрэглэл:** Тухайн дурсгал улс, аймаг, нийслэлийн хамгаалалтын аль ангилалд хамаарахыг сонгож зөвлөнө.



8. **Дурсгалт газрын мэдээлэл:** Энэ хэсэгт дурсгалт газарт байрлаж буй дурсгалын ерөнхий байдал болон тоо хэмжээ, хамрах талбай, орон зайг товч тодорхойлон бичнэ.
9. **Дурсгалт газрыг гэрээгээр хариуцаж байгаа иргэн, аж ахуй нэгж байгаа эсэх:** Тухайн дурсгалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг, захиргааны нэгжээс гэрээ байгуулж иргэн, аж ахуйн нэгжид хариуцуулсан бол “Тийм” гэсэн нүдийг бөглөж арын хэсэгт тухайн иргэн, аж ахуйн нэгжийн нэр болон гэрээний дугаар, хүчинтэй хугацаа зэргийн дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ.
10. **Хашаа, хайстай эсэх:** Тухайн үл хөдлөх дурсгалыг гадны нөлөөллөөс хамгаалах хашаа, хайс хийсэн бол “Тийм” гэсэн нүдийг бөглөнө. Арын хүснэгтэд хашаа хайс барьсан он, төсөв, санхүүжүүлэгчийн мэдээллийг тодорхой бичнэ.
11. **Хашаа, хайс нь дурсгалд эрсдэл дагуулж буй эсэх:** Дурсгалыг хамгаалах зорилгоор босгосон хашаа хайс нь мал амьтан, салхи шуурга зэрэг байгалийн нөлөөгөөр унавал тухайн дурсгалдаа гэмтэл учруулахуйц нөхцөл байдал байгаа бол “Тийм” сонголтыг бөглөж холбогдох мэдээллийг бичнэ.
12. **Хашаа, хайс бүрэн бүтэн эсэх:** Дурсгалыг хамгаалах зорилгоор баригдсан хашаа хайс нь бүрэн бүтэн байгаа эсэхийг бичих. Хэрвээ хашаа хайс эвдэрч гэмтсэн бол энэ талаарх мэдээллийг бичнэ.
13. **Хаяг тайлбартай эсэх:** Тухайн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга, тайлбар, тэмдэглэгээг хийж байрлуулсан бол “Тийм” нүдийг сонгож арын хэсэгт тухайн хаяг тайлбар хийсэн он, иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг тодорхой бичнэ.
14. **Кадастрын хэмжилт хийсэн эсэх:** Тухайн дурсгалт газар мэргэжлийн аж ахуй нэгжээр кадастрын хэмжилт, зураглал хийлгэсэн бол “Тийм” нүдийг сонгож арын хэсэгт аж ахуй нэгжийн нэр хийсэн он сарыг тодорхой бичнэ.

15. **Кадастрын улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх:** Тухайн дурсгалт газар хийлгэсэн кадастрын хэмжилтийн мэдээллийг кадастрын улсын бүртгэл бүртгүүлсэн бол “Тийм” нүдийг сонгож арын хэсэгт тогтоол шийдвэрийн тоот, он сар, хамрах талбайн хэмжээг тодорхой бичнэ.
16. **Дурсгалт газрын хамрах хүрээний солбицол:** Тухайн дурсгалт газар болон дурсгал байрлаж буй нийт талбайг оруулан, гадна талаар хязгаарлалт үүсгэж хамрах хүрээг тодорхойлон. Ингэхдээ дурсгалт газар болон дурсгал байрлаж буй нийт талбайн захын солбицлыг бичнэ.

ХОЁР. Гэмтлийн мэдээллийн тайлбар (үсгийн дарааллаар)

1. **Дурсгалт газрын бүртгэлийн дугаар:** Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 2015 оны А/108 дугаар тушаалаар Улс орон даяар зохион байгуулагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллогын хүрээнд өгсөн бүртгэлийн дугаарыг бичнэ.
2. **Аж ахуйн нөлөөлөлд өртсөн эсэх:** Дурсгалт газрын зарим төрлийн дурсгалын чулууг ашиглан хашаа хороо барих, хадны зураг, бичээс бүхий дурсгалт газар малчид өвөлжөө, хаваржааны нөлөөлөлд өртөх, мөн суурин газар, зам дагуух байрлалтай дурсгалыг барилгын түүхий эд болгон ашиглах зэргээр эх төрх, бүрэн бүтэн байдлыг алдагдуулсныг хэлнэ.
3. **Биологийн бохирдолтой (Хаг, сангас, ургамал...г.м) эсэх:** ТСҮХД-д сөрөг нөлөөт хүчин зүйлсийн тоонд бичил биетэн, төрөл бүрийн ургамал, амьтны нөлөөгөөр хаг ургах, шувууны сангас болох, шавьж үүрлэх зэргийг хэлнэ.
4. **Будаж балласан (Хүний үйл ажиллагаа) эсэх:** ТСҮХД дээр хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй тосон будаг болон химийн найрлага бүхий өнгийн будгаар будаж баллахыг хэлнэ.



5. **Булшны дараас чулуу газрын хөрсөнд дарагдсан эсэх:** Тухайн дурсгалт газарт оршиж байгаа дурсгалууд байгалийн хүчин зүйлээс хамаарч дараас чулуун газрын хөрсөнд дарагдсаныг хэлнэ.
6. **Буруу сэргээн засварлалт:** Дурсгалыг эрдэм шинжилгээний судалгаагүй буюу материал болон хийгдсэн арга технологийг тодорхойлолгүйгээр эсвэл бодит бус судалгаанд үндэслэн тохиромжгүй материал, түүхий эд ашиглан, технологийн болон хэлбэр загвар, дүр дүрслэлийн хувьд алдаатай, дахин сэргээн засах боломжгүй арга, түүхий эд материал, бодис хэрэглэгдэхүүн ашиглан хийгдсэн ажлыг буруу сэргээн засварлалт гэнэ.
7. **Газар тариаланд өртсөн эсэх:** Хөдөө аж ахуй зорилгоор их хэмжээний талбайд нэгдсэн зохион байгуулалттайгаар газар хагалж тариа тариалах үйл ажиллагааг хэлнэ.
8. **Дэлгэрэнгүй мэдээлэл:** Тухайн хэсэгт гэмтлийн мэдээлэл цуглуулж буй дурсгалт газар, дурсгалын гэмтлийн талаар болон гэмтэл, эрсдэл үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар тодорхой бичнэ.
9. **Дурсгалт (олдворт) газраас элс шороо авсан эсэх:** Дурсгал тэр дундаа палеонтологийн олдворт газар, чулуун зэвсгийн дурсгалт газар болон үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан газар, палеонтологийн олдворт газраас зөвшөөрөлгүй түгээмэл тархацтай ашигт малтмал болох элс, хайрга, чулуу, шороо олборлохыг хэлнэ.
10. **Жуулчны баазтай ойр эсэх:** Дурсгал түүний ойр орчимд жуулчны бааз байгуулан, аяллын маршрутдаа оруулсан тохиолдлыг хэлнэ.
11. **Объектын түймэрт өртсөн эсэх:** Хүний буруутай үйл ажиллагаа, галын эрсдэлийн төлөвлөгөө, стандарт дүрэм зөрчсөн, хайхрамжгүй байдал зэргээс шалтгаалж дурсгалт барилгад үүсэх гал түймрийг хэлнэ.

- 12. Орон нутгийн чанартай замд өртсөн эсэх:** Дурсгалт газар дээгүүр, түүний ойр орчмоор шороон болон хатуу хучилттай авто зам дайран гарч дурсгалыг эвдэж сүйтгэснийг хэлнэ.
- 13. Өгөршсөн эсэх:** Дурсгал биологийн хүчин зүйл болон нар, салхи, бороо ус зэргээс үүдэж өгөршсөнийг хэлнэ.
- 14. Өөх, тос түрхсэн (Хүний үйл ажиллагаа) эсэх:** Дурсгал дээр тахилга шүтлэгийн холбогдолтой хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн өөх тос түрхэж бохирдуулахыг хэлнэ.
- 15. Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажиллагаа) эсэх:** Чулуун дурсгалууд дээр хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй сийлж, сүйтгэхийг хэлнэ.
- 16. Суурьшлын бүс газар олголтод өртсөн эсэх:** Хот, суурин газарт иргэн, хуулийн этгээдэд хууль, журмын хүрээнд, тодорхой төлөвлөгөөний дагуу олгосон газарт өртсөнийг хэлнэ.
- 17. Сүүлийн 5 жилд тоногдсон тухай мэдээлэл:** Тухайн дурсгалыг хууль бусаар ашиг, хонжоо олох зорилгоор дурсгалын эх төрх, бүрэн бүтэн байдлыг алдагдуулан эвдэж сүйтгэн ухаж тоносныг хэлнэ.
- 18. Ухагдсан, тоногдсон эсэх:** Хууль бусаар ашиг хонжоо хайх зорилгоор дурсгалыг ухаж, тоносныг хэлнэ.
- 19. Хагарал, цууралттай эсэх:** Дурсгалд хүний буруутай үйл ажиллагаа болон байгалийн хүчин зүйлээс хамаарч тухайн дурсгал хагарч, цуурсныг хэлнэ.
- 20. Хазайсан эсэх:** Тухайн дурсгал хүний буруутай үйл ажиллагаа болон байгалийн хүчин зүйлээс хамаарч хажуу тийш налж хазайсан, газарт унасан тохиолдлыг хэлнэ.
- 21. Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон эсэх:** Дурсгалд хүний буруутай үйл ажиллагаа болон байгалийн хүчин зүйлээс үүдэлтэй ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон тохиолдлыг хэлнэ.



22. Хог хаясан эсэх: ТСҮХД дээр болон түүний орчинд хүний буруутай үйл ажиллагаа, байгалийн хүчин зүйл үер усны нөлөөгөөр хог хаягдал хуримтлагдсаныг хэлнэ.

21. Хэв хуулбар, дардас, 3D баримтжуулалт: Тухайн дурсгалаас хадгалалт хамгаалалт, судалгааны зорилгоор холбогдох хууль, журмын хүрээнд тодорхой тоног төхөөрөмж ашиглан арга зүйн дагуу хэв хуулбар, дардас, 3D баримтжуулалт хийсэн тухай мэдээллийг хэлнэ.

22. Эрдэсжилтэй (Хадан дээр шохойжилт үүссэн) эсэх: ТСҮХД-ын төрөл зүйлээс чулуун дурсгалууд дээр эрдэсжилт шохойжилт үүссэн чулуу эрсдэлд орж хагарч хугарсан тохиолдлыг хэлнэ.

23. Эх төрх байдлыг алдагдуулсан эсэх: Тухайн дурсгал хүний буруутай үйл ажиллагаа болон байгалийн хүчин зүйлээс хамаарч гадаад зохион байгуулалт, эх төрх, бүрэн бүтэн байдал алдагдахыг хэлнэ.

ГУРАВ. Маягтыг бөглөх аргачлал:

1. Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн үл мөр бүхий дурсгалт газар:

Нэн эртний тодорхой цаг үед аж төрж байсныг гэрчлэх чулуун зэвсэг, түүнийг үйлдэж байсан чулууны үлдэц, галын ором, хоол хүнсний үлдэгдэл зэрэг хүний үйлдвэрлэл, суурьшлын үл мөр бүхий олдворт газрыг хэлнэ.

№	Гэмтлийн төрөл	Тайлбар
1.1	Дурсгалт газраас элс шороо авдаг эсэх:	Тухайн дурсгалт газраас элс шороо авах үйл ажиллагаа явагдаагүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
1.2	Газар тариаланд өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газарт газар тариалан эрхлэх үйл ажиллагаа явагдаагүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.

1.3	Орон нутгийн чанартай замд өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газар дээгүүр орон нутгийн чанартай зам дайрч гараагүй бол “Гэмтэлгүй”, харин дурсгалт газраар зам ямар нэг хэмжээгээр дайрсан байвал өртсөн талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
1.4	Суурьшлын бүс, газар олголтод өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газар суурьшлын бүс, газар олголтод өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
1.5	Жуулчны баазтай ойр эсэх:	Тухайн дурсгалт газраас 5 км-ээс хол зайд Жуулчны бааз байвал “Гэмтэлгүй”, харин дурсгалт газартай 5-3 км зайд байвал “10% хүртэл”, 3-1 км байвал “10-50% хүртэл”, 1 км ээс дотор “50% дээш” гэсэн сонголтыг хийнэ.
1.6	Хог хаясан эсэх:	Тухайн дурсгалт газарт ямар нэгэн хог хаяагүй бол “Гэмтэлгүй”, харин хог хаягдсан бол хогийн хэмжээг нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.

2. Хадны зураг, тамга, тэмдэг, бичгийн дурсгал: Байгалийн хад чулууны гадаргуу дээр ямар нэгэн тусгай багажийн тусламжтайгаар эртний хүмүүсийн аж байдал, ан гөрөө, нүүдэл суудал, дайн тулаан, шүтлэг бишрэл зэргийг араатан, жигүүртэн, тэрэг, зэр зэвсэг, тамга тэмдэг, хүний нүүр, баг, үйл хөдлөл зэргээр төлөөлүүлэн харуулсан зураг болон түүхийн олон үед хамаарах сийлмэл болон зос, бэхэн зураг, тамга тэмдэг болон бичээсийг хамруулна.

№	Гэмтлийн төрөл	Тайлбар
2.1	Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон эсэх:	Тухайн дурсгалт газарт ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон тохиолдол байхгүй бол гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.



2.2	Өгөршсөн эсэх:	Тухайн дурсгалт газарт өгөршсөн тохиолдол байхгүй бол гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээг харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
2.3	Хагарал, цууралттай эсэх:	Тухайн дурсгалт газарт хагарал, цуурал байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
2.4	Биологийн бохирдол (Хаг, сангас, ургамал...)	Тухайн дурсгалт газарт биологийн бохирдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
2.5	Эрдэсжилт (хадан дээр шохойжилт үүссэн):	Тухайн дурсгалт газарт эрдэсжилт байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
2.6	Өөх, тосны бохирдол (Хүний үйл ажиллагаа) эсэх:	Тухайн дурсгалт газарт өөх, тосны бохирдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
2.7	Будаж балласан (Хүний үйл ажиллагаа) эсэх:	Тухайн дурсгалт газарт будаж балласан тохиолдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
2.8	Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажиллагаа) эсэх:	Тухайн дурсгалт газарт сийлж сүйтгэсэн тохиолдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.

3. Хөшөө дурсгал (Буган чулуу, хүн чулуу, гэрэлт хөшөө): Түүхэн тодорхой цаг үед зан үйл, шүтлэг бишрэл, түүхэн тэмдэглэлт үйл явдалд зориулан босгосон түүх, урлагийн үнэ цэнэ бүхий бүх төрлийн хөшөө дурсгал хамаарна.

№	Гэмтлийн төрөл	Тайлбар
3.1	Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон эсэх	Тухайн дурсгалд газарт ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон тохиолдол байхгүй бол гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
3.2	Өгөршсөн эсэх:	Тухайн дурсгалт газарт өгөршил байхгүй бол гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
3.3	Хагарал, цууралттай эсэх:	Тухайн дурсгалт газарт хагарал, цуурал байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
3.4	Биологийн бохирдолтой (Хаг, сангас, ургамал...) эсэх	Тухайн дурсгалт газарт биологийн бохирдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
3.5	Эрдэсжилттэй (хадан дээр шохойжилт үүссэн) эсэх	Тухайн дурсгалт газарт эрдэсжилт байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.



3.6	Хазайсан эсэх:	Тухайн дурсгал огт хазайгаагүй бол “Гэмтэлгүй”, харин бага зэрэг хазайсан байвал “10% хүртэл”, хазайсан боловч газрын хөрсөн дээр унаагүй байвал “10-50% хүртэл”, газрын хөрсөн дээр хэвтээгээр унасан байвал “50% дээш” гэсэн үнэлгээг сонгоно.
3.7	Өөх, тосны бохирдол (Хүний үйл ажиллагаа) эсэх	Тухайн дурсгалт газарт өөх, тосны бохирдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
3.8	Будаж балласан (Хүний үйл ажиллагаа) эсэх:	Тухайн дурсгалт газарт будаж балласан тохиолдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
3.9	Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажиллагаа) эсэх	Тухайн дурсгалт газарт сийлж сүйтгэсэн тохиолдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
3.10	Буруу сэргээн засварлалт хийсэн эсэх	Тухайн дурсгалыг сэргээн засварлаагүй бол “Гэмтэлгүй”, харин дурсгалд ийм төрлийн үйл ажиллагаа хийсэн бол дурсгалын бүрэн бүтэн, эх төрхтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.

4. Булш оршуулга, тахил тайлгын дурсгал: Түүхэн тодорхой цаг үед хүмүүс талийгаач болсон хүний бие цогцсыг тусгай зан үйлийн дагуу, мод, чулуу, шороогоор дарж (хадны оршуулга) үйлдсэн бүх төрлийн эртний булш хамаарна. Тахил тайлгын байгууламж нь оршуулгын ёслол, хойд насанд зориулж эсвэл байгаль дэлхийгээ аргадах зорилгоор зан үйл гүйцэтгэн хийж бүтээсэн тахилыг байгууламжууд, түүний бүрдэл хэсгүүд болох хашлага, зэл чулуу, овоо зэрэг хамаарна.

№	Гэмтлийн төрөл	Тайлбар
4.1	Аж ахуйн нөлөөлөлд өртсөн эсэх	Тухайн дурсгалт газар аж ахуйн нөлөөлөлд өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт дурсгалын тоотой харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
4.2	Газар тариаланд өртсөн эсэх	Тухайн дурсгалт газар газар тариаланд өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
4.3	Ухагдсан, тоногдсон эсэх	Тухайн дурсгалт газарт тоногдсон дурсгал огт байхгүй бол “Гэмтэлгүй”, харин харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт дурсгалын тоотой харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
4.4	Хог хаясан эсэх:	Тухайн дурсгалт газарт ямар нэгэн хог хаяагүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол хогийн хэмжээг нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
4.5	Булшны дараас чулуу газрын хөрсөнд дарагдсан эсэх	Булшны дараас чулуу газрын хөрсөнд ямар нэг байдлаар дарагдаагүй бол “Гэмтэлгүй”, харин ийм байдал үүссэн бол нийт дурсгалын тоотой харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
4.6	Сүүлийн 5 жилд тоногдсон дурсгал	Тухайн дурсгалт газарт сүүлийн 5 жилд хууль бусаар тоногдсон булш оршуулгын дурсгалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтийн VII баганад байрлах хэсэгт, цаг хугацаа, тоон дүн, хэзээ хэнээс мэдсэн эсэх, сүм болон аймгийн хууль ёсны байгуулгад мэдээлсэн эсэх, шалгалт явуулсан эсэх зэргийг тодорхой тэмдэглэнэ.



5. Барилга, архитектурын дурсгал: Түүхэн тодорхой цаг үед хүмүүс урт хугацаагаар суурьшин барьж байгуулсан эртний хот, хэрэм (суваг, шуудуу)-ийн үлдэгдэл болон барилга байшин, суварга, сүм хийдийн туурь, архитектурын дурсгал (сүм хийд, уран барилга, түүхийн дурсгалт байшин, баримал, хөшөө, сүрлэг чимэглэлийн дүрслэл г.м) зэрэг хамаарна.

№	Гэмтлийн төрөл	Тайлбар
5.1	Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон	Тухайн дурсгалд ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон тохиолдол байхгүй бол гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт байгууламжийн тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.2	Өгөршсөн эсэх:	Тухайн дурсгалд өгөршсөн тохиолдол байхгүй бол гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт байгууламжийн тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.3	Хагарал, цууралттай эсэх:	Тухайн дурсгалд хагарал, цууралт огт ажиглагдахгүй байвал гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин дурсгалт газарт ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.4	Биологийн бохирдол (Хаг, сангас г.м)-тай эсэх:	Тухайн дурсгалд биологийн бохирдол огт ажиглагдахгүй байвал гэмтэлгүй буюу “Гэмтэлгүй”, харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт байгууламжийн тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.5	Аж ахуйн нөлөөлөлд өртсөн эсэх:	Тухайн дурсгалд аж ахуйн нөлөөлөлд өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол байгууламжийн бүрэн бүтэн байдалтай нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.

5.6	Буруу сэргээн засварлалт хийсэн эсэх:	Тухайн дурсгалыг сэргээн засварлаагүй бол “Гэмтэлгүй”, харин дурсгалд ийм төрлийн үйл ажиллагаа хийсэн бол дурсгалын бүрэн бүтэн, эх төрхтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.7	Газар тариаланд өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газар тариаланд өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол байгууламжийн тоо хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.8	Объектын гал түймэрт өртсөн эсэх:	Тухайн дурсгал объектын түймэрт өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм тохиолдол байгаа бол нийт байгууламжийн тоо, хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.9	Эх төрх байдлыг алдагдуулсан эсэх:	Тухайн дурсгал эх төрх байдлыг алдагдуулаагүй бол “Гэмтэлгүй”, харин ийм тохиолдол байгаа бол нийт дурсгалын бүрэн бүтэн, эх төрхтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.10	Будаж балласан (Хүний үйл ажиллагаа) эсэх	Тухайн дурсгалыг будаж балласан тохиолдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол дурсгалын бүрэн бүтэн, эх төрхтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
5.11	Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажиллагаа)	Тухайн дурсгалд сийлж сүйтгэсэн тохиолдол байхгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол дурсгалын бүрэн бүтэн, эх төрхтэй харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.



6. Палеонтологийн олдворт газар: Палеонтологийн олдворт газрыг түүхэн хөгжлийн он дарааллаар, хронометрийн аргаар эртний үеэс хожуу үе рүү шатлан ангилж судалдаг. Хроностратиграф (аливаа хурдас чулуулгийг нас, тэдгээрийн цаг хугацааны харьцааг судалдаг стратиграфийн салбар) -ийн аргаар геологийн цаг хугацааг Эон, Эрин, Галав, Галчин, Зуун, Хрон гэсэн нэгжүүдэд хувааж олдворт газруудыг энэхүү аргаар системчлэн ангилдаг байна.

№	Гэмтлийн төрөл	Тайлбар
6.1	Аж ахуйн нөлөөлөлд өртсөн эсэх:	Тухайн олдворт газар аж ахуйн нөлөөлөлд өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт олдворт газрын хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
6.2	Газар тариаланд өртсөн эсэх:	Тухайн олдворт газарт газар тариалан эрхлэх үйл ажиллагаа явагдаагүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
6.3	Орон нутгийн чанартай замд өртсөн эсэх:	Тухайн олдворт газар дээр орон нутгийн чанартай зам дайрч гараагүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаанд өртсөн бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
6.4	Сүүрьшлын бүс, газар олголтод өртсөн эсэх:	Тухайн олдворт газарт сүүрьшлын бүс, газар олголтод өртөөгүй бол “Гэмтэлгүй”, харин ийм үйл ажиллагаанд өртсөн бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.
6.5	Жуулчны баазтай ойр эсэх:	Тухайн дурсгалт газраас 5 км ээс хол зайд Жуулчны бааз байвал “Гэмтэлгүй”, харин дурсгалт газартай 5-3 км зайд байвал “10% хүртэл”, 3-1 км байвал “10-50% хүртэл”, 1 км ээс дотор “50% дээш” гэсэн сонголтыг хийнэ.
6.6	Хог хаясан эсэх:	Тухайн дурсгалт газарт ямар нэгэн хог хаяагүй бол “Гэмтэлгүй”, харин хог хаягдсан бол хогийн хэмжээг нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан “10% хүртэл”, “10-50% хүртэл”, “50% дээш” сонголтуудаас тохирохыг сонгоно.

Гэмтлийн мэдээллийн тоон дүнг нэгтгэх, үнэлэх аргачлал:

Гэмтлийн мэдээллийн асуулга тус бүр дээр тэмдэглэгдсэн сонголтыг нэгтгэх байдлаар үнэлгээг хийнэ. Тухайлбал гэмтлийн мэдээллийн

- Гэмтэлгүй бол 0 оноо,
- 10 хүртэл хувийн 1 сонголт 1 оноо,
- 10-50 хүртэл хувийн 1 сонголт 2 оноо,
- 50% дээш хувийн 1 сонголт 3 онооны сонголт тус бүрийн нийлбэрээр тухайн дурсгалын гэмтлийн мэдээллийг 4 сонголтоор үнэлнэ.

Жишээ нь 10% хүртэл багана дээр 4 сонголт хийгдсэн бол 1 тус бүрээр тоолж нэгдсэн дүнгийн хэсэгт 4, 10-50% хүртэл багана дээр 4 сонголт хийгдсэн бол 1 сонголтыг 2 гэж тоолж нэгдсэн дүнгийн хэсэгт 8, 50% дээш багана дээр 4 сонголт хийгдсэн бол 1 сонголтыг 3 гэж тоолж нэгдсэн дүнгийн хэсэгт 12 гэх мэт нэгтгэж төрөл тус бүрийн гэмтэлийн мэдээллийн доор байгаа онооны үнэлгээнээс (□ 0-4 Сайн; □ 5-9 Дунд; □ 10-14 Муу; □ 15-18 Маш муу) сонголт хийж үнэлгээг гаргана.



II.5. ТООЛЛОГЫН ДЭВТЭР ХӨТЛӨХ

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын дэвтэр нь аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт орших дараах түүх, соёлын дурсгалын мэдээллээс бүрдэнэ. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоол, 2021 оны 179 дүгээр тогтоолоор тус тус “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д батлагдсан;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалаар “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д батлагдсан;
- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн “RICH 3.0 программд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ын жагсаалт.

Дээрх мэдээллийг тооллогын дэвтэрт тухайн аймгийн нийт сумдын нэрсийг цагаан толгойн үсгийн дагуу дугаарлан, сумын нутаг дэвсгэрт орших дурсгалыг Улсын хамгаалалтад байх, Аймгийн хамгаалалтад байх, RICH 3.0 программд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэсэн дарааллаар хэвлэв.

Дэвтрийг Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журмын 4.1-т заасны дагуу Улсын комиссын даргын гарын үсэг, тамга болон тооллого зохион байгуулагдаж буй оны сүүлийн 2 орон, 21 аймаг, нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код бүхий дугаараар тус тус баталгаажуулсан болно.

Дэвтэрийн жагсаалтад орсон дурсгал тус бүр дээр 9 асуулга бөглөнө. Үүнд:

1. **Дэс дугаар хэсэг:** Дэвтэрт орсон нийт дурсгалын дэс дугаар байх бөгөөд ямар нэгэн засвар, өөрчлөлт хийхгүй.

2. **Дурсгалт газрын бүртгэлийн дугаар хэсэг:** Тооллогын дэвтэрт орсон нийт дурсгалын бүртгэлийн дугаар байх бөгөөд Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоол, 2021 оны 179 дүгээр тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалаар эрх зүйн хамгаалалтад шинээр орж, RICH 3.0 программд бүртгэгдээгүй дурсгалууд дугаар бичигдээгүй байгаа тул, энэ удаагийн тооллогоор өгсөн бүртгэлийн дугаарыг нөхөж бичиж программд оруулна.
3. **Дурсгалт газрын нэр хэсэг:** Тухайн дурсгалт газрын нэрийг өмнө нь буруу тэмдэглэсэн бол залруулж бичих, программд оруулах.
4. **Дурсгалын төрөл зүйл хэсэг:** Дурсгалын төрөл, зүйлийн сонголт байгаа бөгөөд өмнө нь буруу, ташаарсан бол залруулж бичих, программд оруулах.
5. **Дурсгалын төрөл зүйлийн бүрдэл хэсэг:** Тухайн дурсгалт газарт олон үеийг хамрах, олон төрлийн дурсгал байвал тус бүрд нь бичих.
6. **Тоо ширхэг:** Тухайн дурсгалт газарт байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоо ширхгийг үнэн зөв бичих.
7. **Газар зүйн байршил (солбицол) хэсэг:** Өмнөх тооллогоор буруу тэмдэглэгдсэн солбицлыг засах, Улс, аймаг, нийслэл, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас программд бүртгэлгүй дурсгалын солбицлыг заавал нөхөж оруулах,
8. **Тэмдэглэл хэсэгт:** Тухайн дурсгалт газарт тооллогын ажлын хүрээнд засаж сайжруулсан, нөхөж бүртгэсэн эсэх талаарх мэдээллийг товч бичих.
9. **Тоологдсон эсэх, огноо хэсэгт:** Тооллого хийсэн бол тоолов гээд он сар өдрийг үнэн зөв тэмдэглэж бичих.

Тухайн сумын дурсгалын жагсаалт дуусахад бүртгэл хийсэн мэргэжилтэн өөрийн мэдээллийг бөглөнө.



Дэвтрийн төгсгөлд баталгааны хуудас хэсэгт: Тухайн аймаг нийт хэдэн сумын нутагт байх хэдэн дурсгалт газрын хэдэн дурсгал тоолохоос хэдэн дурсгалт газрын хэдэн дурсгал тоологдсон, тодорхой шалтгааны улмаас тооллогод хамрагдаж чадаагүй бол хэдэн дурсгалт газрын хэдэн дурсгал тоологдоогүйг үнэн зөв бичиж тэмдэглэнэ.

Салбар комиссын дарга, нарийн бичгийн дарга болон гишүүд гарын үсэг зурж улсын комисст хүргүүлнэ.

 **СОЁЛЫН ЯАМ**

 **ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРГЭЛЭЛЭГЧИЙН АГЕНТБАР
СОЁЛ, УНГАГИЙН ГАЗАР**

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДҮРСГАЛЫН УЛСЫН ТООЛЛОГЫН ДЭВТЭР
(2022 ОН)

АЙМГИЙН НЭР: АРХАНГАЙ

Эхэлсэн огноо:.....
Дууссан огноо:.....

Тооллогын ажлыг зохион байгуулж эхэлсэн болон дууссан огноог гараар бичнэ.

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДҮРСГАЛЫН УЛСЫН ТООЛЛОГЫН ДЭВТЭР
(2022 ОН)

АЙМГИЙН НЭР: АРХАНГАЙ

Дэвтрийн дугаар: 2265

УЛСЫН КОМИССЫН ДАРГА  Т.ЭХЕБАТ (СОЁЛЫН БӨИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ)

Тооллого зохион байгуулагдаж буй оны сүүлийн хоёр орон, монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код

Улсын комиссын дарга гарын үсэг зурж тамга дарж хүчин төгөлдөр болно.

Figure 170

Улс, аймаг,
нийслэлийн
хамгаалалтад байх
түүх, соёлын үл хөдлөх
дурсгалыг бүртгэлийн
програмд заавал
бүртгэсэн байх.

Бүртгэл хийсэн: _____ Нийт _____ дурсгалт газрын _____ түүх, соёлын үн хадгалах дурсгал тоолно.

(доош нэр) (гарын үсэг) (агбан тусламж)

188





III БҮЛЭГ

**ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ
ДУРСГАЛЫН ТООЛЛОГЫН
ТАЙЛАН БИЧИХ ТУХАЙ**





III.1. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН УЛСЫН ТООЛЛОГЫН АЖЛЫГ ТАЙЛАГНАХ ТУХАЙ

Тооллогын ажлыг тайлагнах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт дахь “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/14 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын удирдамж”-д тус тус заасан байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын тайлан нь тушаал, удирдамж, төлөвлөгөө зэрэг зохион байгуулалтын баримт бичиг, тооллого явуулсан тухай илтгэх хуудас, тооллогын үйл явц, тоон дүн мэдээ, тооллого зохион байгуулсан дүгнэлт, санал зэрэг үндсэн мэдээлэл, холбогдох хавсралтуудаас тус тус бүрдэнэ.

Тайланг бичихдээ Архив албан хэрэг хөтлөлтийн MNS 5140-2:2021 стандартыг баримтлан, илгээхдээ архив бичиг хэргийн хадгалалтын горимын дагуу хатуу хавтсаар хавтаслан, хуудсыг салахааргүй нааж, үдэж бэхэлсэн байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын ажлын дүнг тайлагнахдаа “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-ын 6.1-6.5 хүртэлх заалт, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын удирдамж”-ийн 3.1-3.4 хүртэлх заалт, дор дурдсан зөвлөмжийг удирдлага болгоно.

НЭГ. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын тайлангийн бүрдэл

- ♦ Нүүр
- ♦ Дотоод товъёг
- ♦ 1.1 дэх хэсэг
- ♦ 1.2 дахь хэсэг

- ♦ 1.3 дахь хэсэг
- ♦ Хавсралт

1.1. Зохион байгуулалтын баримт бичиг

- ♦ Салбар комиссыг байгуулсан тухай тушаал, захирамж,
- ♦ Тооллого явуулахад баримтлан ажилласан зохион байгуулалт, комиссын гишүүдийн ажлын чиг үүрэг, ажлын төлөвлөгөө,
- ♦ Салбар комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой мэдээлэл, шийдвэр,
- ♦ Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны тухай,
- ♦ Салбар комиссын ажлын тухай (аль суманд, хэдий хугацаанд ажилласан, хөтөлсөн протокол, тэмдэглэл г.м),
- ♦ Бусад нэмэлт мэдээлэл г.м

1.2. Үйл явц буюу илтгэх хуудас

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёлын урлагийн газрын даргын баталсан Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын удирдамжид заасан үйл ажиллагааг зохион байгуулсан талаарх мэдээллийг бичнэ. Илтгэх хуудсанд:

- ♦ Тооллогын үйл явц, зохион байгуулалттай холбоотой мэдээлэл (Ямар хугацаанд ямар маршрутаар, ямар бүрэлдэхүүнтэй, хэрхэн явсан г.м),
- ♦ Тооллогын ажилд зарцуулсан хөрөнгө, санхүүгийн мэдээлэл,
- ♦ (Үзлэг, тооллогод зарцуулсан улс, аймаг, сум, албан байгууллага, хувь хүнээс мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр г.м) мэдээлэл,
- ♦ Тооллогод хамрагдсан дурсгалын ерөнхий мэдээлэл зэрэг тус тус заавал орно.



1.3. Дүгнэлт, санал

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёлын урлагийн газрын даргын баталсан Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын удирдамжийн 3.1 дэх хэсэгт заасан мэдээллийг дараах байдлаар ангилан, хүснэгтийн дагуу ирүүлнэ. Үүнд:

- Тооллогод хамрагдсан нийт дурсгалын мэдээлэл /Хүснэгт 1,2-ыг бөглөх/
- Тооллогод хамрагдсан дурсгалын хадгалалт хамгаалалтын мэдээлэл /Хүснэгт 3,4,5,6,7-г тус тус бөглөх/
- Тооллогод хамрагдсан нийт дурсгалын эвдрэл гэмтлийн мэдээлэл /Хүснэгт 8,9,10,11,12-г тус тус бөглөх, дурсгалын эвдрэл гэмтлийн тоон дүнг RICH 4.0 программаас үндсэн мэдээллийг бөглөж, нэгтгэхийг анхаарна уу/

Хүснэгт 1. Тооллогод хамрагдсан нийт дурсгалын тоон дүн, төрөл зүйл.

№	Төрөл	Дурсгалт газрын тоо	Дурсгалын тоо
1	Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн үл мөр бүхий дурсгалт газар		
2	Хадны зураг, тамга, тэмдэг, бичгийн дурсгал		
3	Хөшөө дурсгал (Буган чулуу, хүн чулуу, гэрэлт хөшөө)		
4	Булш оршуулга, тахил тайлгын дурсгал		
5	Барилга, архитектурын дурсгал		
6	Палеонтологийн олдворт газар		
Нийт			

Хүснэгт 2. Өмнөх тооллогын бүртгэлд залруулга хийсэн мэдээлэл, тоон дүн.

№	Өөрчлөлт орсон шалтгаан	Дурсгалт газрын тоо	Дурсгалын тоо
1	Дурсгалт газрын нэр, нэршлийн залруулга		
2	Дурсгалт газрын засаг захиргааны нэгжийн залруулга		
3	Дурсгалын төрөл зүйлийн залруулга		
4	Дурсгалын тоон дүнгийн залруулга		
5	Дурсгалын газарзүйн байршлын залруулга		
6	Бусад (.....		
Нийт			

Хүснэгт 3. Хашаа, хайсаар хамгаалагдсан дурсгалын тоон дүн.

№	Дурсгалын оршин байгаа засаг захиргааны нэгжийн нэр	Дурсгалт газрын нэр	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1						
2						
3						
	Нийт					



Хүснэгт 4. Дурсгалыг гэрээгээр хариуцаж байгаа иргэн, аж ахуй нэгжийн тоон дүн.

№	Дурсгалын оршин байгаа засаг захиргааны нэгжийн нэр	Дурсгалт газрын нэр	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг	Гэрээт харуулын нэр
1							
2							
3							
	Нийт						

Хүснэгт 5. Кадастрын хэмжилт хийсэн дурсгалын төрөл, зүйл тоон дүн

№	Дурсгалын оршин байгаа засаг захиргааны нэгжийн нэр	Дурсгалт газрын нэр	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1						
2						
3						
	Нийт					

Хүснэгт 6. Газрын кадастрын системд бүртгэгдсэн дурсгалт газрын төрөл, тоон дүн

№	Дурсгалын оршин байгаа засаг захиргааны нэгжийн нэр	Дурсгалт газрын нэр	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1						
2						
3						
	Нийт					

Хүснэгт 7. Хаяг тайлбартай дурсгалт газрын төрөл, тоон дүн

№	Дурсгалын оршин байгаа засаг захиргааны нэгжийн нэр	Дурсгалт газрын нэр	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1						
2						
3						
	Нийт					

Хүснэгт 8. Биологийн бохирдолтой (Хаг сангас, ургамал...)

дурсгалын тоон дүн

№	Засаг, захиргааны нэгж	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1					
2					
3					
	Нийт				

Хүснэгт 9. Өөх, тосны бохирдолтой (Хүний үйл ажилагаа)

дурсгалын тоон дүн

№	Засаг, захиргааны нэгж	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1					
2					
3					
	Нийт				



*Хүснэгт 10. Будагж балласан (Хүний үйл ажиллагаа)
дурсгалын тоон дүн*

№	Засаг, захиргааны нэгж	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1					
2					
3					
	Нийт				

*Хүснэгт 11. Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажиллагаа)
дурсгалын тоон дүн*

№	Засаг, захиргааны нэгж	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1					
2					
3					
	Нийт				

*Хүснэгт 12. Ухагдаж тоногдсон (Хүний үйл ажиллагаа)
дурсгалын тоон дүн*

№	Засаг, захиргааны нэгж	Дурсгалын нэр	Төрөл зүйл	Солбицол	Тоо ширхэг
1					
2					
3					
	Нийт				

Санал:

- Тооллогоор ямар үр дүнд хүрсэн тухай, хүндрэл, бэрхшээл г.м
- Тооллогын мөрөөр цаашид авах арга хэмжээний санал байж болно.

Хавсралт:

- Хаягжилтын зураг,
- Хашаа хайсны зураг,
- Ажлын явцын зураг г.м баталгаажуулах мэдээллийг оруулна.

Бусад:

- Тооллогын тайланг цаасан болон цахим хэлбэрээр СӨУНБМСанд илгээнэ.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёлын урлагийн газрын даргын баталсан Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын удирдамжийн 2.15-д заасан тооллогын явц, зохион байгуулалтын танилцуулга бүхий дүрс бичлэгийг CD-д хуулан цаасан тайланд хавсарган ирүүлнэ.
- Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан хадгаламжийн нэгж үүсгэн хадгална.

ХОЁР. Тайлангийн бичвэрт тавигдах техник шаардлага:

1. Үсгийн фон: Arial,
2. Үсгийн хэмжээ: 12-11pt, хүснэгтэн мэдээллийн үсгийн хэмжээ 10-8 pt,
3. Бичвэрийн хэсэг: урдаас 3 см, хойноос 1.5 см, дээрээс 2 см, доороос 2 см байна.
4. Хөндлөн хүснэгтийн толгойг үдэх тал руу харуулна.
5. Хавсралт зураг бүр нь зургийн дугаар, тайлбартай байна.
6. Тайлангийн хавтасны гадна талд ямар нэгэн бичвэр бичихгүй.
7. Тайлангийн эхний хуудас нь нүүр байна. Нүүрний дээд хэсэгтаймгийн Соёл, урлагийн газар, дунд хэсэгт




“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын тайлан”
.....аймаг, доод хэсэгт “Аймгийн нэр, 2022 он” гэж
бичнэ.

8. Бичмэл тайланг албан бичгээр ирүүлнэ.



ХАВСРАЛТ

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ
ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН
ТӨРӨЛ ЗҮЙЛ



№		Төрөл зүйл	
1	1. Чулуун зэвсгийн дурсгалт газар	1.1 Палеолит	
		1.2 Мезолит	
		1.3 Неолит	
		1.4 Хүний сууж байсан оромж, сууц, агуй	
		1.5 Бусад	
2	2. Хадны зураг, бичгийн дурсгал	2.1 Сийлмэл зураг	
		2.2 Зос, бэхэн зураг	
		2.3 Тамга, тэмдэг, бичгийн дурсгал	
			2.3.1 Түрэг
			2.3.2 Уйгур
			2.3.3 Кидан
			2.3.4 Монгол
			2.3.5 Тод
			2.3.6 Дөрвөлжин
			2.3.7 Манж
			2.3.8 Согд
			2.3.9 Араб
			2.3.10 Перс
			2.3.11 Санскрит
			2.3.12 Төвд
			2.3.13 Хятад
			2.3.14 Бусад
3	3. Булш оршуулгын дурсгал	3.1 Неолитын булш	
		3.2 Шоргоолжин булш	
		3.3 Хиргисүүр	
		3.4 Дөрвөлжин булш	
		3.5 Пазырык булш	
		3.6 Хүннү булш	
		3.7 Түрэг булш	
		3.8 Уйгур булш	
		3.9 Хятан булш	
		3.10 Монгол булш	
		3.11 Хадны оршуулга	
		3.12 Бусад	
4	4. Тахил тайлгын байгууламж	4.1 Тахилын онгон	
			4.1.1 Балбал (зэл чулуу)
			4.1.2 Хашлага чулуу
		4.2 Тахилын сүмийн туурь	
		4.3 Шивээ	
		4.4 Овоо	
		4.5 Бусад	

5	5.Барилга, архитектурын дурсгал	5.1 Суурьшлын үл мөр бүхий газар
		5.2 Эртний хот
		5.2.1 Хүннү
		5.2.2 Түрэг
		5.2.3 Уйгур
		5.2.4 Кидан
		5.2.5 Монгол
		5.2.6 Манж
		5.2.7 Тодорхойгүй
		5.3 Хэрмэн зам
		5.4 Шуудуу
		5.5 Сүм хийдийн туурь
		5.6 Суврага
		5.7 Түүхэн дурсгалт байшин
		5.8 Агуй, оромж, түр сууц
		5.9 Архитектурын дурсгал
		5.9.1 Уран барилга
		5.9.2 Уран барилгын цогцолбор
		5.9.3 Сүм хийд
		5.9.4 Уран баримал, хөшөө (1921-1990 он)
		5.9.5 Сүрлэг чимэглэлийн дүрслэл
6	6. Хөшөө дурсгал	5.10 Бусад
		6.1 Буган чулуун хөшөө
		6.2 Хүн чулуу
		6.2.1 Хүрэл
		6.2.2 Түрэг
		6.2.3 Уйгур
		6.2.4 Кидан
		6.2.5 Монгол
		6.2.6 Тодорхойгүй
		6.3 Тамга тэмдэгтэй хөшөө чулуу
		6.4 Гэрэлт хөшөө
		6.5 Амьтны дүрслэлтэй хөшөө
		6.6 Цулгүй хөшөө
		6.7 Бусад
7	7.Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар	7.1 Төмөрлөг боловсруулалтын үл мөр
		7.2 Шавар боловсруулалтын үл мөр
		7.3 Газар тариалангийн үл мөр
		7.4 Чулуу олзворлолтын үл мөр



АШИГЛАСАН НОМ БҮТЭЭЛ:

- ♦ **Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал** (Сэдэвчилсэн лавлах). Улаанбаатар, 1999.
- ♦ **Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт.** Үндэсний семинар. Редактор: Д.Цэвээндорж, Н.Уртнасан. Улаанбаатар, 2008.
- ♦ **Соёлын өвийг гэрэл зургаар баримтжуулах нь** (Гарын авлага). Эмхэтгэсэн: П.Чинбат, Б.Алтансүх, Б.Отгон, Хянан тохиолдуулсан: Г.Энхбат, М.Цэцэнбилэг. Улаанбаатар, 2020.
- ♦ **Түүх соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад.** Бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, соёлын ажилтнуудад зориулсан гарын авлага. Эмхтгэж, хянасан: Ц.Цэндсүрэн. Улаанбаатар, 2008.
- ♦ **Түүх соёлын үл хөдлөх дурсгалын байршил тогтоох, GPS ашиглах, хэмжилт хийх, DRONE-ний хэрэглээ** (Гарын авлага). Эмхэтгэсэн: С.Баасандорж, Хянан тохиолдуулсан: Г.Анхсанаа. Улаанбаатар, 2021.
- ♦ **Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын бүртгэлийн RICH 3.0 програмын гарын авлага.** Улаанбаатар, 2014.
- ♦ **Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах.** Эмхэтгэсэн: Г.Энхбат, Г.Анхсанаа. Улаанбаатар, 2017.
- ♦ **Эрдэнэбат У. Археологийн үндэс судалгааны арга зүй** (Сурах бичиг). Улаанбаатар, 2012.